Expert

2026.07 Дугаар 08

06
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир:
СОР-17 МОНГОЛ УЛСЫН МАНЛАЙЛЛЫГ ДЭЛХИЙД ХАРУУЛАХ ТҮҮХЭН БОЛОМЖ

22
Онлайн хэлэлцүүлэг
УИХ-ЫН ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГА

ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙ БҮРДҮҮЛЭХ НЬ

ХҮНДЭЭ ЭЭЛТЭЙ ХОТ ТӨЛӨВЛӨЛТ БА ХҮНИЙ ЭРХ

МОНГОЛ УЛСЫН 35 ДАХЬ ЕРӨНХИЙ САЙД Н.УЧРАЛ

#ЧӨЛӨӨЛЬЕ

ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ДӨРВӨН ЗАМ, ДӨРВӨН БОДЛОГО


ШИНЭ ҮЕИЙН УДИРДАГЧДЫН НУУЦ ЗЭВСЭГ: ХУВЦАСЛАЛТЫН СЭТГЭЛ ЗҮЙ

Хүний тархи бусдыг харахдаа ердөө **0.1** секундэд анхны сэтгэгдлийг бүрдүүлдэг. Принстоны их сургуулийн судалгаагаар хүмүүс анхны сэтгэгдлээ боловсруулах хугацаанд төрсөн дүгнэлтдээ хугацаа өнгөрөх тусам улам бүр бат итгэдэг болохыг баталжээ. Гадаад төрхийн дүгнэлтэнд энэхүү **"Halo Effect"** буюу далд итгэлцэл нь таны өндөр зэрэглэлийн дүр төрхөөс үүдэж, таны ур чадвар, найдвартай байдлыг ч мөн адил шууд өндрөөр үнэлэх суурь болдог байна.

Шинэ үеийн залуу удирдагчид энэ шалтгаанаар хувцаслалтандаа өндөр ач холбогдол өгч, сонгодог хослолын хэв маягийг өөрийн зан чанар, амбиц, алсын хараатай уялдуулан илэрхийлэх стратегийн чухал хэрэгсэл хэмээн тодорхойлж байна. Тэдний хувьд гадаад дүр төрх болон биеээ зөв авч явах байдал нь бизнес, улс төрийн талбарт хамгийн түрүүнд, чухлаар ажиглагдах сэтгэл зүйн хөшүүрэг юм.



10 ЖИЛИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВ: ГАДААД ТӨРХДӨӨ АНХААРДАГ ХҮМҮҮС БОЛОН ДУНДАЖ АЖИЛТНЫ ЦАЛИНГИЙН ӨСӨЛТИЙН ХАРЬЦУУЛАЛТ



Энэхүү зорилго, ухамсартай хувцаслалтын сэтгэл зүйг "Enclothed Cognition" хэмээдэг бөгөөд энэ нь өмссөн хувцас, биеэ хэрхэн авч явахтай шууд холбоотойгоор таны сэтгэл зүйд бодож сэтгэх дэвшил, хөгжил болон өөртөө итгэх дүр төрхийг авчирдаг байна. Төгс эсгүүртэй, үнэ цэнтэй хослол өмсөх мөчид хүн аяндаа илүү төвлөрсөн, шийдэмгий байдалруу цаанаасаа бие физиологийн хувьд шилждэг бөгөөд энэхүү давуу тал нь хэлэлцээрийн ширээний ард стратегийн далайцтай сэтгэх, эрсдэлээс үл эмээх хүчирхэг удирдагчийн зан төлөвийг сууриар нь бүрдүүлдэг.

Шинэ үеийн удирдагчдын хувьд өөртөө зориулсан дээд зэрэглэлийн хослол өмсөх нь зүгээр ч нэг тансаглал биш бөгөөд энэ нь өөртөө хийх хамгийн өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалт юм. Энэхүү зөв, өөрт яг таарсан хувцаслалтын дүр төрх нь таныг өдөр тутмын жижиг асуудлуудаас ангид байлгаж, зорилгодоо хүрэхэд нь анхны тулгуур болох сэтгэл зүйн хурдасгуур болдог бөгөөд бизнесийн алсын хараг илүү томоор, зоримог харах дотоод эрх чөлөөг олгодог. Хувцаслалт бол дэлхий ертөнцөд өөрийгөө танилцуулахаас өмнөх, өглөө бүр толины өмнө өөртөө өгч буй хамгийн хүчтэй амлалт билээ.



PREMIER TAILOR · YOUR OWN SUCCESS

ОНЦЛОХ



Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд
Ц.САНДАГ-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН МАНЛАЙЛЛЫГ ДЭЛХИЙД ХАРУУЛАХ ТҮҮХЭН БОЛОМЖ

06



Ерөнхий сайд
Н.УЧРАЛ

САНААЧИЛГА, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ДӨРВӨН ЗАМ, ДӨРВӨН ЧӨЛӨӨЛӨЛТИЙН БОДЛОГОО ХЭРЭГЖҮҮЛНЭ

12

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Ёс зүйн дэд хороо

УИХ-ын ёс зүй, сахилга хариуцлага 22


Авлигатай тэмцэх газар

Шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүй бүрдүүлэх нь 29

Эмнести интернэйшнл НҮТББ

Хүндээ эзэлтэй хот төлөвлөлт ба Хүний эрх 38

ЭРЧИМ



УИХ-ын гишүүн
Д.ҮҮРИЙНТУЯА

ТӨСВИЙН БОДЛОГОО БИЧИЛ БИЗНЕСИЙГ ХӨГЖҮҮЛЭХЭД ЧИГЛҮҮЛБЭЛ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ АЙЛ БОЛГОНЫ ХААЛГААР ОРНО

47

Expert

Expert сэтгүүлийг "Вип Эксперт" ХХК-иас эрхлэн гаргав.

Чингэлтэй дүүрэг, Жуулчны гудамж 4/4, Макс цамхаг, Монгол Улс

info@expert.mn
www.Vip76.mn

Утас: 701-22-701

Эрхлэгч: Б.Уугантуяа
Редактор: Ц.Соёлмаа
Б.Хонгорсайхан
Б.Цэцэгсүрэн
А.Сэвжид
Хамтран ажиллах: Г.Дэлгэрмаа, Ц.Нямдорж (8032-7678, 8031-7678)
Зураглаач: Б.Одончимэг
Дизайнер: Э.Бадрал, Д.Баттөр

ЭКСПЕРТ



Д.Ерөө
Монгол менежерүүд глобал түвшинд манлайлал үзүүлэхэд сэтгэлгээний хөгжил дутагдаж байна 52



М.Нандин-Эрдэнэ
Нобелийн шагналтан болж чадахгүй бол Нобелийн шагналтныг төрүүлж яагаад болохгүй гэж... 54



О.Батчулуун
“Багахангай-Хөшигийн хөндий-Эмээлт” чиглэлийн төмөр зам түгжрэлийг бууруулж, тээврийн шинэ гарцыг нээнэ 57



Э.Уганбаяр
Иргэдийн аюул, эрсдэлгүй амьдралын төлөө төрийн байгууллага, иргэд, ААН бүр хамтран зүтгэвэл үр дүнд хүрнэ 61



Д.Бумдарь
Манай улс парламентат ёсны төлөвшлөөр дэлхийн улс орнуудын тэг дунд байна 64



Б.Баттогтох
Татварын хуулийг дан ганц нэмэлт өөрчлөлтөөр бус багцаар нь дахин системчлэх шаардлагатай 66

БАТЛАГДСАН ХУУЛИУД

18 нас хүрсэн иргэнд скүүтер, мопедоор зорчихыг зөвшөөрөхөөр хуульчлав 68

Шинжлэх ухааны салбар их өгөгдлийн сантай болсноор эдийн засгийн эргэлт сайжирна 70

“Халамжаас - хөдөлмөрт” бодлогын хөдөлгөгч хүч нийгмийн ажилтан мэргэжил “дархлагдлаа” 72

Нэг амьгүй донор 8 хүний амь нас аврах боломжтой 74

Монгол улс гэмт хэрэгтэй “коммунист”-аар тэмцэж ирснээ хүлээн зөвшөөрч “тогтоол” баталлаа! 76

Казахстан улсад ажиллаж, амьдарч байсан иргэд өөрийн улсдаа тэтгэвэр тогтоолгох боломж бүрдлээ 78

Австри улсад амьдарч буй иргэд нийгмийн даатгалын шимтгэлийг хоёр улсад давхар төлөхөөс чөлөөлөгдлөө 79

Нэг хүний хандивласан цус гурван хүний амийг аврах боломжтой 80

Импортыг орлох 2 мега төсөл хугацаандаа, бүрэн хэрэгжинэ 82

Экспортыг нэмэгдүүлж, эдийн засгийг төрөлжүүлэх Евразийн хэлэлцээр 84

Монголын төр алдаагаа засаж, мянга мянган ээжүүдэд мэхийн ёсоллоо 86

Хууль батлагдсанаар төрийн хүнд суртал, эдийн засаг дахь төрийн оролцоо 30 орчим хувиар буурна 88

Төсөвт өртөг нь удаа дараа нэмэгдсэн төслүүдийг цаашид санхүүжүүлэхгүй! 90

Бизнес эрхлэгчдээ татварын дарамтаас чөлөөлөх хууль батлагдлаа 92

Үл хөдлөх борлуулсны 2 хувь татвар хүчингүй боллоо 93

Татварын өртэй бол данс хааж, хөрөнгийг 100 хувь хураадгийг болиулна 94

НӨАТ-ын босгыг 400 сая төгрөг болгосноор 23 мянган ААН өрсөлдөх чадвараа хадгалж үлдэнэ 95



МОНГОЛ УЛСЫН МАНЛАЙЛЛЫГ ДЭЛХИЙД ХАРУУЛАХ ТҮҮХЭН БОЛОМЖ

Байгаль, хүн төрөлхтний өмнө тулгамдаж буй хамгийн чухал асуудал бол уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтол болсон. Ийм эгзэгтэй цаг үед НҮБ-ын Риогийн гурван том конвенцын нэг Цөлжилттэй тэмцэх 17 дугаар бага хурлыг Монгол Улс 2026 оны 08 дугаар сарын 17-28-ны өдрүүдэд эх орондоо зохион байгуулна. Энэ бол Монгол Улсын байгаль орчны бодлого, санаачилгыг дэлхийн түвшинд хүргэх, хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг татах чухал боломж юм.

НҮБ-ын Риогийн гурван том конвенц

- Уур амьсгалын өөрчлөлтийн конвенц
- Биологийн олон янз байдлын конвенц
- Цөлжилт болон газрын доройтолтой тэмцэх конвенц

Бид үүнийг том хариуцлага төдийгүй, гурван конвенцын хүрээнд илүү нэгдмэл, уялдаа холбоотой үйл ажиллагааг төлөвшүүлэх стратегийн боломж гэж харж байна. Монгол Улсын хувьд үндсэн зорилго маш тодорхой. Газар бол уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдал, хүнсний тогтолцооны огтлолцлын гол цэг юм. Иймд нэгдмэл үйл ажиллагаа нь газрын болон хөрсний эрүүл мэндэд тулгуурлаж, системийн түвшинд хэрэгжих ёстой.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд

Ц.САНДАГ-ОЧИР

Энэхүү алсын хараа нь COP17 бага хурлын “Эх байгалиа сэргээж, итгэл найдвараа бадраая” урианд тусгагдсан бөгөөд газрын нөхөн сэргээлт нь хүнсний аюулгүй байдал, орон нутгийн тэсвэртэй байдал, тогтвортой нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал үүрэгтэй.



Бага хурлыг зохион байгуулагч орны хувьд Монгол Улс "Тал хээрийн төлөвлөгөө"-г зорилтоос бодит хэрэгжилт рүү шилжих талбар болгохоор зорьж байна.
Тус төлөвлөгөө нь олон улсын түвшний зорилтыг бодит үйл ажиллагаа болгон хэрэгжүүлэхийн зэрэгцээ Риогийн конвенцуудын уялдаа холбоог бэхжүүлэхэд чиглэнэ.

COP-17 хуралд НҮБ-ын **196** улсын Засгийн газар, бизнес, ТББ-ын **10,000** гаруй төлөөлөгч оролцоно

"ТАЛ ХЭЭРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ"-НИЙ ХҮРЭЭНД ГУРВАН ҮНДСЭН САНААЧИЛГЫГ ДЭВШҮҮЛНЭ

1 "Бэлчээрийн тэргүүлэх санаачилга" нь бэлчээрийг нөхөн сэргээх, тогтвортой ашиглахын зэрэгцээ хөрсний эрүүл мэнд, экосистемийн бүтээмжийг сайжруулахад чиглэнэ. Монгол Улсын газар нутгийн 70 хувь нь бэлчээрийн газар байдаг. Гэтэл нийт нутаг дэвсгэрийн 77.6 хувь нь газрын доройтлын шинжтэй, үүнээс 23 хувь нь нэн доройтсон ангилалд ордог. Тиймээс бэлчээрийн доройтол бол зөвхөн Монголын асуудал биш, дэлхий нийтийн асуудал. Үүн дээр олон улсын төлөөллүүд нэгдсэн нэг шийдвэрт хүрэх нь маш чухал. Тиймээс манай улс энэ чиглэлээр олон улсад манлайлан ажиллах боломжтой.

2 *"Ус ба газрын нэгдсэн менежментийн санаачилга"* нь хуурай гандуу бүс нутагт ус, газрын нэгдсэн менежментийг дэмжиж, ган болон усны хомсдолд тэсвэртэй байдлыг бэхжүүлнэ. Газрын доройтол, цөлжилт нь усгүйгээр яригдах боломжгүй асуудал. Тиймээс усны эх үүсвэр, гол мөрөн, нуур цөөрөм, усны бүрэлдэх эхийг хамгаалах асуудлыг онцгойлон хөндөнө. Үүний хүрээнд, усны эхийг нэмэгдүүлэх, усны урсгалын бүтцийг хамгаалах, усны нөөцийг тогтвортой ашиглах чиглэлээр томоохон төслүүдиийг хэрэгжүүлэх боломж бүрдэж байна.

3 Байгальд суурилсан шийдлүүдийг өргөн хүрээнд дэмжихэд чиглэнэ. Өөрөөр хэлбэл, байгалийн өөрийнх нь нөөц боломжийг ашиглан асуудлыг шийдэх арга замууд юм. Нар, салхи, ус, бэлчээрийн экосистемд тулгуурласан тогтвортой хөгжлийн төслүүдийг олон улсын түвшинд санал болгож байгаа.

Эдгээр санаачилгууд нь тус тусдаа хэрэгжих төсөл бус, харин Риогийн конвенцуудын зорилтыг уялдуулан хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт татахад бэлэн нэгдсэн талбар байх болно.



Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн дэд сайд
Б.МӨНХТАМИР

COP-17 ДЭЛХИЙ НИЙТЭЭР ЦӨЛЖИЛТТЭЙ ХЭРХЭН ТЭМЦЭХ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛНО


COP-17 бол зөвхөн 12 хоног үргэлжлэх хурал биш. Дэлхий нийтээрээ цөлжилттэй хэрхэн тэмцэх чиг хандлагыг тодорхойлно. Харин үүнээс хойш хоёр жил, цаашлаад 10 жилийн хугацаанд үргэлжлэх томоохон өөрчлөлтийн эхлэл байх ёстой гэж харж байна. Монголчууд бэлчээрийн мал аж ахуйн өв соёлоо хадгалж үлдсэн цөөн орны нэг. Бид эх орныхоо энэ бэлчээрийн газар нутаг газрын доройтлыг дэлхий нийтийн анхааралд авчрах улмаар, COP-17 хурлаар энэ чиглэлээр хэрэгжих томоохон төсөл, хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт татахыг зорьж байна.

Түүнчлэн манай улс дараагийн COP-18 хурал хүртэл хоёр жилийн хугацаанд НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцыг даргалж ажиллана. Ингэхдээ COP-17 дээр танилцуулсан “Хээр талын төлөвлөгөө” болон дэд гурван санаачилгын хүрээнд хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдийг бодит ажил болгоход анхаарна. Байгаль орчинд хил хязгаар гэж байдаггүй. Монголын байгаль, Хятадын байгаль, Оросын байгаль гэж тусдаа ойлголт байхгүй. Нэг дэлхийн л экосистем. Бэлчээрийн газар нутаг нь нүүрстөрөгч шингээдэг томоохон экосистемийн нэг. Гэтэл доройтол нэмэгдэх тусам нүүрсхүчлийн хий ихэсч, улмаар дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт улам эрчимжих эрсдэлтэй.

Иймээс олон улсын байгууллагуудтай хамтран хөрөнгө оруулалт татах, урт хугацааны төсөл хэрэгжүүлэх, газрын доройтлыг бууруулах бодит үр дүн гаргах чиглэлээр ирэх жилүүдэд идэвхтэй ажиллана.

COP17 БА МОНГОЛ УЛСЫН ХҮЛЭЭЛТ

Монгол Улс COP17 олон улсын хурал зохион байгуулах төдий бус цөлжилт, газрын доройтол, ган гачгийн асуудлаа дэлхийн бодлогын анхаарлын төвд хүргэх түүхэн боломж гэж үзэж байна. Газар, бэлчээр нь иргэдийн амьжиргаа, хүнс, усны аюулгүй байдал, эдийн засаг, соёлын өвтэй шууд холбоотой. Иймээс бэлчээрийн тогтвортой менежмент, газрын нөхөн сэргээлт, малчдын мэдлэг, амьжиргааны асуудлыг олон улсын шийдвэр, хөрөнгө оруулалтын түвшинд ахиулахыг зорьж буй юм.





COP17 ЦЭНХЭР, НОГООН БҮС ГЭСЭН ХОЁР ҮНДСЭН ХЭСЭГТЭЙГЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАГДАНА

ЦЭНХЭР БҮС: ДЭЛХИЙН ШИЙДВЭР ГАРГАЛТЫН ТАЛБАР

COP17 хурлын албан ёсны хэлэлцээр, шийдвэр гаргах үйл явц Цэнхэр бүсэд төвлөрнө. Тусгай нэвтрэх дэглэмтэй энэ бүсэд Конвенцын Талууд, НҮБ болон олон улсын байгууллага, итгэмжлэгдсэн ажиглагчид, иргэний нийгэм, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл оролцоно.

Цэнхэр бүсэд Талуудын албан ёсны хуралдаан, дээд түвшний уулзалт, сайд нарын яриа хэлэлцээр зохион байгуулагдана. Мөн эрдэм шинжилгээний болон хувийн хэвшлийн байгууллагууд, олон улсын байгууллагууд өөрсдийн судалгаа, сайн туршлага, шинэлэг шийдэл, хамтын ажиллагааны санаачилгыг танилцуулан оролцогч талуудтай хэлэлцэх тусгай хөтөлбөр юм.



НОГООН БҮС: ОЛОН НИЙТИЙН НЭЭЛТТЭЙ ОРОН ЗАЙ

Ногоон бүс нь COP17 хурлын зорилго, дэвшүүлж буй шийдлийг иргэд болон нийгмийн олон талт төлөөлөлтэй холбох олон нийтэд нээлттэй талбар юм. Ногоон бүсэд газрын нөхөн сэргээлт, цөлжилт, гангийн эрсдэл, ус, бэлчээр, хөрсний эрүүл мэнд, хүнсний тогтолцооны чиглэлээр үзэсгэлэн, танилцуулгын хэсэг байрлана. Энэ хүрээнд иргэд, эрдэмтэн судлаачид, иргэний нийгэм, хувийн хэвшил бизнесүүд болон орон нутгийн төлөөллүүд туршлага, шинэлэг шийдлээ хуваалцан хамтын ажиллагааны шинэ боломжууд өрнөнө. Иргэд, залуучууд, эрдэмтэн судлаачид, иргэний нийгэм, хувийн хэвшил, малчид, орон нутгийн иргэд, уламжлалт мэдлэг тээгчид, бүтээлч бүлэг болон инновацын шийдэл нэвтрүүлэгчид өөрсдийн туршлага, төсөл, бүтээгдэхүүн, санаачилгаа танилцуулж, шинэ түншлэл тогтоох боломжтой.



ӨНДӨР ТҮВШНИЙ УУЛЗАЛТУУД СЭДЭВЧИЛСЭН ӨДРҮҮДЭЭР ҮРГЭЛЖИЛНЭ

COP 17-ын хүрээнд газрын доройтол, цөлжилт, ган гачигтай холбоотой тэргүүлэх асуудлуудыг тусгайлан авч үзэж бодлого, санхүүжилт, шинжлэх ухаан, бодит шийдлийг нэг дор хэлэлцэх хөтөлбөр юм.

Наймдугаар сарын 24 - Санхүүжилтийн өдөр газрын нөхөн сэргээлтийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн шинэ боломж,

Наймдугаар сарын 25 - Усны өдөр - усны хомсдол, ус ба газрын нэгдсэн менежментэд төвлөрнө.

Наймдугаар сарын 26 - Газар ба хүн төвт өдрөөр газрын доройтлын хүний амьжиргаа, орон нутгийн хөгжилд үзүүлэх нөлөө,

Наймдугаар сарын 27 - Хүнсний систем ба хөрсний эрүүл мэндийн өдөр эрүүл хөрс, бэлчээр, тогтвортой хүнсний үйлдвэрлэлийн харилцан хамаарлыг онцлон хэлэлцэнэ.

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ БАТАЛЛАА

1998 онд баталж, 2012 онд шинэчлэн найруулсан тус хуулийг хэрэгжүүлэх явцад үүссэн зохицуулалтын давхардал, тодорхой бус байдал болон төсөл хэрэгжүүлэгчдэд учирдаг цаг хугацаа, зардлын хүндрэлүүдийг арилгах зорилгоор нэмэлт, өөрчлөлтийг боловсруулсан.


Хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг хянах, шийдвэрлэх хугацааг богиносгож, нийгмийн нөлөөллийн үнэлгээг хамтатган хийх эрх зүйн боломжийг бүрдүүллээ.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ АНХДАГЧ ХУУЛИЙГ СОЁРХОН БАТАЛЛАА

Монгол Улс НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын талуудын 17 дугаар бага хурал (COP17)-ыг зохион байгуулах гэж буйтай холбогдуулан цөлжилттэй тэмцэх, ногоон бодлогыг амьдралд ойртуулах хүрээнд дэлхий нийтийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай анхдагч хуулийг баталлаа. Тус хуулийн төслийг баталснаар Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг бие даасан хуулиар зохицуулах эрх зүйн орчинтой боллоо.

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ БОЛОН ОЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ШИНЭЧИЛЖ БАЙНА


Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн барихаар төлөвлөсөн бол Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэн, дэмжээд байна. **Эдгээр хуулийн шинэчлэл нь байгаль орчныг хамгаалах бодлогыг тогтвортой хөгжил, хүний эрхийн зарчимтай уялдуулан боловсронгуй болгох зэрэг ач холбогдолтой.**



COP17 ЗОХИОН БАЙГУУЛАХ БЭЛТГЭЛ АЖЛЫН ХҮРЭЭНД ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ АЖИЛ ҮРГЭЛЖИЛСЭЭР БАЙНА



Ерөнхий сайд Н.Учрал цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын гүйцэтгэх нарийн бичгийн дарга Ясмин Фоуадыг хүлээн авч уулзав.



Stream+ төслийн Удирдах хорооны II хуралдаан боллоо.



Петерсбургийн уур амьсгалын 17 дугаар хэлэлцүүлэг боллоо.



2026.04.25

“Их Долоо”-гийн Байгаль орчны сайд нарын дээд хэмжээний уулзалтад Монгол Улс урилгаар оролцов.



2026.04.28

НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудтай хамтран ажиллана.



2026.05.27

COP17 хүүхэд залуучуудын оролцоог хангаж, хамтран ажиллана.









2026.06.15

COP17 хурлын хүрээнд Монгол Улсаас дэвшүүлэн танилцуулах “Бэлчээрийн тэргүүлэх санаачилга”, “Ус-газрын нэгдсэн менежмент”, “Байгальд түшиглэсэн дэд бүтэц” гэсэн гурван тэргүүлэх санаачилгыг Канад, Герман, Франц, Итали, БНХАУ зэрэг Монгол Улсад суугаа Элчин сайдын яам дэмжиж, хэрэгжилтийн хүрээнд хамтран ажиллахаа илэрхийлээд байна.









2026.04.14

COP17-ын бэлтгэл ажлын хүрээнд орон нутгийн иргэд, малчид болон бусад оролцогч талуудын санал, туршлагыг нэгтгэх зорилготой бүсчилсэн зөвлөлдөх уулзалтууд Хангайн болон Говийн бүсийг хамарч өндөрлөлөө.



#ЧӨЛӨӨЛЬЕ

ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ДӨРВӨН ЗАМ, ДӨРВӨН ЧӨЛӨӨЛӨЛТИЙН БОДЛОГОО ХЭРЭГЖҮҮЛНЭ

Монгол Улсын 35 дахь Ерөнхий сайд
Н.УЧРАЛ

Хэлсэн үг 2026-03-31

Монгол Улсын Ерөнхий сайдын алба бол эрх мэдэл гэхээсээ илүү өндөр хариуцлага, ачааны хүндийг үүрч, асуудлыг шийдэл болгох үүрэг гэдгийг ухамсарлаж байна.

Гадаад, дотоод хоёр талаасаа олон улс, эдийн засаг, улс төрийн эрсдэл хямрал давхар нүүрлэсэн энэ цаг үед Монгол Улсын Ерөнхий сайдын өндөр хариуцлагатай ажил үүргийг хүлээн авч байна. Засгийн газар давхар дарамт, түлш шатахууны үнийн өсөлт, хомсдолын аюул, түүхий эдийн үнийн савлагаа, төсвийн орлогын тасалдлын аюул, дотоодын гацаа, улс төрийн талцал бутралын аюул гэсэн **ГУРВАН** том эрсдэл бүхий шуурга сөрөн ажилдаа орлоо.

Засгийн газар энэ бүх эрсдэлийг сөрж, УИХ-ын даргаар ажиллаж байхдаа дэвшүүлсэн "**ЧӨЛӨӨЛЬЕ**" санаачилга, эрх чөлөөний дөрвөн зам, дөрвөн чөлөөлөлтийн бодлогоо ажил хэрэг болгон хэрэгжүүлнэ.



1 ЭДИЙН ЗАСГИЙН ӨӨЛӨӨЛӨЛТ

Европ, Азийн банкуудыг Монголд урих нэгэнт эхэлсэн яриа хэлцлүүд бол хямд өртөгтэй зээлийн эх үүсвэр, чөлөөт өрсөлдөөний үр дүнд өндөр хүүгийн дарамтаас чөлөөлөгдөх замын эхлэл байлаа. Аюул, гамшиг аливаа эрсдэлийг хандив тусламж, сайхан сэтгэлээр биш даатгалаар шийднэ. Тэтгэврийн тогтолцоо зөвхөн төрийнх байж ирснийг өөрчилж, хувийн тэтгэврийн санг дэмжиж ажиллана.

2 ЭРХ ЗҮЙ, ДҮРЭМ ЖУРМЫН ӨӨЛӨӨЛӨЛТ

Хүслийг хяссан хүнд суртлаас хөдөлмөрч бүтээлч хүн ардаа, баялаг бүтээгч хувийн хэвшлээ төрийн зуршлаас чөлөөлөхийн тулд жим биш зам нээнэ. Зөвшөөрөл нэртэй хориглолтын системийг нурааж эдийн засгийн эрх чөлөөний замыг элдэв саадаас чөлөөлнө.




3 ногоон хөгжлийн чөлөөлөлт

Эх дэлхийдээ ээлтэй эдийн засаг, эко үйлдвэрлэл, тогтвортой хөгжлөөр хөдөө аж ахуйг дэмжих, сэргээгдэх эрчим хүч ашиглаж, нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах нь ногоон чөлөөлөлтийн замын 3-100 хөтөлбөр чиг шугам юм.

4 АВЛИГЫН ЭСРЭГ ЧӨЛӨӨЛӨЛТ

Авлига, албан тушаалын гэмт хэргийн хохирогчид нь Монгол Улсын бүх иргэд юм. Авлигаар олсон мөнгө, үндэслэлгүй хөрөнгө орлогыг олон нийтийн шууд хараа хяналтын дор хураан авах, худалдан борлуулах, эрүүл мэнд, боловсрол, эмнэлэг сургуульд зарцуулах ил тод тайлагнал бүхий хуулийн өөрчлөлт, зохицуулалтыг Засгийн газрын тэргүүний хувьд манлайлж, санаачилсан гишүүдтэй нягт хамтран ажиллана.

Эрх чөлөөний наран монгол хүн бүрийг ивээж, эрх чөлөөт, тусгаар Монгол Улс мандан бадрах болтугай.



Монгол Улсын 35 дахь Ерөнхий сайд Н.Учралын

"**ЧӨЛӨӨЛЬЕ**" санаачилга, "Эрх чөлөөний дөрвөн зам - Дөрвөн чөлөөлөлтийн бодлогоо хэрэгжиж эхлээд даруй **ГУРВАН** сар өнгөрлөө.

ЗАХ ЗЭЭЛД ХЭТ ОРОЛЦДОГ ТӨРИЙН ЗУРШЛЫГ ХУУЛИАР ХААЖ, ХУВИЙН ХЭВШИЛДЭЭ ЗАХ ЗЭЭЛ, ОРОН ЗАЙ НЭЭЖ ӨГНӨ

Ерөнхий сайдын алх цохьсон анхны шийдвэр нь татварын өрийн улмаас хаагдсан 12,153 татвар төлөгчийн арилжааны банкан дахь дансыг нээж, чөлөөлсөн юм. Засгийн газрын дараа дараагийн шийдвэр "Чөлөөлье" бодлогыг хурдасгаж, салбар бүрд тулгарсан чөдөр тушааг чөлөөлөхөөр үргэлжилж байна. Энэ онд 9376 иргэн, аж ахуй нэгж, байгууллага дээр төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр байсныг цуцаллаа. Төрийн албан хаагчдыг 20-30 төрлийн тайлангаас, 146 бизнесийг зөвшөөрлөөс чөлөөлөв. Эрүүл мэндийн салбарынхан 5 дугаар сарын нэгний өдрөөс эхлэн бүх төрлийн нэмэгдлээ нэмэгдсэн цалингаасаа тооцуулж гар дээрээ авах шийдвэр гарлаа.

Эх оронч худалдан авалтыг дэмжлээ. Түлш, шатахууны үнийг хязгаарлаж, тогтворжуулаа. Татварын дарамтаас иргэнээ чөлөөлөх Татварын багц хууль батлагдлаа. Зах зээлд хэт оролцдог төрийн зуршлыг хуулиар хааж, хувийн хэвшилдээ



зах зээл, орон зай нээж өгөх Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэн хэлэлцэж байна.

Ийнхүү эдийн засгаа өсгөж идэвхжүүлж, үр өгөөжийг айл өрх, иргэн, аж ахуй нэгж бүрд хүргэх зорилготой "ЧӨЛӨӨЛЬЕ" санаачилга хэрэгжиж, үргэлжилсээр байна.



БИЗНЕСИЙН ЭРХ ЧӨЛӨӨНД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО ЧУХАЛ

Эдийн засагч **Н.ЭНХБАЯР**

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжээд 30 гаруй жил болж байна. Өнгөрсөн хугацааны сургамжид үндэслэн 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлтөөр хөгжлийн бодлогын тогтвортой байдлыг баталгаажуулсан. Ингэснээр сонгуулийн дараа Засгийн газар солигдох бүрт хөгжлийн бодлого өөрчлөгддөг сул талыг арилгах боломж бүрдсэн.

Энэ хугацаанд эдийн засаг өсөж, бүтэц нь өөрчлөгдөн уул уурхайн салбар эдийн засгийн дөрөвний нэгийг бүрдүүлэх болсон. Энэхүү боломжийг хэрхэн зөв ашиглахаас эдийн засгийн өсөлтийг аж ахуйн нэгж, айл өрхөд хүртээж чадах эсэх шалтгаална.

Манай улс бизнесийн эрх чөлөөгөөр 180 гаруй орноос **69**-д эрэмбэлэгддэг

Үүнийг сайжруулах боломж их байна. Энэ хүрээнд Засгийн газар "Чөлөөлье" бодлогыг хэрэгжүүлж, Нийгмийн даатгалын багц хууль болон Бизнесийн эрх чөлөөний хуулийг боловсруулан өргөн барьсан. Татварын багц хууль батлагдлаа. Эдгээрт тусгай зөвшөөрөл зэрэг бизнесийн саадыг бууруулах, иргэн, аж ахуйн нэгжийн татварын дарамтыг хөнгөрүүлэх зохицуулалтууд тусгагдсан.


Энэхүү батлагдсан хуулийн өөрчлөлтийг төсвийн бодлоготой уялдуулж хэрэгжүүлэх шаардлагатай. Хуульд туссан татварын ачаалал буурсантай холбоотойгоор 2027 оны төсөвт зарлагыг бууруулж, орлогодоо нийцсэн бодлого баримтлах хэрэгтэй. Мөн УИХ баталсан хуулийнхаа хэрэгжилтэд үр дүнтэй хяналт тавьж, УИХ, Засгийн газар бүх түвшинд нягт хамтран ажиллаж чадвал ирэх оны эдийн засагт эерэг үр дүн гарна.



ЧӨЛӨӨЛӨВ

2026 04.06 — 04.08

Монгол Улсын 35 дахь Ерөнхий сайд Н.Учрал Засгийн газрын тамгаа гардан авч, ажилдаа ороод 80 хоногт 42 шийдвэр гаргав.



18	14	7	3
ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨЛӨЛТ	ЭРХ ЗҮЙ, ДҮРЭМ ЖУРМЫН ЧӨЛӨӨЛӨЛТ	АВЛИГЫН ЭСРЭГ ЧӨЛӨӨЛӨЛТ	НОГООН ХӨГЖЛИЙН ЧӨЛӨӨЛӨЛТ

АЛХ ЦОХЬСОН АНХНЫ ШИЙДВЭР ДАНС НЭЭВ

Татварын өрийн улмаас хаагдсан 12,153 татвар төлөгчийн арилжааны банкан дахь дансыг сарын хугацаатай нээж, 1,700 орчим татвар төлөгч өр төлбөрөө төлж, 50 орчим тэрбум төгрөг төвлөрөв.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ЦУЦЛАВ

Хувийн хэвшлийнхэнд үе давдаг тоглоом шиг хатуухан сорилууд тулгардаг асуудлыг шийдлээ. 2026 онд 9376 иргэн, аж ахуй нэгж, байгууллага дээр төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр байсныг Засгийн газраас цуцаллаа.

ТӨРИЙН АЛБАН ХААГЧААС ТАЙЛАН ШААРДАХГҮЙ

Засгийн газар Төрийн албан хаагчдыг 20-30 төрлийн тайлангаас чөлөөллөө. Бодлогын 4 төрлийн баримт бичгийг жилд 7 удаа тайлагнадаг байсныг 2 болгон цөөлөв.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ЦАЛИНГИЙН ОЙЛГОМЖГҮЙ БАЙДАЛ ЦЭГЦЭРЛЭЭ

5 дугаар сарын нэгний өдрөөс эхлэн Эрүүл мэндийн салбарынхан бүх төрлийн нэмэгдлээ нэмэгдсэн цалингаасаа тооцуулж гар дээрээ авах шийдвэр гарлаа.

IT КОМПАНИУДАД "API SERVICE"-ЭЭ НЭЭЛЭЭ

Энэ нь IT салбар авлигыг бууруулаад зогсохгүй улс орны хөгжлийг хурдасгах хөшүүрэг болж байна. Төр иргэндээ очиж үйлчилнэ. Дүрэм засагладаг бус дата засагладаг болно.

ТУУЛЫН ХУРДНЫ ЗАМЫГ ЗОГСООВ

"Туулын хурдны зам" төслийн асуудлаар иргэд, улс төрийн намууд, эрдэмтэн судлаачид Ерөнхий сайдад удаа дараа шаардлага хүргүүллээ. Үүний дагуу хууль хяналтын байгууллага эцэслэх хүртэл зогсоох шийдвэр гаргалаа.

04.08 | 04.15 | 04.21 | 04.22 | 04.23

146 БИЗНЕСИЙГ ЗӨВШӨӨРЛӨӨС ЧӨЛӨӨЛӨӨ

Дугуй, засвар, үсчин, оёдол, кофе шоп, фитнес гээд 146 бизнес эрхлэхийг хүсвэл www.E-business.mn системд гар утаснаасаа мэдэгдээд шууд ажлаа эхлэх боломж бүрдлээ.

ЭХ ОРОНЧ ХУДАЛДАН АВАЛТАА ДЭМЖИНЭ

Дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бараа бүтээгдэхүүнийг төрийн худалдан авалтаар тэргүүн ээлжинд дэмжиж ажиллахыг төсвийн захирагч нарт даалгалаа. Гарын шингэн саван, ариун цэврийн цаас, нормын гутал хувцас зэрэг дотооддоо стандартын дагуу үйлдвэрлэж буй бараа, бүтээгдэхүүнийг төрийн байгууллагууд худалдан авна.

БАГШ, АЖИЛТНУУДЫН ЦАЛИН ТОДОРХОЙ БОЛЛОО

Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй 1510 байгууллагад ажиллаж буй 44.6 мянган багш, ажилтанд учирсан санхүү, нийгмийн эрсдэл арилж байна. Боловсролын салбарынхан өндөр насны тэтгэвэр тогтоолгох, хүүхэд асрах чөлөө хүсэх, эрүүл мэнд, банкны үйлчилгээ авах, виз мэдүүлэхэд учирсан гох дэгээнээс ЧӨЛӨӨЛӨГДЛӨӨ.

ТҮЛШ, ШАТАХУУНЫ ҮНЭ ӨСӨХГҮЙ

2026 оны 3 сард 3200 төгрөг байсан түлш 4 дүгээр сард 4400 төгрөгөөр авсан бөгөөд 5 дугаар сард 6250-6700 орчим төгрөг хүрэх эрсдэл үүсчихсэн байв. Аж үйлдвэр, Эрдэс баялгийн сайдаар ахлуулсан баг ОХУ, Казахстан улсад ажиллаж, ОХУ манай улсад дотоодын зах зээлийнхээ үнээр түлш нийлүүлнэ гэдгээ илэрхийлсэн.

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ"-Н ХУВЬЦАА ӨВЛҮҮЛЭХ АСУУДЛЫГ ШИЙДЛЭЭ

"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоол батлагдлаа. Тус тогтоолоор 2025 оны арван хоёрдугаар сарын 31-ний байдлаар "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-ийн бүртгэлд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцаа эзэмшиж байгаад нас барсан 132,203 иргэний хувьцаа өвлөгдөх нөхцөл бүрдлээ.

ШИЛДЭГ ТАТВАР ТӨЛӨГЧИД 33 ПОЛИТЕХНИКИЙН КОЛЛЕЖТОЙ ХАМТАРНА

Засгийн газар хувийн хэвшилд тулгуурлан боловсролын салбарыг шинэ шатанд гаргах чөлөөлөлтийг эхлүүлж, шилдэг татвар төлөгч, үндэсний тэргүүлэгч компаниудын удирдлагууд 33 политехникийн коллежтой хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.

НОГООН ХӨГЖЛИЙН ЧӨЛӨӨЛӨЛТ ЭХЛЭВ

Засгийн газар Ногоон хөгжлийн чөлөөлөлтийн хүрээнд, 15 шат дамжлага, гарын үсгээр халхалсан хүнд суртлаас иргэдээ чөлөөлсөн. Өрхийн хэрэглээний сэргээгдэх эрчим хүчний холболтын дээд хязгаарыг 20 кВт хүртэл чөлөөлж, айл өрхүүд өөрсдөө эрчим хүч үйлдвэрлэгч болох боломжийг нээсэн.

Мөн Засгийн газар анх удаа Сэргээгдэх эрчим хүчний салбарт өрсөлдөөнт сонгон шалгаруулалт зарлалаа.

НӨӨЦИЙН МАХНЫ ҮНИЙН ӨСӨЛТИЙГ ХЯЗГААРЛАВ

Засгийн газар ээлжит бусаар шуурхай хуралдаж, Үнийн өсөлтийн эсрэг авч хэрэгжүүлэхтэй холбогдох тогтоолын төслийг хэлэлцэн баталж, асуудлыг шийдвэрлэлээ. Шийдвэр гарсны дараа нөөцийн махыг нийслэлийн төвийн зургаан дүүргийн зургаан цэг, томоохон сүлжээ дэлгүүрүүдийн 80 гаруй салбарт худалдаалж эхэлсэн.

04.23 | 05.07 | 05.08 | 05.11 | 05.15 | 05.18 | 05.19

ТАТВАРЫН ДАРАМТААС ИРГЭНЭЭ ЧӨЛӨӨЛНӨ

Засгийн газраас Татварын багц хуульд өөрчлөлт оруулахаар өргөн барилаа.

Татварын Ерөнхий хууль

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай

Хувь хүний орлогын албан татварын тухай

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай

Эдгээр хуулийн нэмэлт, өөрчлөлт нь хөдөлмөрлөж, хийж бүтээж байгаа хэн бүхнийг ХӨНГӨЛӨЛТ-ЧӨЛӨӨЛӨЛТ-өөр дэмжих бодлого юм.

СТРАТЕГИЙН ОРДЫН ҮР ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭВ

Засгийн газар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоож, Үндэсний баялгийн санд хуваарилж, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийн дийлэнхийг ард түмэнд хүртээх зорилгоор хуулийн төсөл боловсруулж, УИХ-д нэн яаралтай горимоор өргөн мэдүүлэхээр тогтлоо.

ИПОТЕКИЙН ЗЭЭЛД ОЛОН ТӨРЛИЙН САНХҮҮЖИЛТ БИЙ БОЛГОНО

Орлого багатай иргэд ипотекийн зээл авах боломж бүрдүүлнэ. Тухайлбал, Орон сууцны 50 хувийг ипотекийн зээлээр авч, 50 хувийг түрээслээд өмчлөх хэлбэрээр тооцож, нөхцөлийг зөөлрүүлэх юм. Орон сууцны санхүүжилтийн банк байгуулахад Монголбанк Засгийн газартай хамтарч ажиллаж байна.

ОЮУТОЛГОЙ ОРДЫН ХҮРТЭХ ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭВ

Засгийн газар зэс, алтны нөөцөөрөө дэлхийд дээгүүрт эрэмбэлэгдэх Оюутолгойн ордын хэлэлцээрт эхний амжилтаа гаргалаа. Эхний шатанд 2.2 тэрбум ам.долларын төлбөрийн зардал бууруулж, хүртэх өгөөж 1.5 тэрбум ам.доллароор нэмэгдлээ.

ЗАСГИЙН ГАЗАР “ГАДААД ЗЭЭЛИЙН АШИГЛАЛТ, ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙГ УИХ-Д ӨРГӨН МЭДҮҮЛЖ, БАТЛУУЛЛАА.

Дотоодын газрын тосны хэрэглээний 55 орчим хувийг хангах Газрын тос боловсруулах үйлдвэр, Баруун бүсийн эрчим хүчний хэрэглээг бүрэн хангах Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төслийн ажил гацаанаас ЧӨЛӨӨЛӨГДЛӨӨ.

НУТАГТАА ЭЗЭН 100:1000 ТӨСЛИЙГ ЭХЛҮҮЛЭВ

Засгийн газар атаршсан газарт ногоон тэжээл тариалж, өвөл, хаврын хүндрэлээс сэргийлэх, малын чанарыг сайжруулах зорилготой “НУТАГТАА ЭЗЭН 100:1000” төслийг эхлүүллээ.

ГАН, ЗЭС БОЛОВСРУУЛАХ ЦОГЦОЛБОР, НҮҮРС ПИРОЛИЗИЙН ҮЙЛДВЭР

“Хөнгөн цагааны аж үйлдвэрийн парк” байгуулах бэлтгэл ажил эхэлсэн бөгөөд Оюу толгойгоос том хэмжээтэй тус төслийн газрыг улсын тусгай хэрэгцээнд авна.

ЗА ГЭЖ ХЭЛСЭН БОЛ ЗААВАЛ ХИЙЕ

Хүүхдийн төлөө За гэж хэлэх хангалтгүй, заавал хийх ёстой гэдгийг Хүүхдийн төлөө зөвлөлийн зөлжит хуралдааны үеэр Ерөнхий сайд онцолж, хэд хэдэн шийдвэр гаргалаа. Ирэх есдүгээр сарын 1-нээс эхлэн цэцэрлэгийн хүүхдүүдийг эрт илрүүлэгт хамруулна. Засгийн газар Монгол хүүхдийг мэдлэг, ур чадварын хоцрогдлоос чөлөөлөх бодлогын хүрээнд “Нэг суралцагч-нэг компьютер, нэг анги-нэг ухаалаг самбар”-тай болгох ажил эхэллээ. Энэ оны 9 дүгээр сарын нэгнээс 2028 он хүртэл 3 үе шаттайгаар нийт 300.000 компьютер, 15.000 ухаалаг самбарыг бүх сургуульд нийлүүлнэ.

“БИЗНЕСИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ” ХУУЛИЙГ ӨРГӨН БАРИВ

Хуулиар

Зөвшөөрөл нэртэй ч хориглолт болсон 105 гаруй хуулийн гох дэгээг тайлж чөлөөлнө.

70 зөвшөөрлөөс бүрэн чөлөөлнө.

32 тусгай зөвшөөрлийг энгийн болгоно.

Зөвшөөрөл авахад тавьдаг 20-30 шаардлагыг дээд тал нь 8 болгож чөлөөлнө.

05.22 | 05.24 | 05.27 | 05.28 | 06.04 | 06.12 | 06.18

ТӨРИЙН 10 КОМПАНИЙГ ТАТАН БУУЛГАЛАА

“Эрдэнэс Монгол” нэгдлийг Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасан үндсэн чиг үүрэгт бүрэн шилжүүлж, “Чингис хаан Үндэсний баялгийн сан корпораци” болгон өөрчлөн зохион байгуулна. Үр дүнд нь 260 орон тоог танаж, 67,3 тэрбум төгрөг хэмнэлээ.

НОГООН ӨРТӨӨ

Хоёр жилийн хугацаанд Улаанбаатар хот болон орон нутагт 500 орчим цахилгаан машин цэнэглэх ногоон өртөө барих тооцоолол гаргажээ. COP-17 хурлаас өмнө цэнэглэх 40 станц байгуулна. 2030 он гэхэд Монгол Улсад 50 мянган цахилгаан машины эрэлт бий болно. Энэ ажлыг ганц компани биш хувийн хэвшлүүд хамтран хэрэгжүүлэх нь чухал. Сонирхсон аж ахуйн нэгж, компаниудад бүрэн нээлттэй юм.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛНА

Илүү олон жил шимтгэл төлсөн нь илүү өндөр тэтгэвэр авдаг шударга тогтолцооны шинэчлэл хийнэ. Ард түмнээ дэмжсэн, ажлын байраа хамгаалсан энэ том шинэчлэлийг УИХ дэмжинэ гэдэгт итгэлтэй байна.

ДҮҮРЭГ БҮРД “ХОТХОНЫ БАГА”, “ТӨРӨЛЖСӨН АХЛАХ”, “ОЛОН УЛСЫН ХӨТӨЛБӨРТЭЙ” СУРГУУЛЬ БАЙГУУЛАХ АЖИЛ ЭХЭЛЛЭЭ

Нийслэлийн Баянгол дүүргийн “Оюуны ундраа” сургуулиас Засгийн газраас хэрэгжүүлж буй “Монгол хүүхэд, залуусыг мэдлэг, ур чадварын хоцрогдлоос чөлөөлье” бодлогын хүрээнд дүүрэг бүрд “Хотхоны бага”, “Төрөлжсөн ахлах”, “Олон улсын хөтөлбөртэй” сургууль байгуулах ажил эхэллээ.

Онлайн хэлэлцүүлэг зохион байгуулагч
УИХ-ын Ёс зүйн дэд хороо

УИХ-ЫН ГИШҮҮНИЙ ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГА

Хугацаа: 2026.04.20-оос 2026.05.25-ны хүртэл

Ард түмний элч төлөөлөгч болсон төрийн түшээ хүн эх орон, хүн ардынхаа эрх ашгийг нэн тэргүүнд тавих ёстой. Тэдний хэлсэн үг, үйлдэл үүнийг гэрчлэх учиртай.Гэтэл өнөөдрийн нийгэмд төрд итгэх иргэдийн итгэл суларсаар байгаа. Иймд УИХ-ын гишүүдийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хяналт хариуцлагын тогтолцоог сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Үүнтэй холбогдуулан УИХ-ын Ёс зүйн дэд хороотой хамтран УИХ-ын гишүүний ёс зүй сахилга хариуцлагыг хэрхэн дээшлүүлэх талаар онлайн хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлгийн үр дүнд асуудлыг олон талаас нь авч үзэж, бодитой шийдэл, санал боловсруулах, улмаар төрийн албан хаагчдаа соён гэгээрүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулж, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарч, төрийн байгууллагын ил тод байдал, хариуцлага нэмэгдэх ач холбогдолтой юм.

Оролцогч экспертүүд



Б.Баярбаатар
УИХ-ын гишүүн



С.Зулпхар
УИХ-ын гишүүн



Ч.Өнөрбаяр
АН-ын дэд дарга



Д.Оюунгэрэл
МУИС-ын багш



Т.Мөнгөнцацрал
Сод консалтинг захирал



О.Сийлэгмаа
Боловсролын зээлийн сангийн дарга асан



Д.Мөнхбат
Ёс зүйн хорооны Референт



Ц.Заяхүү
Ёс зүйн хорооны Соён гэгээрүүлэх хэлтсийн дарга



Э.Саранцэцэг
МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн Ахлах багш, доктор(Ph.D)



Н.Батзориг
Мэргэжлийн социологичдын холбооны гүйцэтгэх захирал



Б.ХЭРЛЭН
УИХ-ын гишүүн, Ёс зүйн дэд хорооны дарга

“ЁС ЗҮЙН ХУУЛЬ, ДҮРЭМ НЬ НИЙГМИЙН ХАРИЛЦААГ ЗӨВ ТӨЛӨВШҮҮЛЭХЭД ҮЙЛЧЛЭХЭЭС БУС, ХЭН НЭГЭНД ДАРАМТ ҮЗҮҮЛЭХ ХЭРЭГСЭЛ БОЛЖ БОЛОХГҮЙ.

ТӨРИЙН ТҮШЭЭДИЙН ҮНДСЭН ШАЛГУУР БОЛ ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГА

Өнөөдөр таван намын төлөөлөл болсон 126 гишүүн Улсын Их Хуралд ажиллаж байна. Төр, түмнээ төлөөлж буй УИХ-ын гишүүд үг, үйлдлээрээ үлгэрлэж, ёс зүйтэй байх учиртай. Иймээс тэдний ёс зүй, хариуцлагын асуудал үргэлж анхаарлын төвд байдаг.

УИХ-ын гишүүний ёс зүйн дүрэмд нийтийн болон улсын эрх ашгийг эрхэмлэх, төрт ёсны уламжлалыг хүндэтгэх, хууль дээдлэх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, шударга зан үйлээрээ үлгэрлэх гэсэн таван зарчмыг тусгасан. Миний хувьд эхний дөрвөн шаардлага харьцангуй сайн хэрэгжиж байгаа гэж үздэг бол тав дахь зарчимд илүү анхаарах шаардлагатай байна.Би 2025 оны арванхоёрдугаар сарын 30-нд Ёс зүйн дэд хорооны даргаар сонгогдсон. Үүнээс өмнө 2025 оны наймдугаар сард УИХ-ын тухай хуульд өөрчлөлт оруулж, Ёс зүй, дэгийн байнгын хороог Ёс зүйн дэд хороо болгон өөрчилж, зөвхөн гишүүдийн ёс зүйн асуудлыг хариуцах болсон нь оновчтой шийдвэр гэж боддог. Гэвч хууль, дүрэм, зохицуулалт нь хуучнаараа байгаа тул шинэчлэх шаардлагатай.

Одоогийн зохицуулалт нь ёс зүйн зөрчил тогтоож, хариуцлага хүлээлгэхэд түлхүү чиглэдэг. Өргөдөл, гомдол ирсэн тохиолдолд шалгаж дүгнэлт гаргадаг ч олон нийтийн анхаарал татсан асуудлыг санаачилгаараа шалгах эрх зүйн боломж хомс байна. Мөн дэд хорооны дүгнэлтийн хэрэгжилтийг хангах болон маргаанд холбогдсон албан хаагчийн эрхийг хамгаалах зохицуулалт дутмаг хэвээр байна.

Тиймээс буруу хэрэглээнээс сэргийлэхийн тулд хууль, дүрмийг илүү тодорхой болгож сайжруулах шаардлагатай.Ийм зорилгоор УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан хууль, дүрмийн шинэчлэлийн ажлын хэсгийг миний бие ахалж ажиллаж байна.Төрийн албан хаагчид, төрийн түшээдийн ёс зүй, сахилга хариуцлагын асуудлыг тодорхой хэмжээнд хуульчлах шаардлагатай гэж үздэг. Төрийн албанд ажиллаж буй хүн бүр хувийн ашиг сонирхлоосоо илүү улс орон, ард түмний эрх ашгийг эн тэргүүнд тавих үүрэгтэй. Энэ бол төрийн албаны ёс зүйн үндсэн зарчим бөгөөд хуульчилж, мөрдүүлж, хэвшүүлснээр төрийн зөв соёлыг төлөвшүүлнэ.

55
УИХ-ын гишүүдтэй холбоотой

57
АЛБАН БИЧИГ ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ

2026.1-6 саруудад ёс зүйн дэд хороо хянан шалгаж ажиллалаа.

ЭКСПЕРТҮҮДИЙН ӨГСӨН САНАЛ

УИХ-ын гишүүдийн ёс зүй, сахилга хариуцлагыг хэрхэн сайжруулах талаар дараах санал, шийдлийг дэвшүүлэв.



Э.Саранцэцэг
МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн ахлах багш, доктор

ИРГЭДИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ БАЙНА

Гишүүдэд хариуцлага тооцох асуудлыг зөвхөн сонгогчдын идэвх санаачилгад найдаж орхих нь хангалтгүй. Монголын нөхцөлд сонгогчдын ирц, улс төрийн оролцоо, ил тод мэдээлэлтэй байдал зэрэг нь хангалттай түвшинд хүрээгүй хэвээр байгаа. Иймээс иргэдийн иргэний боловсролыг дээшлүүлэх нь хамгийн чухал асуудал юм.Иргэний боловсрол сайтай ард түмэн сонгосон гишүүддээ хариуцлага тооцож чаддаг.

2026.05.23 | 4 | ★★★★★

УИХ-ЫН ГИШҮҮДЭД ХАРИУЦЛАГА ТООЦОХ ЭРХ НЬ СОНГОГЧДОД БИЙ

Монгол Улс парламентын засаглалтай орон. Энэ тогтолцоонд сонгогчид өөрсдийн төлөөллийг сонгож, шаардлагатай тохиолдолд хариуцлага тооцох эрхтэй байдаг. Энэ эрхээ иргэд сонгуулиар эдэлдэг. Тиймээс хариуцлага тооцох эрх нь сонгогчдод бий.

2026.05.23 | 5 | ★★★★☆



Ч.Өнөрбаяр
АН-ын дэд дарга

ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮНИЙГ ЁС ЗҮЙН ҮНДЭСЛЭЛЭЭР ОГЦРУУЛАХ НЬ ЗӨВ ШИЙДЭЛ БИШ!

Зөвхөн ёс зүйн үндэслэлээр парламентын гишүүнийг огцруулах нь зөв шийдэл биш. Учир нь ийм жишиг тогтвол парламентын бие даасан байдал, институцийн дархлаа сулрах эрсдэлтэй. Иймээс тухайн гишүүнд эцсийн үнэлгээг ард түмэн өөрсдөө өгч, дараагийн сонгуулиар хариуцлага тооцдог ардчиллын зарчим хамгийн чухалд тооцогддог. Мөн улс төрийн нам тухайн хүнийг дахин нэр дэвшүүлэх эсэх нь өөрөө томоохон хариуцлагын механизм болдог юм.

2026.05.22 | 6 | ★★★★☆

ТУХАЙН ГИШҮҮНД ЭЦСИЙН ҮНЭЛГЭЭГ АРД ТҮМЭН ӨӨРСДӨӨ ӨГЧ, ХАРИУЦЛАГА ТООЦОХ НЬ ЗӨВ!

Хэрэв парламентын гишүүн эрүүгийн хууль зөрчвөл энгийн иргэний адил гэмт хэрэгтэн болно. Харин бусад хууль, дүрэм зөрчсөн тохиолдолд сайн дурааараа албан тушаалаасаа чөлөөлөгдөх, нам нь хариуцлага тооцох, цаашлаад парламентын түвшинд асуудлыг хэлэлцэх зэрэг улс төр, ёс зүйн хариуцлагын асуудал яригддаг.Иймээс тухайн гишүүнд эцсийн үнэлгээг ард түмэн өөрсдөө өгөх нь зөв.

2026.05.22 | 5 | ★★★★☆



Д.Мөнхбат
Ёс зүйн хорооны Референт

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ

Ёс зүйн хэм хэмжээ, нийтлэг шаардлага гэсэн хоёр ойлголтын зааг ялгааг нарийвчлан гаргаж зохицуулах, эвлэрүүлэн зуучлах, зөрчлийг урьдчилан хэлэлцэж ёс зүйн зөрчил мөн эсэхийг тогтоодог байх шаардлагатай байна.

2026.05.18 | 5 | ★★★★☆



Б.Баярбаатар
УИХ-ын гишүүн

ЁС ЗҮЙГ ХЭТ ХУУЛЬЧЛАХ ОРОЛДЛОГО НЬ ӨРӨӨСГӨЛ ОЙЛГОЛТОД ХҮРГЭХ ЭРСДЭЛТЭЙ!

Миний хувьд ёс зүйг хуульчлахын эсрэг байр суурьтай байдаг. Ёс зүйн зөрчлийг зүйрлэвэл барьж болдоггүй, тодорхой хэмжүүрт багтаахад бэрх “мөнгөн ус” шиг гэж хэлж болно.Өнөөдөр ёс суртахууны доройтол нийгмийн бүх түвшинд ажиглагдаж байна. Үүнийг зөвхөн хууль, дүрмээр шийдэх боломжгүй. Харин соён гэгээрүүлэх ажлыг боловсрол, урлаг соёл, нийгмийн оролцоо зэрэг олон талт арга замаар өргөн хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай.

2026.05.21 | 5 | ★★★★★



Т.Мөнгөнцацрал
Сод консалтинг захирал

ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ, БУСАД ЗӨРЧЛИЙН ЯЛГААГ ЗААГЛААГҮЙ, ХОЛЬЖ ХЭРЭГЛЭСЭЭР ИРСЭН

Хамгийн ихээр маргаан дагуулж буй асуудлуудын нэг нь ёс зүйн зөрчил гэж юуг хэлэх вэ гэдэг асуудал. Улс төрч хүн өөрийн үзэл бодлыг илэрхийлэхдээ зүй бус үг хэллэг хэрэглэж, улмаар үхэж байхдаа таарсан юмнууд, ална... гэх мэт үг хэллэгийг хэрэглэсэн бол энэ ёс зүйн зөрчил үү. Эрүүгийн хуульд заасан заналхийлэх гэмт хэргийн шинжтэй үйлдэл гэж үзэх үү гээд. Ёс зүйн зөрчлийг тогтооход хамгийн хэцүү нь харилцагч этгээдэд төрсөн сэтгэгдэл байдаг. Тэгэхээр ёс зүйн зөрчил гэж яг ямар үйлдлийг эс үйлдэхүйг ойлгох вэ гэдгийг маш тодорхой зааглах хэрэгцээ байна.

2026.04.22 | 6 | ★★★★★



Н.Батзориг
Мэргэжлийн социологичдын холбооны захирал

ШИЙДВЭРЛЭХ АСУУДЛЫГ ЭРЭМБЭЛБЭЛ ЭХЭНД БИШ СҮҮЛД НЬ ЁС ЗҮЙ ОРНО!

Нийгмийн бодит хэрэгцээг авч үзвэл иргэдийн өмнө тулгамдаж буй шийдвэрлэх олон асуудлууд бий. Үнийн өсөлт, инфляц, бараа бүтээгдэхүүний үнийн хөөргөдөл, ядуурал, авлигал зэрэг тулгамдаж буй шийдвэрлэх олон асуудлууд байна. Эдгээр шийдэх асуудлуудыг ач холбогдлоор нь жагсаавал, УИХ-ын гишүүдийн ёс зүй, эгүүлэн татах асуудал нь нэн тэргүүнийх биш, хамгийн сүүлд байж болно.

2026.05.24 5 ★★★★☆



С.Зулпхар
УИХ-ын гишүүн

ЁС ЗҮЙГ ТОДОРХОЙ ХҮРЭЭНД ХУУЛЬЧЛАХ ШААРДЛАГАТАЙ!

Ёс зүй бол зөв, бурууг ялгах нийгмийн суурь ойлголт. Харин энэ ойлголтыг хэрэгжүүлэх механизм нь хууль байдаг. Хулгай хийхгүй байх нь ёс зүй, харин хийсэн тохиолдолд хүлээх хариуцлага нь хууль юм.Үүнтэй адил УИХ-ын гишүүний ёс зүйг зөвхөн хувь хүний ухамсарт найдаж орхих бус, тодорхой хүрээнд хуульчлах шаардлагатай. УИХ-ын гишүүд хуралдаа тогтмол оролцохгүй, үүргээ биелүүлэхгүй байх нь зөвхөн ёс зүйн асуудал биш, бодлогын шийдвэрт нөлөөлөх ноцтой асуудал юм. Иймээс ирц, оролцоотой холбоотой зарим харилцааг хуульчлах нь зайлшгүй. Ард түмэн төлөөллөөсөө ёс зүй, хариуцлага шаардаж байна. Харин энэ шаардлагыг хууль болгох нь хууль тогтоогчдын үндсэн үүрэг юм.

2026.05.21 6 ★★★★☆



Д.Оюунгэрэл
МУИС-ийн багш

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГТ УЛС ТӨРЧИЙН ЁС ЗҮЙН ТАЛААР ДАРААХ ЗҮЙЛИЙГ ТУСГАХ ХЭРЭГТЭЙ

Улс орнуудад нийтлэг мөрддөг хориглосон хэм хэмжээг бид өнөө цагт хууль, дүрэм журамтаа жагсаан дурдаж нарийн тусгах хэрэгтэй. Үүнд: - Цэргийн албанаас зайлсхийх - Хүүхдийн тэтгэврээ төлөхгүй байх - Хориотой ан хийх - Автомашины ноцтой осол гаргах - Замын хөдөлгөөний дүрэм зөрчиж, торгууль төлөхгүй удаан хугацаагаар явах - Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ бусадтай таагүй харилцаа үүсгэх - Ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх - Татвараас зугатах - Бэлгийн дарамт үзүүлэх - Төгсөлтийн болон эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэхдээ зохиогчийн эрх зөрчих - Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх - Ул хөдлөх хөрөнгийн үнэ хөөрөгдүүлэх - Хуурамч хаягийн бүртгэлтэй байх - Холбогдох төлбөр, тухайлбал орон сууцны төлбөр төлөхгүй явах - Мөрийтэй тоглоом тоглох - Сонгогчдын үндэслэлтэй шүүмжийг үл тоох - Хэлмэгдүүлэлт гарах нөхцөл боломж үүсгэх - Эх орноосоо урвах зэргийг юуны өмнө нэрлэх хэрэгтэй.

2026.04.28 6 ★★★★★

ҮҮРГЭЭ УХАМСАРЛАХ НЬ УЛС ТӨРИЙН ЁС ЗҮЙН ҮНДСЭН ЗАРЧИМ

Деонтологи онолын хувьд үүргээ ухамсарлан биелүүлэх нь юу юунаас чухал. Энэ онол нь үйлдлийн үр дагаврыг биш, сэдэл зорилгыг чухалчилдаг. УИХ-ын гишүүн сонгогчдод бэлэг тараах, шагнал гардуулах, тойрогтоо ямар нэг эерэг зүйл хийх зэрэг нь үр дагавар нь сайн мэт боловч сэдэл, зорилго нь дахин сонгогдохын тулд байх аваас уг онолоод ёс суртахуунтайд тооцогдохгүй. Хүссэнээрээ бус, юунд татагдсанаараа бус үүргээ үйлдэхээ ухамсарлан хийхийг хэлнэ. Хүлээсэн үүргээ хүндэтгэснээс хийж буй үйлдэл ёс суртахуунтай. Эндээс харахад амласан бол биелүүлэх ёстойгоо ухамсарлах нь УИХ-ын гишүүдийн үүрэг гэж ойлгоно.

2026.04.28 5 ★★★★☆



О.Сийлэгмаа
Боловсролын зөөлийн сангийн дарга асан

ЁС ЗҮЙГ ХУУЛЬЧИЛЖ БАЙГАА БОЛ ТӨРИЙН БҮХ ШАТАНД, УЛС ТӨРИЙН АЛБАН ТУШААЛТНУУДАД АДИЛ ТЭГШ ХЭРЭГЛЭХ ЁСТОЙ

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн үйлчлэх хүрээг улс төрийн албан тушаалтанд ижил түвшинд хэрэгжүүлдэг байхаар хуулийн хэрэгжих хүрээг өөрчлөх шаардлагатай. Энэ нь хууль тэгш үйлчлэх зарчимд нийцэх болов уу? Одоогийн УИХ-ын гишүүдийн ёс зүйн дүрэмд тусгасан заалтыг дээрх хуулийн нэмэлт өөрчлөлтөөр боловсронгуй болгох нь илүү бодит үр дүн гарна гэж харж байна. Тус дүрмийн хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий Ёс дэд хорооны гишүүд ажлаа эрчимжүүлэх чин эрмэлзэлтэй байж, "хууль зүйн мэдлэгээ сайжруулж, хараат бус, баримтад суурилсан шинжлэн судлах ажлыг бүрэн-үнэн зөв гүйцэд ажиллагаа явуулдаг", олон талаас мэтгэлцэх боломжийг хангадаг, сонсох ажиллагааг бодитоор хэрэгжүүлдэг болох ёстой. Ингэж чадвал ёс зүйн зохицуулалт нь хүний эрх зөрчдөг хэрэгсэл биш, харин төрийн албаны шударга, хариуцлагатай тогтолцоог хамгаалах механизм болж чадна.

2026.05.18 7 ★★★★★

ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙН ДҮГНЭЛТИЙГ ЗАРИМ ТОХИОЛДОЛД ХҮНИЙГ АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ХЭРЭГСЭЛ БОЛГОН АШИГЛАЖ БАЙНА

Ийм эрсдэл харагдаж байна. Миний хувьд сайдын чөлөөлөх тушаал гарахдаа Төрийн албан хаагчийн Ёс зүйн хорооноос ирүүлсэн албан бичиг болон ёс зүйн дэд хорооны дээрх шиг дүгнэлтүүдийг үндэслэсэн. Үүний хоёр дээр нь шүүхэд хандах боломж, хугацаа олголгүйгээр шууд шийдвэр гаргасан.Мөн ёс суртахуун, ёс зүй гэсэн ойлголтын талаар нэгдмэл ойлголтгүй байгаа нь асуудлыг хувь хүний үзэмжээр шийдэх нөхцөл бүрдүүлж байна. Үүнийг засах ёстой.

2026.05.18 8 ★★★★★



С.ЗУЛПХАР
УИХ-ын гишүүн

ЁС ЗҮЙГ ТОДОРХОЙ ХҮРЭЭНД ХУУЛЬЧЛАХ ШААРДЛАГАТАЙ!

Ёс зүй бол зөв, бурууг ялгах нийгмийн суурь ойлголт. Харин энэ ойлголтыг хэрэгжүүлэх механизм нь хууль байдаг. Хулгай хийхгүй байх нь ёс зүй, харин хийсэн тохиолдолд хүлээх хариуцлага нь хууль юм.Үүнтэй адил УИХ-ын гишүүний ёс зүйг зөвхөн хувь хүний ухамсарт найдаж орхих бус, тодорхой хүрээнд хуульчлах шаардлагатай. УИХ-ын гишүүд хуралдаа тогтмол оролцохгүй, үүргээ биелүүлэхгүй байх нь зөвхөн ёс зүйн асуудал биш, бодлогын шийдвэрт нөлөөлөх ноцтой асуудал юм. Иймээс ирц, оролцоотой холбоотой зарим харилцааг хуульчлах нь зайлшгүй. Ард түмэн төлөөллөөсөө ёс зүй, хариуцлага шаардаж байна. Харин энэ шаардлагыг хууль болгох нь хууль тогтоогчдын үндсэн үүрэг юм.Гэвч нөгөө талдаа ёс зүйн асуудлыг хэт ерөнхий байдлаар хуульчилбал гишүүдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх халдашгүй эрхэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Иймд: Ёс зүйн ноцтой зөрчил”-ийг тодорхойлох, хариуцлагын хэлбэр, хэмжээг нарийвчлах, гишүүдийн бүрэн эрх, халдашгүй байдлыг хамгаалах зэрэг асуудлыг тэнцвэртэй шийдвэрлэх шаардлагатай.



О.СИЙЛЭГМАА
Боловсролын зээлийн сангийн дарга асан

БАРИМТГҮЙ ЁС ЗҮЙН ДҮГНЭЛТ ХҮНИЙ ХУВЬ ЗАЯАГ ШИЙДЭХ ЁСГҮЙ!

Практик дээр ёс зүйн зөрчил мөн эсэхийг тогтоох ажиллагаа хэт субьектив байдлаар явагдаж байна. Баримтыг бүрэн шалгаж, нөхцөл байдал, шалтгаан хүчин зүйлсийг нягтлахын оронд хувь хүний үзэмж, өс хонзонгийн сэдэл, ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр давамгайлах тохиолдол цөөнгүй байна. Ялангуяа дээд албан тушаалтны хууль бус шийдвэрийг эсэргүүцсэн, асуудал хөндсөн төрийн албан хаагчдын эсрэг ёс зүйн зөрчил гэх үндэслэл ашиглаж, ажлаас нь чөлөөлөх явдал түгээмэл байгаа.Миний хувьд Боловсролын яамны Ёс зүйн дэд хорооноос гаргасан дүгнэлтийг шүүхэд өгч, шүүхийн шийдвэр манай талд гарсан бодит кейстэй хүн. Шүүхээс дараах үндэслэлүүдийг тогтоосон. Нэгдүгээрт, ажил үүргээ гүйцэтгэж байхдаа өгсөн мэдээлэл нь ёс зүйн зөрчил болсон гэх үндэслэл тогтоогдоогүй. Хоёрдугаарт, Боловсролын яамны Ёс зүйн дэд хороо баримтыг бодитоор нягтлан шалгалгүй, зөвхөн нэг талын мэдээлэлд тулгуурласан байсан. Гуравдугаарт, хуульд хэрэглэсэн “гутаах”, “доромжлох” гэх үгийг буруу тайлбарлаж, хэрэглэсэн асуудал байсан.



Ч.ӨНӨРБАЯР
Ардчилсан намын дэд дарга

ЁС ЗҮЙН ҮНДЭСЛЭЛЭЭР ОГЦРУУЛАХ НЬ ЗӨВ ШИЙДЭЛ БИШ!

Парламентын гишүүн бол ард түмний төлөөлөгч. Тангараг өргөхдөө Үндсэн хуульдаа үнэнч ажиллана хэмээн амладаг. Энэ нь зүгээр нэг ёслолын шинжтэй үйлдэл, эсвэл олон нийтэд харагдах хээнцэр дүр зураг огт биш. Харин үүний цаана хууль зүйн болон ёс зүйн томоохон хариуцлага оршдог.

Гурван төрлийн том хариуцлага хүлээдэг. Нэгт, ард түмэн сонгуулиар дүн тавьж, улс төрийн хариуцлага тооцдог. Хоёрт, Үндсэн хууль зөрчсөн нь Үндсэн хуулийн цэцээр тогтоогдвол бүрэн эрхээс нь түдгэлзүүлэх, чөлөөлөх хүртэл арга хэмжээ авах боломжтой. Гуравт, хууль тогтоогчийн хувьд Засгийн газраас хуулийн хэрэгжилтийг шаардахын зэрэгцээ өөрөө хууль дээдлэх зарчмыг биечлэн үлгэрлэх үүрэгтэй. Хэрэв парламентын гишүүн эрүүгийн хууль зөрчвөл энгийн иргэний адил гэмт хэрэгтэн болно. Харин бусад хууль, дүрэм зөрчсөн тохиолдолд сайн дураараа албан тушаалаасаа чөлөөлөгдөх, нам нь хариуцлага тооцох, цаашлаад парламентын түвшинд асуудлыг хэлэлцэх зэрэг улс төр, ёс зүйн хариуцлагын асуудал яригддаг.



Э.САРАНЦЭЦЭГ
Улс төрийн ухааны доктор(Ph.D

ГИШҮҮДЭД ХАРИУЦЛАГА ТООЦОХ ЭРХ НЬ СОНГОГЧДОД БИЙ!

2023 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн үр дүнд 2024 оны сонгуулиар Монгол Улсын парламент 126 гишүүнтэй болж, үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ өөрчлөлт нь төлөөллийн цар хүрээг нэмэгдүүлэх, бодлогын түвшний хэлэлцүүлгийг илүү өргөн болгох зорилготой ч нөгөө талдаа ардчиллын чанар, иргэдийн оролцооны талаар шинэ асуултуудыг дагуулж байна. Үүнийг парламентын шинэ бүтэц ба ардчиллын сорилт гэж харж байна. УИХ-ын гишүүний ёс зүй хариуцлагын асуудал нэлээн яригдаж, гишүүдийг эгүүлэн татах хуулийг парламент хэлэлцсэн.Зарим улс оронд гишүүдийг эгүүлэн татах эрхийг хуульчилсан байдаг ч эдгээр нь ихэвчлэн ардчиллын индекс доогуур орнуудад түгээмэл ажиглагддаг.

Манай улсад гишүүдийн ёс зүй, хариуцлагын асуудал ардчилал төлөвшиж байгаа оронд байдаг хэвийн үзэгдэл гэж харж байна. Парламентын засаглалтай манай улсын тогтолцоонд сонгогчид өөрсдийн төлөөллийг сонгож, шаардлагатай тохиолдолд хариуцлага тооцох эрхтэй. Энэ эрхээ иргэд сонгуулиар эдэлдэг.

РЕДАКЦЫН ДҮГНЭЛТ



Ц.СОЁЛМАА
Vip 76.mn сайтын сэтгүүлч, редактор

УЛС ТӨРИЙН НАМ ТӨЛӨВШӨЛ ГИШҮҮДИЙН ЁС ЗҮЙ САЙЖИРНА

Нийгэмд ёс зүйг хуульчлах нь зөв үү, буруу юу? Энэ талаарх мэтгэлцээн өнөөдрийг хүртэл өрнөсөөр ирсэн. Тэр дундаа “Ёс зүйг хуульчилж болдоггүй” гэх яриа улс төрийн тавцанд байнга гардаг. Монгол Улсад УИХ-ын гишүүний ёс зүй, сахилга хариуцлагын асуудлыг голчлон ёс зүйн дүрмээр зохицуулж ирсэн. Энэ хариуцлагын тогтолцоо сул байгаа нь үнэн.

Эцэст нь дүгнэхэд “Эх нь булингартай бол адаг нь булингартай” гэдэг шиг улс төрийн нам цэвэр, төлөвшсөн, хариуцлагатай байх нь парламентын ёс зүй, улмаар ардчиллын чанарыг тодорхойлох үндсэн нөхцөл болно.Иймд УИХ-ын гишүүний ёс зүйн асуудал нь хувь хүнээс давсан намын төлөвшлийн асуудал юм.

ТЭГВЭЛ, ИРГЭДИЙГ ТӨЛӨӨЛЖ БУЙ УИХ-ЫН ГИШҮҮНИЙ ЁС ЗҮЙ САХИЛГА ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА МЕХАНИЗМУУД, ШИЙДЭЛ НЬ ЮУ БАЙЖ БОЛОХ ТАЛААР САЛБАРЫН ЭКСПЕРТҮҮДИЙН ДУУ НЭГТЭЙ ДЭВШҮҮЛСЭН

6 ШИЙДЭЛ

1. Ёс зүй ёс суртахууны ялгааг тодорхой болгож, ёс зүйн зөрчлийг хуулиар тодорхойлсон нэр томьёотой болох.

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах.

3. УИХ-ын гишүүний ёс зүйг зөвхөн хувь хүний ухамсарт найдаж орхих бус, тодорхой хүрээнд хуульчлах.

4. Ёс зүйн үндэслэлээр парламентын гишүүнийг огцруулах нь зөв шийдэл биш. Учир нь ийм жишиг тогтвол парламентын бие даасан байдал, институцийн дархлаа сулрах эрсдэлтэй.

5. Иргэдийн иргэний боловсролыг дээшлүүлэх. Иргэний боловсрол сайтай ард түмэн сонгосон гишүүддээ хариуцлага тооцож чаддаг.

6. Намууд шинэчлэгдэж, ил тод, шударга, хариуцлагатай тогтолцоог бүрдүүлэх.

Онлайн хэлэлцүүлэг зохион байгуулагч
Авлигатай тэмцэх газар

ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙ БҮРДҮҮЛЭХ НЬ

Хугацаа: 2026.04.20-оос 2026.05.25-ны хүртэл

Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлснээр хэт нэг талдаа төвлөрсөн эрх мэдэл тэнцвэржинэ, төр засгаас гарч буй шийдвэрүүд хэн нэгний явцуу эрх ашигт нөлөөлсөн бус нийтийн эрх ашгийн төлөө гардаг болно, нийгэмд шударга ёс тогтоно.
Түүнчлэн хамгийн чухал нь авлигыг мэдээлэх аюулгүй, үр дүнтэй тогтолцоог бэхжүүлэхэд өндөр хувь нэмэр оруулах юм.
Иймд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилтыг хангах, олон улсын байгууллагуудаас хийсэн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, дүнг сайжруулах үүднээс Авлигатай тэмцэх газартай хамтран онлайн хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Оролцогч экспертүүд



Х.Баасанжаргал
УИХ-ын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга



О.Билгүүн
Монголын хуульчдын холбооны зөвлөлийн гишүүн



Д.Ганхүрэл
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш



Б.Эрдэнэдалай
МУИС, УТСОУХНУС-ийн Улс төр судлалын тэнхимийн дэд профессор, доктор



С.Будрагчаа
Сэтгүүлч



Л.Галбаатар
Монголын хуульчдын холбооны гишүүн



С.Бямбахорлоо
СЭЗИС-ийн доктор, профессор



О.Сийлэгмаа
Боловсролын зээлийн сангийн дарга асан



Г.Эрдэнэзул
“Зөвийг шүгэлдэгч ТББ”-ын тэргүүн



Б.Цогтгэрэл
“Шилэн данс” ТББ-ын тэргүүн



Д.ЦЭНД-АЮУШ

АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар

ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДВЭЛ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦОО БЭХЖИЖ, ТӨСВИЙН ҮР АШИГГҮЙ ЗАРЦУУЛАЛТ БУУРНА

Авлигын гэмт хэрэг нууц далд байдлаар үйлдэгддэг учраас түүний талаар бодит мэдээлэл, дотоод мэдээлэгчийн өгсөн мэдээллээр илрэх магадлал өндөр байдаг. Шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчин бүрдүүлэх нь улс орнуудын санал санаачилгын төдий асуудал бус, авлигатай үр дүнтэй тэмцэхийг зорьж буй улс орнуудын, мөн бизнесийн байгууллагуудын үйл ажиллагааны нэг нийтлэг стандарт бараг болж байна гэхэд болохоор байна.

Нэгдсэн Үндэсний Байгууллага, Эдийн засаг хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) зэрэг байгууллагууд шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн тогтолцоо бүрдүүлэхийг авлигын эсрэг бодлогын зайлшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг гэж зөвлөдөг.

Гадны улс орнуудад шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн тогтолцоог бүрдүүлсэн олон орон бий. Тухайлбал, АНУ-ын болон Их Британий загвар голлон яригддаг загвар ба түүнд тулгуурлан хөгжүүлсэн Япон, Солонгосын онцлог загварууд байдаг. Ялангуяа, БНСУ-ын загвар нь авлигыг мэдээлж шүгэл үлээсэн хүнийг хамгаалахаас гадна тодорхой нөхцөлд мөнгөн урамшуулал, нөхөн олговор олгодог, мөн цахим системийг хөгжүүлсэн нь онцлог байдаг. Бусад орнууд, тухайлбал, Австрали, Канад, Франц зэрэг улсууд мэдээлэгчийн нууцлалыг хадгалах, хариу авах гэсэн үйлдлээс хамгаалах, ажлын байрны баталгааг нь хангах чиглэлээр зохицуулалтад нийтлэг анхаардаг.

Шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчин бүрдэж, хэрэгжсэнээр гарах олон үр дүн байгаа. Тухайлбал, авлига, ашиг сонирхлын зөрчил, төсвийн хөрөнгийг зүй бусаар зарцуулсан талаарх мэдээллийн ихэнх нь байгууллагын дотоод орчноос мэдээлэх



Шүгэл үлээгчийг хамгаалах асуудлыг зөвхөн нийтийн албаар хязгаарлах нь учир дутагдалтай, хувийн хэвшил, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд зэрэг өргөн хүрээнд авч үзэх хэрэгтэй.

боломжтой байдаг тул хууль хэрэгжсэнээр эдгээр далд зөрчлийг илрүүлэх боломж нэмэгдэнэ. Түүнчлэн төрийн байгууллагын хариуцлага сайжирч, төсвийн үр ашиггүй зарцуулалт буурах, ялангуяа үр дагавар нь гарахаас өмнө буурах боломж нэмэгдэнэ.

Нөгөө талаас шүгэл үлээхээс үүдэх дарамт, шахалтыг бууруулах, нийтийн эрх ашигийн төлөө шүгэл үлээсний дараа ирэх зүй бус шахалт дарамтаас хамгаалах, хууль бус үйлдэл, үйл ажиллагааны талаар зохих шаардлага тавьдаг соёл, хандлага бүрдэхэд ихээхэн нөлөө үзүүлэх юм.

Мэдээж хэрэг нэг хууль батлаад эдгээр үр дүн шууд гарах боломжгүй юм. Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт, уялдааг хангах нь чухал. Тухайлбал, багаар ажиллах, эвсэл намын болон бусад ямар нэг байдлаар "өөрийн хүн"-ээр хүний нөөцийг бүрдүүлэх гэсэн хандлага нь хууль бус, шударга бус үйлдлийг дарагдуулах, ашиг сонирхлын зөрчлийн эрсдэлийг нэмэгдүүлэхээс гадна хууль дээдлэх ёсонд үл нийцэх юм. Энэ мэт хандлагыг өөрчлөх, шударга, ил тод, хариуцлагатай нийтийн албыг бэхүүлэх нь чухал юм. Шүгэл үлээгчийг хамгаалах асуудлыг зөвхөн нийтийн албаар хязгаарлах нь учир дутагдалтай, хувийн хэвшил, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд зэрэг өргөн хүрээнд авч үзэх хэрэгтэй.

Түүнчлэн шүгэл үлээсэн тохиолдолд нууцлалыг хэрхэн хангах вэ гэдэгт анхаарч, нарийн зохицуулалтыг тусгах нь чухал хүчин зүйл болно.

Монгол Улс НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 33 дугаар зүйлд заасан мэдээлэгчийг хамгаалах зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тодорхой зорилтууд тусгасан гэж үзэж болно.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийн 3.4.2-т авлига, албан тушаалын гэмт хэргийн талаар мэдээлсэн этгээдийг дарамт шахалт, сүрдүүлгээс хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох зорилтыг тусгаснаас гадна мөн хөтөлбөрийн 6.4.3-т шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар "шүгэл үлээх соёл"-ыг нийгэмд төлөвшүүлэхээр зааажээ. Энэ хүрээнд олон нийтэд авлигын хор хөнөөлийг ойлгуулах, авлигын талаар гомдол мэдээллийг гаргах суваг, хэлбэрийг тайлбарласан сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулж байна.

Түүнчлэн энэ асуудлаар төр, хувийн хэвшил болон иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл, судлаачдыг хамруулсан нээлттэй хэлэлцүүлгүүдийг үе шаттайгаар зохион байгуулсан, холбогдох судалгааны ажлыг хийлгэж "Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль"-ийн төслийг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлж байсан. Улмаар Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хуулийн төслийг шинэчлэн 2021 онд УИХ-д өргөн баригдсан бөгөөд 2026 онд Засгийн газар уг хуулийн төслийг дахин хэлэлцэн дэмжиж, УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Шударга байдлын үнэлгээний 2025 оны судалгааны тайлангаас харвал "авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалдаг" гэсэн үзүүлэлт

47 орчим оноо авсан нь эрх зүйн хамгаалалт шаардлагатайг харуулж байна

ОЛОН НИЙТЭД АВЛИГЫН ХОР ХӨНӨӨЛИЙГ ОЙЛГУУЛАХ, АВЛИГЫН ТАЛААР ГОМДОЛ МЭДЭЭЛЛИЙГ ГАРГАХ СУВАГ, ХЭЛБЭРИЙГ ТАЙЛБАРЛАСАН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААГ ТОГТМОЛ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА!

ЭКСПЕРТҮҮДИЙН ӨГСӨН САНАЛ

Шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар санал, шийдлийг дараах байдлаар дэвшүүлэв.



Х.Баасанжаргал
УИХ-ын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга

АВЛИГА ГАРАХААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ ЧУХАЛ МЕХАНИЗМ БАЙХ УЧИРТАЙ

Авлигатай тэмцэхэд хоёр том параллель ажил явах ёстой. Нэгт, авлига гарсны дараах илрүүлэх ажиллагааны гол механизм нь шүгэл үлээгч байж болно. Хоёрт, авлига гарахаас урьдчилан сэргийлэх нь чухал механизм байх учиртай. Үүнийг бид орхигдуулаад байгаа. Учир нь дандаа хэрэг болсны дараах үйл явдал, хэрэг болсны дараах сенсаци руу голчлон анхаарч байна. Тиймээс хэрэг болохоос өмнөх буюу авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй зүйлүүд дээр урьдчилан сэргийлэх механизм хэрхэн, яаж ажиллах вэ гэдгийг бодох ёстой. Дээрээс нь шүгэл үлээгчийг энэ тийш чиглүүлэх нь зүйтэй!

2026.04.22 | 4 | ★★★★★



Д.Ганхүрэл
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш

ҮНЭНИЙГ ХЭЛЭХ ЗОРИГИЙГ ХАМГААЛАХ НЬ ЧУХАЛ

Нэгт, шүгэл үлээгчийг хамгаалах бие даасан, цогц хуулийг яаралтай батлах шаардлагатай. Энэ хууль нь зөвхөн төрийн албан хаагч бус, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын хүрээг хамарсан байх ёстой. **Хоёрт,** мэдээлэгчийг бодитоор хамгаалах механизм хэрэгтэй. Зөвхөн “хамгаална” гэж тунхаглахаас илүү ажлаас халахыг хориглох, нууцлалыг чанд хадгалах, шаардлагатай бол хамгаалалтын тусгай арга хэмжээ авах хүртэлх тодорхой зохицуулалтыг хуульчлах нь чухал. **Гуравт,** авлигын мэдээлэл хүлээн авах, шалгах нэгдсэн, итгэл төрүүлэхүйц сувгийг бий болгох. Иргэн мэдээлэл өгсөн бол түүнийх нь хувь заяа тодорхойгүй алга болдог биш, тодорхой хугацаанд шалгагдаж, хариу өгдөг систем байх ёстой. **Дөрөвт,** мэдээлэгчийг зөвхөн хамгаалахаас гадна дэмжих хэрэгтэй. Зарим улс оронд мэдээллийн үр дүнд төрд учрах хохирлыг бууруулсан тохиолдолд урамшуулал олгодог. Энэ нь “эрсдэл үүрсэн хүнийг үнэлдэг” шударга зарчим юм.

2026.05.01 | 10 | ★★★★★



Б.Цогтгэрэл
“Шилэн данс ” ТББ-ын тэргүүн

ШҮГЭЛ ҮЛЭЭГЧДИЙН ТАЛААР УИХ-ЫН НЭЭЛТТЭЙ СОНСГОЛ ХИЙМЭЭР БАЙНА!

Шүгэл үлээгчийн хууль хэрэгтэй. Шүгэл үлээгчдийн талаар УИХ-ын нээлттэй сонсгол хийх саналтай байна. Нийтийн сонсголын тухай хуулийн дагуу иргэд саналаа гаргаж болно. Эсвэл УИХ-ын гишүүд санал гаргаж ч болно.

2026.05.06 | 5 | ★★★☆☆



О.Билгүүн
Монголын хуульчдын холбооны зөвлөлийн гишүүн

ХУУЛЬ ЗҮЙН БОДИТ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ИНСТИТУТИЙН МЕХАНИЗМ ТОДОРХОЙГҮЙ БАЙНА!

“Шүгэл үлээгч”-ийг үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаагаар хангах, хуульчдын оролцоог институцчлах, улмаар мэдээллийг нийтийн эрх ашгийн хэрэг болгон хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх буюу хуульчийн пробоно үйл ажиллагаатай уялдуулж болохоор байгаа. Хуульд дээрхи зохицуулалтыг тусгах нь Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль нь зөвхөн хамгаалалтын шинжтэй, авлигыг илрүүлэх зохицуулалт байхаас давж, мэдээллийг бодитой ашиглах, эрсдэлийг эрт илрүүлэх, хариуцлага тооцох, компанийн засаглалыг сайжруулах, улмаар БОНЗ-ийн гүйцэтгэлийг нэмэгдүүлэх цогц механизм болж хөгжих боломжтой. Өөрөөр хэлбэл, уг хууль нь авлигын эсрэг тэмцлийн хүрээнээс давж, тогтвортой хөгжил, хариуцлагатай бизнесийн орчныг бүрдүүлэх стратегийн ач холбогдолтой эрх зүйн хэрэгсэл болох нөхцөл бүрдэнэ.

2026.06.05 | 10 | ★★★★★

ОДООГИЙН ХУУЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ НЬ АВЛИГЫН ШИНЖТЭЙ ЗӨРЧИЛД ТҮЛХҮҮ ТӨВЛӨРСӨН БАЙНА!

Одоогийн хуулийн төслийн хамрах хүрээ нь авлигын шинжтэй зөрчилд түлхүү төвлөрсөн байгаа нь олон улсын чиг хандлага буюу санхүүгийн зөрчил, байгаль орчны зөрчил, хүний эрхийн зөрчил, түүнчлэн нийтийн ашиг сонирхолд ноцтой нөлөөлөх аливаа үйлдлийг илрүүлэх чухал хэрэгсэл болж болох боломжийг алдаж байна!

2026.06.05 | 5 | ★★★★★



Л.Галбаатар
Монголын хуульчдын холбооны гишүүн

ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИЙГ СӨРӨГ ҮР ДАГАВРААС ХАМГААЛАХ ТОГТОЛЦОО

Нэгт, хуульд ажлаас халах, албан тушаал бууруулах, сэтгэл зүйн дарамт үзүүлэхийг хориглосон заалтууд орсон. Гэвч шүгэл үлээгчийг эргээд “гүйцэтгэх ажлын нууц задруулсан” эсхүл “байгууллагын нэр хүндэд халдсан” гэж яллах боломжийг хаах хууль зүйн дархан эрхийг илүү тодорхой болгох шаардлагатай. Хоёрт, нотлох баримтын ачааллыг шилжүүлэх. Хэрэв шүгэл үлээгч ажлаас халагдсан бол “шүгэл үлээсэнтэй нь холбоогүй” гэдгийг ажил олгогч өөрөө нотлох үүрэг хүлээдэг олон улсын зарчмыг (Reversed burden of proof) тусгах. Гуравт, байгууллагын хараат бус байдал. Шүгэл үлээгчийг дэмжих нэгж нь Аюулгүй байдлыг хангах төв байгууллагын дэргэд байхдаа зөвхөн цагдаагийн хамгаалалтын чиг үүргээр хязгаарлагдахгүй, иргэний нийгэмтэй хамтарсан хяналтын зөвлөлтэй байх.

2026.05.05 7 ★★★★★

ОЛОН УЛСАД УРАМШУУЛАЛ НЬ ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИЙГ ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ “ДААТГАЛ” БОЛОХ ЁСТОЙ ГЭЖ ҮЗДЭГ

Хуулийн төсөлд “Шүгэл үлээгчийг дэмжих сан” байгуулж, нийтийн ашиг сонирхлыг хамгаалж, хохирлыг нөхөн төлүүлсэн тохиолдолд урамшуулал олгохоор заасан. Урамшууллыг зөвхөн “шүүхийн эцсийн шийдвэр гарч, хохирол төлөгдсөн” тохиолдолд олгохоор хязгаарлавал шүгэл үлээгч олон жилийн турш эрсдэлд орж, ямар ч дэмжлэггүй үлдэх магадлалтай. Олон улсад (Жишээ нь: АНУ-ын SEC загвар) урамшуулал нь шүгэл үлээгчийг эрсдэлээс хамгаалах “даатгал” болох ёстой гэж үздэг.

2026.05.05 5 ★★★★★



О.Сийлэгмаа
Боловсролын зээлийн сангийн дарга асан

“ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИЙН ЭРСДЭЛ, ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ” ТОДОРХОЙ БУС

Монгол Улсын хүн ам цөөн, ажилласан салбар хязгаарлагдмал нөхцөлд ажлаас гарсан ч элдэвээр дарамтлах байдлаар шүгэл үлээгчийг нийгэмд хөл тавих газаргүй болгодог. Шүгэл үлээгч ажилгүй болоод зогсохгүй эрүүл мэнд, сэтгэл зүйн асар их хохирол амсахын сацуу түүний гэр бүл, эргэн тойрныхон элдэв шахалтад өртдөг. Түүгээр ч зогсохгүй нийгмийн зүгээс ирэх эерэг, сөрөг хандлага тухайн хүнийг хаа ч тайван алхах нөхцөлгүй болгодог нь хамгийн том эрсдэл. Хуулийн төсөлд “шүгэл үлээгчийн эрсдэл, эрсдэлийн үнэлгээ”-ний талаар тодорхой бус байгаа. Иймд Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай болон бусад эрх зүйн актаар зохицуулсан ч хангалтгүй байгааг харгалзах шаардлагатай!

2026.05.11 5 ★★★★★



Г.Эрдэнэзул
Зөвийг Шүгэлдэгчид ТББ-ын тэргүүн үүсгэн байгуулагч

Н.УЧРАЛЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЕД ЭНЭ ХУУЛИЙН ТӨСӨЛ ГАЦАХ УУ, ХӨДЛӨХ ҮҮ?

Хууль зүй дотоод хэргийн яамнаас 2026 оны хаврын ээлжит чуулганаар 20 орчим хуулийн төслийг УИХ-д өргөн барихаар төлөвлөсний нэг нь Шүгэл үлээгчийг хамгаалах хуулийн төсөл бөгөөд 1-р сард хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг хийж санал авсан. Мөн 3-р сарын 25-нд Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон. Гэвч Г.Занданшатарын засаг солигдон овоо хөдөлж эхэлсэн хуулийн төсөл ахиад л хаана яваа нь мэдэгдэхгүй гацаанд орчихлоо.

2026.05.05 6 ★★★☆☆



Б.Эрдэнэдалай
МУИС, УТСОУХНУС-ийн Улс төр судлалын тэнхимийн дэд профессор, доктор

СОНГУУЛИЙН САНХҮҮЖИЛТ, КОМПАНИТ АЖИЛ, САНАЛ ХУДАЛДАН АВАЛТ ГЭХ МЭТИЙГ ХУУЛЬД ТУСГАХ ХЭРЭГТЭЙ

Шүгэл үлээнэ гэдэг зөвхөн авлига, албан тушаал зэрэг бид нарын мэддэг нийтлэг ойлголт дээр гардаг асуудал биш. Сонгуулийн санхүүжилт, сонгуулийн компанит ажил, санал худалдан авалт гэх мэт асуудлыг ярих ёстой. Парламентад хэд хэдэн удаа сонгогдсон гишүүдийн зардлын тайланг нь харахаар маш бага дүнгээр сонгуулиа хийчихсэн харагддаг. Гэтэл тэр хүн их хэмжээний мөнгийг сонгуулийн бус үед тойргийнхоо сонгогчдыг хэдэн мянгаар нь хүлээж авдаг цаашлаад цагаан сар, ахмадын баяр, багш нарын баяр, эх үрсийн баяр гэх мэт өдрүүдээр “гарын бэлэг” тараадаг нь нууц биш. Олон хүнд их хэмжээний бэлэг өгч байгаагаа сонгуулийн зардлын тайландаа тусгадаггүй. Иймд энэ асуудлыг Шүгэл үлээгчтэй холбоотой эрх зүйн зохицуулалтад тусгавал нэн сайн!

2026.05.29 6 ★★★★★



С.Будрагчаа
Сэтгүүлч

ЗӨВИЙН ТӨЛӨӨ БУРУУ ИЛЧЛЭХ ЗОРИГТОЙ БОЛООД ЭХЭЛБЭЛ МАНАЙ УЛС ЦЭНГЭЛИЙН МАНЛАЙД ХҮРНЭ

Гагцхүү Шүгэл үлээгчийн тухай хууль улс төрийн “гацаанд” орсон ганцхан шалтгаан бий. Хэн ч өөрийнхөө эсрэг хууль батлахыг хүсэхгүй. Улсын Их Хурлын гишүүдийн дийлэнх олонход энэ хууль таалагдахгүй байна. Шийдвэр гаргагчдад энэ хууль хортой үйлчлэх гээд байгаа учраас хууль удааширч, гацаад байгаа хэрэг!Өнөөдрийн нийгэмд хүн бүр шударгын төлөө ямар ч айдасгүйгээр дуугардаг болоод эхэлбэл энэ улс цэнгэлийн манлайд хүрэх нь тодорхой.

2026.05.19 1 ★★★☆☆



Х.БААСАНЖАРГАЛ
УИХ-ын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга

ЯГ ЯМАР АСУУДАЛД ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИЙГ ХАМГААЛАХ ВЭ ГЭДГИЙГ ХУУЛЬД ТОДОРХОЙ БОЛГОХ

Яг ямар асуудал дээр шүгэл үлээгчийг хамгаалах вэ гэдгийг хуульд нарийн тодорхойлох хэрэгтэй. Түүнээс бүх асуудлаар шүгэл хүлээж болно гэчихвэл Эрүүгийн хууль дээр байгаа гэмт хэрэг зөрчлийн талаарх мэдээлэл өгөх, тэр мэдээлэл нь үнэн, зөв байх гэдэг шалгалтын ажиллагаанд хүндрэл учруулж болзошгүй. Дээрээс нь үнэн, зөв эсэхийг нь ялгаж салгах хэрэгтэй болно. Энэ нь одоогийн цагдаагийн бие бүрэлдэхүүний нөөцөд төвөгтэй нөхцөл байдал үүсгэх магадлалтай. Тиймээс тодорхой сэдвээр хүрээ хязгаарыг тогтоох нь зөв. Хууль батлагдсанаар нийгэмд болж бүтэхгүй байгаа асуудал тэр дундаа авлигын асуудлууд, далд нуугдмал хэлбэртэй оршдог жендерийн хэв шинжтэй хүчирхийллийн асуудлуудыг илрүүлэхэд чухал алхам болно. Ер нь урьдчилан сэргийлэх гэхээс илүүтэй гэмт хэрэг зөрчлийг илрүүлэхэд гол түлхэц болох хууль гэж харж байгаа. Авлигатай тэмцэхэд хоёр том параллель ажил явах ёстой. Нэгт, авлига гарсны дараах илрүүлэх ажиллагааны гол механизм нь шүгэл үлээгч байж болно. Хоёрт, авлига гарахаас урьдчилан сэргийлэх нь чухал механизм байх учиртай.



Б.ӨЛЗИЙБАТ
“D-Parliament” цахим системийг санаачлагч

ХУУЛЬ БАТЛАГДВАЛ ЭРХ МЭДЭЛ НЬ ДЭНДСЭН, ШИЙДВЭР ГАРГАГЧИД ЭХНИЙ ХОХИРОГЧИД БОЛНО!

Шүгэл үлээгчийн тухай хууль улс төрийн “гацаанд” орсон ганцхан шалтгаан бий. Энэ хууль батлагдвал өнөөдрийн эрх мэдэл нь дэндсэн, шийдвэр гаргагчид хамгийн эхний хохирогчид болно. Хэн ч өөрийнхөө эсрэг хууль батлахыг хүсэхгүй. Шийдвэр гаргагчдад энэ хууль хортой үйлчлэх гээд байгаа учраас хууль удааширч, гацаад байгаа хэрэг. Энэ хууль батлагдвал Монголын нийгэм цэвэршинэ. Тухайлбал, маш олон залуучууд шударгын талд зогсож дуу хоолойгоо илэрхийлдэг болно. Мөн хэвлэл мэдээллийн салбарынхан ч шударга бусын эсрэг дуугарвал “төр биднийг хамгаална” гэдэг ойлголт суух юм. Иймд нэн тэргүүнд иргэн бүр Шүгэл үлээгчийн тухай хуулийн ач холбогдлыг ойлгох хэрэгтэй. Монгол Улсын парламент, Засгийн газрын авлигатай тэмцэх хамгийн эхний алхам нь Шүгэл үлээгчийн тухай хуулийг батлах. Үүнийг батлахгүйгээр хэдэн арван гоё нэртэй төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээд ч авлигатай тэмцэх нь зүгээр л “лоозон” төдий болж хувирна. Мянган удаа авлигатай тэмцэх гоё нэртэй үндэсний хөтөлбөр, журам гаргаад ямар ч үр дүнгүй!



С.БЯМБАХОРЛОО
СЭЗИС-ийн доктор, профессор

ЗӨВХӨН ШҮГЭЛ ҮЛЭЭГЧ ТАЛДАА АСУУДЛЫГ ХАРААД БАЙЖ БОЛОХГҮЙ! ХУУЛЬД ТЭНЦВЭРИЙГ ХАДГАЛАХ

Нэгт, Шүгэл үлээх нэрийн дор буруутай этгээд тус хуулийг өөрийгөө хамгаалах хэрэгсэл болгон ашиглах эрсдэл үүсэх вий гэдэг өнцөг. Тухайлбал, ямар нэг шударга бус үйлдлийг бусадтай хамтран үйлдчихээд тэрхүү гэмт үйлдлээ нуун дарагдуулах, өөрөөсөө холдуулах байдлаар "шүгэл үлээх"-ийг үгүйсгэхгүй! Тиймээс хуулийн төсөлд энэ эрсдэлийг тооцож, нарийвчлан харах нь зүйтэй. Мэдээж шүгэл үлээгчийг хуулийн хүрээнд хамгаалах систем байх ёстой. Гэхдээ үүнийг эсрэгээр ашигласан тохиолдол цөөнгүй байдаг учраас энэ эрсдэлийг тооцмоор байна. Хоёрт, шүгэл үлээсэн иргэнийг 100 - 1.5 тэрбум төгрөг хүртэлх мөнгөн урамшууллаар заасан. Ер нь аливаа "урамшуулал" гэдэг цаанаа шуналын болон эдийн засгийн сэдэл төрүүлэхийг үгүйсгэх аргагүй. Нэг ёсондоо, мөнгөнөөс үүдээд "шантааж" рекет" хийх боломжийг нээчих вий гэдэг нэг өнцөг. Тиймээс хуулийн төсөлд үүнийг сайтар бодолцож аль аль талдаа тэнцвэрийг хадгалах ёстой. Зөвхөн шүгэл үлээгч талдаа асуудлыг хараад байж болохгүй. Энэ хууль батлагдвал нийгэмд тодорхой хэмжээгээр "импакт" үзүүлнэ.



Б.ЦОГТГЭРЭЛ
"Шилэн данс " ТББ-ын тэргүүн

11 ЖИЛИЙН ТУРШ ШҮГЭЛ ҮЛЭЭСНЭЭР УЛСАД 600 ГАРАН ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ХОХИРЛЫГ ЭРГЭН ТӨЛҮҮЛСЭН!

Манай улс Шүгэл үлээгчийг хамгаалах, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хууль дээр фокуслаж гэмээ нь авлигын индекс дээшилнэ. Нөгөө талдаа авлигын индексийг доош нь татаж буй хэд хэдэн асуудал байна. Тодруулбал олон төрлийн өршөөлийн гэх хуулиуд. Чингис зэрэг бонд гаргачхаад түүнийгээ өршөөчихдөг. Мөнгө угааж, өөртөө давуу байдал олж авсан хүмүүс Эдийн засгийн өршөөлийн хууль батлаад л өөрсдийгөө өршөөчхөж байх жишээний. Хууль гацаад буй шалтгааны ард асар том ашиг сонирхол байгаа нь нууц биш! Миний хувьд 2015 оноос хойш 11 жил шүгэл үлээсэн. Энэ хугацаанд 600 гаран тэрбум төгрөгийн хохирлыг улсад буцаан төлүүлчихсэн байна. Хууль бус тендерүүд, хууль бус худалдан авах үйл ажиллагаатай холбоотой асуудлаар шүгэл үлээж, зогсоосон тохиолдол тоогоо алдсан. Шүгэл үлээгээд явахаар ямар ч шалтгаангүйгээр их олон дарга нар дургүй болно. Ад үзэгдэнэ, доромжлогдоно, гутаагдана. Улс төрийн бүх дэмжлэгүүдээ алдах ч тохиолдол бий! Хууль тогтоох дээд байгууллага нь шүгэл үлээгчдээ дэмжихгүй л бол ард түмний дэмжлэг нэг л өдөр зогсоно!

РЕДАКЦЫН ДҮГНЭЛТ



Б.ХОНГОРСАЙХАН
Vip 76.mn сайтын сэтгүүлч

ШҮГЭЛ ҮЛЭЭХ ЗОРИГ БАЙГАА Ч ХАМГААЛАГДАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН АЛГА!

Монгол Улсын иргэд Үндсэн хуульд заасан журамт үүрэг болох шударга байж, эх орноо хайрлан, хамгаалж буйгаараа бахархдаг байх ёстой. Атал энэ журамт үүргээ хэрэгжүүлэх явцдаа аливаа шударга бус зүйлийг илчилснийхээ төлөө хэн нэгэн эрх мэдэлтний өмнө хүчин мөхөстөж, хууль эрх зүйн боломжоо алдагдуулж эсхүл дордуулж байгаа нь нууц биш!

Монгол Улсын парламентын засаглал иргэнээ “хамгаалах” үндсэн агуулга нь Шүгэл үлээгчийн тухайн хууль. Дэлхийн бусад орнууд ч энэ хуулийг мөрдлөг болгож буй сайн туршлагуудыг экспертүүд дуу нэгтэйгээр нэрлэж байна. Иймд Парламент, Засгийн газрын авлигатай тэмцэх хамгийн эхний алхам нь Шүгэл үлээгчийн тухай хуулийг батлах. Үүнийг батлахгүйгээр хэдэн арван гоё нэртэй төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээд ч авлигатай тэмцэх нь зүгээр л “лоозон” төдий болж хувирна гэдгийг “Шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх нь” хэлэлцүүлгийн үр дүн харууллаа.

НИЙГЭМД ШУДАРГА ЁС БИЙ БОЛГОЖ АВЛИГИ БУУРУУЛАХ ЭКСПЕРТҮҮДИЙН ТОП- 7 ШИЙДЭЛ

1. Шүгэл үлээгчийг хамгаалах бие даасан цогц хуулийг улс төрийн “гацаанаас” гаргаж, нэн яаралтай батлах;

2. Хуулийн хамрах хүрээ нь авлигын шинжтэй зөрчилд түлхүү төвлөрч байна! Иймд нийтийн ашиг сонирхлыг хөндсөн бусад зөрчлүүдийг багтаах;

3. Авлигын мэдээлэл хүлээн авах, шалгах, эргээд тодорхой хугацаанд хариу өгдөг итгэл төрүүлэхүйц “систем” бий болгох;

4. Авлигыг мэдээлбэл тухайн авлигачийн учруулсан хохирлын 1 хувьтай тэнцэх урамшууллыг нэн даруй олгоод, хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэний дараа 10 хүртэл хувийг өгдөг байх;

5. Зөвхөн “хамгаална” гэж тунхаглахаас илүү ажлаас халахыг хориглох, нууцлалыг чанд хадгалах, шаардлагатай бол хамгаалалтын тусгай арга хэмжээ авахыг хуульчлах;

6. Хууль нь зөвхөн төрийн албан хаагч бус, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын хүрээг хамарсан байх;

7. Шүгэл үлээгчид хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх буюу бодит дэмжлэг үзүүлэх институтийн механизмыг тодорхой болгох;



DI FRANCO

made in italy

100 ЖИЛИЙН ТУРШЛАГА

ИННОВАЦИ, ГАР УРЛАЛЫН ҮНЭ ЦЭНЭ

100 жилийн туршлага, инноваци, гар урлалын үнэ цэнийг орчин үеийн технологитой хослуулсан **Ди Франко.**

Дээд зэрэглэлийн Италийн шир, Италийн дизайнеруудын төгс үр хийцээр бүтээгдсэн хос гутал бүр таны эрхэмсэг, дахин давтагдашгүй хэв маягийг тодорхойлно.

ИТАЛИЙН ДЭЭД ЗЭРЭГЛИЙН ШИР

ИТАЛИЙН ДИЗАЙНЕРУУДЫН ТӨГС ҮР ХИЙЦ

ИТАЛИЙН ӨВ, ЧАНАР, ИТГЭЛ

YOUR STYLE. YOUR LEGACY.

Гурван Гал Худалдааны төв – 3 давхарт

11:00–19:30

99127170
80115288

Онлайн хэлэлцүүлэг зохион байгуулагч

ХОТ ТӨЛӨВЛӨЛТ БА ХҮНИЙ ЭРХ

Хугацаа: 2026.04.20-оос 2026.05.25-ны хүртэл

Монгол Улсад хөгжлийн нэрээр халхавчлан олон жил хэрэгжүүлж байгаа хот суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл, хөтөлбөрүүд хүний эрхийн олон улсын эрх зүйн хамгаалалт, удирдлага, зохион байгуулалт, захиргааны болон шүүхийн хяналт, санхүүжилт, хүний эрхэд суурилсан гомдол барагдуулах, зөрчигдсөн эрхийг сэргээх үр дүнтэй тогтолцоо бүрдээгүйн улмаас амжилтгүй болж хэдэн мянгаар тоологдох иргэд хохирсоор байна.

Иймд үүсээд буй хүний эрхийн асуудлыг олон улсын болон дотоодын эрх зүйн хэм хэмжээнд үндэслэн тайлбарлах, шийдэл санал болгох зорилгоор Монголын Эмнести Интернэшнл НҮТББ-тай хамтран онлайн хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Оролцогч экспертүүд



Г.Лувсанжамц
УИХ-ын гишүүн




Ж.Хунан
Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн



Г.Мөнх-Эрдэнэ
МУИС-ийн докторант



Г.Түвшинжаргал
Хуульч, судлаач



Г.Ундрам
Хот төлөвлөгч



Э.Эрдэнэхишиг
“Легал гайд” фирмийн өмгөөлөгч



Б.Пүрэвсүрэн
“Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК-ийн Газрын дарга



Г.Баасанжаргал
“Хан хөгшин” ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал



Б.Нямжав
Хүний эрхийн хамгаалагч



Л.Ану-Үжин
Хот төлөвлөгч



Я.ЦЭЦЭНЗАЯА
Монголын Эмнести Интернэшнл НҮТББ-ын компанит ажлын зохицуулагч

Монгол Улсад дахин төлөвлөлтийн үйл ажиллагааг 2018 оны Хот байгуулалтын тухай хууль, 2015 оны Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай, 2025 оны Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулиудаар зохицуулж байна.

ДАХИН ТӨЛӨВЛӨЛТ ХЭНИЙГ Ч **ЯДУУРАЛД ХӨТӨЛЖ БОЛОХГҮЙ!**

Орон байр бол хүн аюулгүй, амар амгалан, нэр төртэй амьдрах орчин. Тиймээс шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг толгой хорогдох оромж, өмч төдийхөн ойлголтоор хязгаарлах нь өрөөсгөл. Энэ бол НҮБ-ын ЭЗНСЭ-ийн олон улсын пактаар хамгаалагдсан амьдралын шаардлага хангасан түвшинд аж төрөх эрхийн тухай ойлголт юм.

Орон байртай байх эрх нь төрөөс иргэддээ орон сууц барьж өг гэсэн утга хэрхэвч биш бөгөөд угтаа төр тус эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүрэгтэй бөгөөд хууль, эрх зүйн орчинд нь баталгаажуулж, хамгаалж өгөх үүрэг хүлээдэг.

Гэвч бодлогын уялдаагүй байдал, хууль тогтоомжийн хүний эрхийн хамгаалалт сул байгаагаас үүдэн дахин төлөвлөлтийн төсөл хөтөлбөрүүд бүрэн хэрэгжихгүй зогсох, хэрэгжсэн ч наад захын амьдралын шаардлага хангахгүй байгаа нь нөлөөлөлд өртсөн иргэд орон байргүй болох, газраа алдах, амьжиргаанаасаа салах, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал нь дордох, сэтгэлзүйн болон биеийн эрүүл мэндээрээ хохирох зэргээр эрхийн ноцтой зөрчилд орсон хэвээр байна.

Иргэнтэй гэрээ хийлгүйгээр газрыг нь дур мэдэн чөлөөлж барилгын ажлыг эхлүүлсэн; иргэдэд урьдчилсан, чөлөөтэй мэдээлэлтэй байдлаар хэлэлцээрт орох хангалттай цаг хугацаа, мэдээллээр хангаагүй; иргэдэд хөрөнгийн үнэлгээг нь бүрэн танилцуулаагүй; эх болон хуулбар хувиар нь өгөөгүй, нөхөн олговрыг шударгаар үнэлээгүй; гэртээ саадгүй нэвтрэх боломжгүй болгох зэргээр наад захын хэрэгцээ, тог, цахилгаан, интернэтийг нь тасалж үндсэндээ нүүхээс өөр аргагүй байдалд оруулсан бодит жишээнүүд бий. Энэ бол албадан нүүлгэлт буюу хүний эрхийн ноцтой зөрчил.

Иймд бодлого боловсруулагч, төрийн албан хаагчид дахин төлөвлөлтийн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хэнийг ч үл орхигдуулах, хэний ч амьжиргааг дордуулахгүй байх хүний эрхийн наад захын зарчмыг үйл ажиллагааныхаа бүхий л түвшинд мөрдлөг болгон ажиллах шаардлагатай байна.

Улаанбаатар хотын Ерөнхий Архитектур
Ч.Төгсдэлгэр
2025.09.24

2013 оноос хойш 44 байршилд хэрэгжиж буй ихэнх төслүүдийн хэрэгжилт

3% 5% 10%

буюу **ХАНГАЛТГҮЙ** байна.

ЭКСПЕРТҮҮДИЙН ӨГСӨН САНАЛ

Дахин төлөвлөлтийн төсөл хөтөлбөрүүдийг хэрхэн хүний эрхийн зөрчилгүйгээр хэрэгжүүлэх санал, шийдлийг дараах байдлаар дэвшүүлэв.



Г.Лувсанжамц
УИХ-ын гишүүн

ЗАСАГ ДАРГА НАРЫГ ТУХАЙН ХОРОО, ДҮҮРГЭЭС НЬ СОНГОХ ЗАМААР ИРГЭДИЙН ОРОЛЦООГ БОДИТООР ХАНГАХ

Намын, эсвэл өөр нэг харьяаллаараа доод шатны удирдлагаа нэр цохон томилох нь иргэдийн оролцоо хумигдаж, мэдээлэл хүрэхгүй байгаа, мэдээллээр хангагдахгүй байгаа эхний том асуудал гэж хардаг учраас хууль эрх зүйн хүрээнд ямар нэгэн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ 2 удаа хэлэлцүүлэг хийнэ, түүнийгээ эргэн тайлагнана гэсэн 3 үе шаттай болгоё гэсэн агуулгыг хуульд тусган үзэл баримтлалыг нь боловсруулж байгаа.

2026.04.28 | 5 | ★★★★★

ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ШИЙДВЭР ИРГЭДЭЭС ГАРЧ БАЙХ ТОГТОЛЦООНЫ ӨӨРЧЛӨЛТ ШААРДЛАГАТАЙ

Энэ гудамж, энэ хороог дахин төлөвлөлтөд хамруулахыг хүсэж байна гэсэн иргэдийн хүсэлтийн дагуу СӨХ эсвэл хорооны ИНХ, орон нутагт багийн хэмжээндээ ярилцаад дахин төлөвлөх шийдвэрийг гаргадаг болох тогтолцооны өөрчлөлт хэрэгтэй. Хот төлөвлөлтийн тухай анхдагч хуулийн төсөлдөө энэ агуулгыг тусгаад өргөн барихаар ажиллаж байна.

2026.04.28 | 3 | ★★★★★



Г.Ундрам
Хот төлөвлөгч, судлаач

ГАЗРЫГ АЛБАДАН ЧӨЛӨӨЛӨХ ЗӨВШИЛЦЛИЙН БОСГЫГ ОЛОН УЛСЫН ЖИШИГТ НИЙЦҮҮЛЭН НЭМЭГДҮҮЛЭХ

Монгол Улсад 2023 оны 12 дугаар сард яаралтай баталсан “Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль”-иар ердөө 70 хувь зөвшөөрвөл үлдсэн 30 хувийн иргэдийн өмчийг ямар нэгэн хөндлөнгийн хяналтгүйгээр орон нутгийн захиргааны байгууллага шууд албадан чөлөөлөх эрсдэлтэй эрх зүйн орчин бүрдээд байна. Олон улсын жишигт (АНУ, Герман, Япон, БНСУ) газрыг албадан чөлөөлөхийн тулд зөвшилцлийн босго 95 хувьд хүрч байж, мөн тухайн төсөл хөтөлбар “Нийтийн эрх ашгийг хангасан эсэх”-ийг нарийн тогтоож байж албадлагыг хамгийн эцсийн арга болгон хэрэглэдэг.

2026.04.24 | 3 | ★★★★★

ХАРААТ БУС ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООГ МАРГААН ТАСЛАХ ХАРААТ БУС ЗӨВЛӨЛ БАЙГУУЛАХ, ХЯНАЛТЫГ ХУУЛЬЧЛАХ ЗАМААР БҮРДҮҮЛЭХ

Маргааныг шүүхээр олон жил сунжруулж иргэнийг залхаах бус, богино хугацаанд шударгаар шийдвэрлэх, захиргааны байгууллагын дур зоргыг хянах “Газрын трибунал” эсвэл хараат бус мэргэжилтний зөвлөлийг хуульчлан байгуулах нь хүний эрхийг хамгаалах зайлшгүй шаардлага юм.

2026.04.24 | 2 | ★★★★☆

ИРГЭНИЙ ОРОЛЦООГ ХАНГАСАН ЗАСАГЛАЛЫН ШИНЭ ЗАГВАРТ ШИЛЖЬЕ

Орон нутгийн захиргааны байгууллагууд хөндлөнгийн хяналтгүйгээр төсөл хэрэгжүүлж байгаа нь нийгмийн доройтол үүсгэж, баян ядуугийн ялгааг бий болгодог тул төр иргэнээ “албадах объект” биш, шийдвэр гаргах үйл явцдаа хүндэтгэлтэй оролцуулдаг, санал бодлыг нь тусгадаг, мэдээллээр ил тод хангадаг засаглалын шинэ загварт шилжих шаардлагатай байна.

2026.04.24 | 1 | ★★★★★



Я.Цэцэнзаяа
Эмнести интернэшнл НҮТББ-ын компанит ажлын зохицуулагч

МАРГААН ШИЙДВЭРЛЭХ, ХЭЛЭЛЦЭЭ ХИЙХ, ГОМДОЛ БАРАГДУУЛАХ, ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ МЕХАНИЗМЫГ БИЙ БОЛГОХ

Нүүлгэн шилжүүлэлтийн явцад эзэмшлийн аюулгүй байдалд халдсан аливаа шийдвэр, үйл ажиллагааны эсрэг шүүх болон шударга ёсны бусад байгууллагад хандах эрхийг үр дүнтэй хангах, үүссэн эрх зүйн маргааныг хараат бус, шударга, ил тод, хүний эрхэд нийцсэн, хүн бүрд хүртээмжтэй байдлаар шийдвэрлүүлдэг механизм дутагдаж байна.

2026.05.04 | 2 | ★★★★☆

АЛБАДАН НҮҮЛГЭЛТИЙГ ХУУЛИАР ХОРИГЛОЁ!

Манай улсад албадан нүүлгэлтийг зөвшөөрч хуульчилсан. Үүнээс урьдчилан сэргийлэх, зөрчлийг шуурхай таслан зогсоохын тулд хүний эрхийн хязгаарлалтыг хэрэгжүүлэхэд баримтлах ШУДАРГА ПРОЦЕССЫН ХЭМ ХЭМЖЭЭГ хуулиар ойлгомжтой, тодорхой, хоёрдмол агуулгагүйгээр хуульчилсан байх шаардлагатай.

2026.05.04 | 1 | ★★★★☆



Л.Ану-Үжин
Хот төлөвлөгч

ИРГЭД ЭРХ АШГИЙНХАА ТӨЛӨӨ ЭВЛЭЛДЭН НЭГДЭЖ, ЭРХЭЭ ХАНГУУЛАХЫН ТӨЛӨӨ ИДЭВХТЭЙ ТЭМЦЭЖ ЧАДДАГ ХАНДЛАГЫН ӨӨРЧЛӨЛТ ХЭРЭГТЭЙ

Иргэд нүүхгүй байх эрхтэй. Зөрчигдөж буй эрхийн асуудлаар стратегийн өмгөөлөл авч, зөвшөөрөл олгосон, хүнд байдалд оруулсан төрийн захиргааны байгууллагуудын бүх түвшний мэргэжилтэн албан хаагчдыг шүүхдэх зэргээр өөрийн зүгээс боломжит арга замуудыг эрэлхийлж, зөрчигдсөн эрхээ хамгаалуулахын төлөө тэмцэгч байх хандлага нэн чухал.

2026.04.28 | 3 | ★★★☆☆



Б.Нямжав
Хүний эрхийн хамгаалагч

ХУВИЙН АЖ АХУЙ БОЛОН БИЗНЕС ЭРХЭЛЖ БАЙГАА ЭТГЭЭДИЙН БИЗНЕСИЙГ ШУДАРГААР ҮНЭЛДЭГ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХУУЛИЙН ХАМГААЛАЛТТАЙ БОЛОХ

Нөлөөлөлд өртөж буй хүмүүсийн 20-30 хувийг эзэлж буй энэ хэсэг өмчөө үнэлүүлж чадалгүй, олон жилийн туршид бий болгосон баялаг, эд хөрөнгөөрөө хохирох явдал зогсоно.

2026.04.22 3 ★★★★☆

ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙГ ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛЬЕ!

Төрийн байгууллагаас хэрэгжүүлдэг үйл ажиллагаа учраас уг хуулийн 26 дугаар зүйлд "Оролцогчийг сонсох", 26.1.3-т "Захиргааны акт, захиргааны гэрээг батлан гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгоно.", 27 дугаар зүйлд "Сонсох ажиллагааг явуулах"-ыг дэлгэрэнгүй хуульчилсан байдаг.

2026.05.20 2 ★★★★☆



Г.Мөнх-Эрдэнэ
МУИС-ийн докторант

ХОТ ТОМООХОН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХДЭЭ БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛОН НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭГ БОДИТООР ХИЙХ ЁСТОЙ

Ялангуяа эмзэг бүлгийн эрх ашигт үзүүлэх нөлөөг тооцох нь маш чухал. Хүний эрхэд суурилсан хот төлөвлөлт нь иргэдийн оролцоо, мэдээлэл авах эрх, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, соёлын болон байгаль орчны эрхийг бодлого боловсруулах түвшинд төвд нь авч үзэхийг шаарддаг.

2026.05.29 2 ★★★★★



Г.Түвшинжаргал
Хуульч, судлаач

ГУРВАН ТАЛТ ГЭРЭЭН ДЭЭР ТӨРИЙГ ТӨЛӨӨЛЖ ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОЖ БУЙ "УЛААНБААТАР ОРОН СУУЦЖУУЛАЛТ" ХХК-ИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГЫГ ТОДОРХОЙ ЗААЖ ӨГӨХ

Ингэснээр төр гаргасан шийдвэртээ эзэн болж, иргэн болоод төсөл хэрэгжүүлэгч хооронд үүсдэг маргаанаас сэргийлж чадна.

2026.05.05 4 ★★★★☆



Г.Баасанжаргал
"Хан хөгшин" ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал

ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ГЭРЧИЛГЭЭ ГАРГАХ ПРОЦЕССЫГ ТОДОРХОЙ БӨГӨӨД ХҮНДРЭЛГҮЙ БОЛГОЁ!

Төр, иргэн, ААН хооронд 3 талт гэрээ байгуулж төсөл эхлүүлсэн атал хуучин гэрчилгээг дүгнэх асуудлыг оруулж ирэх нь зохимжгүй тул төрийн байгууллагууд уялдаа холбоогоо сайжруулж энэ процессыг эргэж харах шаардлагатай.

2026.05.19 1 ★★★★☆



Ж.Хунан
Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн

ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ ГУРВАН ҮЕ ШАТТАЙ ЗАРЧМЫГ ОРХИГДУУЛАЛГҮЙ, ХАТУУ МӨРДӨХ

Хот байгуулалтын тухай болон Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулиудад тусгагдсан бэлтгэл, нүүлгэн шилжүүлэлт, бүтээн байгуулалтын үе шатуудад баримтлах хүний эрхийг зарчмуудыг мөрдлөг болговол хүний эрхийн зөрчил эрс буурна.

2026.05.25 3 ★★★★★



Э.Эрдэнэхишиг
"Легал гайд" фирмийн өмгөөлөгч

ШҮҮХИЙН ХЯНАЛТ ХЭРЭГЖИХ БАТАЛГААГ ХАНГАХ

Дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх явцад захиргааны байгууллага, төсөл хэрэгжүүлэгчдийн аль шийдвэр, үйл ажиллагааг захиргааны хяналтад, аль шийдвэр, үйл ажиллагааг шүүхийн хяналтад оруулахыг тодорхой болгох шаардлагатай. Түүнчлэн төслийн явцад нөлөөлөлд өртсөн иргэнийг албадан нүүлгэн шилжүүлэх шийдвэр нь хүний эрхийн ноцтой зөрчилд тооцогдох үндэслэлтэй тул тийм шийдвэрийг зөвхөн шүүх, захиргааны хэргийн шүүх хянабал үр дүнд хүрнэ.

2026.05.06 1 ★★★★☆

ТӨРИЙН ЗОХИХ БАЙГУУЛЛАГУУД ХОТ БАЙГУУЛАЛТАД ТУЛГАМДСАН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ БОДЛОГЫН ОЛОН ХУВИЛБАРЫГ БОЛОВСРУУЛЖ ТАНИЛЦУУЛДАГ БОЛЬЁ!

Хуульд бодлогын зөвхөн нэг хувилбарыг тусгасан нь бодлогын олон хувилбар боловсруулах төрийн үүргийг хязгаарлаж буй тул хот байгуулалтыг төлөвлөх, дахин хөгжүүлэхэд бодлого, зохицуулалтын олон хувилбар боловсруулж, тэдгээрт дүн шинжилгээ, судалгаа хийх, иргэдэд танилцуулах нь төрийн зохих байгууллагуудын үйл ажиллагааны нэг хэсэг байх учиртай.

2026.05.18 2 ★★★★☆

ХОТ ТӨЛӨВЛӨЛТӨД ИРГЭДИЙН МЭДЭЭЛЭЛ ОЛЖ АВАХ, ҮР ДҮНТЭЙ ОРОЛЦОХ ЭРХИЙГ ХАНГАЯ!

Мэдээлэл дутуу, хязгаарлагдмал нөхцөлд иргэд "эргэлзэж" эхлэх бөгөөд төслийн талаар бүрэн дүүрэн саналаа хэлж, утга учиртай оролцохын тулд захиргааны байгууллагууд хот төлөвлөлтийн төслийнхөө талаарх мэдээллийг тухай бүр, олон эх сурвалжаар иргэдэд хүргэх шаардлагатай.

2026.05.05 3 ★★★★★



Г.ЛУВСАНЖАМЦ
УИХ-ын гишүүн

ДАХИН ТӨЛӨВЛӨХ ШИЙДВЭР НИТХ-ААС БУС ИРГЭДЭЭС ГАРДАГ БАЙХ ТОГТОЛЦООГ ӨӨРЧЛӨХ

Энэ гудамжийг, энэ хороог дахин төлөвлөлтөд хамруулахыг хүсэж байна аа гэсэн иргэдийн хүсэлтийн дагуу дахин төлөвлөлтийн шийдвэр гарч байх тогтолцооны өөрчлөлтийг хийх нь зүйтэй. Орон сууцыг дахин төлөвлөхөд мөн адил. Нийслэл таны барилга ашиглалтын шаардлага хангахгүй байна гэсэн дүгнэлт гаргаад, нураагаад, шинээр барих бус СӨХ эсвэл хорооны ИНХ, орон нутагт багийн хэмжээндээ ярилцаад дахин төлөвлөх шийдвэрийг гаргах нь чухал. Хот төлөвлөлтийн тухай анхдагч хуулийн төсөлдөө энэ агуулгыг тусгаад өргөн барихаар зэхэж байна. Мөн Засаг дарга нарыг дээд албан тушаалын Засаг дарга нь томилдог хуультай. Гэхдээ хороо, багийн Засаг дарга нь тухайн харьяалалдаа оршин суугч байдаггүй. Үүнийг иргэдийн оролцоо хумигдаж, мэдээлэл хүрэхгүй байгаа, мэдээллээр хангагдахгүй байгаа эхний том асуудал гэж миний хувьд хардаг. Зүй нь тухайн хороон дээрээ асуудлыг шийдэх гэж байгаа хүн хорооныхоо оршин суугч байх ёстой.



Б.НЯМЖАВ
Хүний эрхийн хамгаалагч

ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ЭХНИЙ АЛХАМ НЬ САНАЛ АСУУЛГА ЯВУУЛАХ ҮЙЛ ЯВЦ БАЙХ ЁСТОЙ

Улаанбаатар хотын замын түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульдаа газраараа хувь нийлүүлэх журмыг албан хүчээр оруулж байгаад шийдчихсэн юм уу гэж харагддаг. Хамгийн эхний үе шат бол дахин төлөвлөлтийг энэ талбай, энэ нэгж дээр хийх шаардлага байгаа эсэхийг иргэдээс тодруулах эхний санал асуулга зайлшгүй хийгдэх ёстой. Гэтэл энэ санал асуулгыг хэрхэн явуулах тодорхой журам өнөөдрийн байдлаар байхгүй. Саналын хуудас ямар загвартай, саналын хайрцгийн аюулгүй байдал болон нууцлалыг хэн хангах, биеэр ирэх боломжгүй иргэдээс очиж саналын хуудас авах эсэх, эсвэл цахим хэлбэрээр санал өгөх зэрэг заавал байх ёстой зохицуулалт аль ч хууль, журамд тусгагдаагүй. Уг нь иргэдээс амьдрах орчноо сайжруулах уу гээд асуухаар бүгд зөвшөөрдөг. Энэ агуулгаар төрөөс явуулж байгаа үйл ажиллагааг ямар ч эргэлзээгүйгээр зөвшөөрдөг гэсэн үг. Харин төрийн байгууллагын зүгээс ийн санал авснаа иргэдийн оролцоог хангачихлаа гэж үздэг.



Г.УНДРАМ
Хот төлөвлөгч, судлаач

ИРГЭНЭЭ ХАМГААЛАХ ХӨНДЛӨНГИЙН МЕХАНИЗМГҮЙГЭЭР АЛБАДАН ЧӨЛӨӨЛӨЛТИЙГ ЯВУУЛЖ БОЛОХГҮЙ

Иргэд газраа өгөөд түр түрээсэнд гардаг ч, төсөл явахгүй эсхүл барилга ашиглалтад орохгүй олон жил гацах үед тэдний хөрөнгө "амьгүй" болох, өдөр тутмын орлогоо алдах цаашлаад ядууралд гүнзгий нэрвэгдэх зэрэг олон эрсдэлийг дагуулж байна. Энэ нь НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан зохистой орон байраар хангагдах, өмчтэй байх эрхийг ноцтойгоор зөрчиж буй хэрэг юм. Өндөр хөгжилтэй, ардчилсан орнуудад газар албадан чөлөөлөх үйл явц нь хүч түрэмгийлсэн олонхын хувьиар бус, харин иргэнийхээ өмчийг дээдэлсэн "Шүүхийн хараат бус хяналт", "Бүрэн нөхөн олговор", "Маргаан таслах хөндлөнгийн механизм" дээр тогтож байна. Гэтэл манай улсын хувьд "70/30" гэх хатуу босгоор далайлгаж, иргэнийг хамгаалах ямар ч хөндлөнгийн механизмгүйгээр, төрийн болон хувийн хэвшлийн санал, давамгайллаар асуудлыг шийдвэрлэхээр зорьж байгаа нь олон улсын хүний эрхийн стандартаас илт ухарсан үйлдэл юм.



Ж.ХУНАН
Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн

ДАХИН ТӨЛӨВЛӨЛТӨД БАРИМТЛАХ ЗАРЧИМ МӨРДӨГДӨХГҮЙ БАЙГААГААС ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧЛҮҮД ҮҮСДЭГ

Бэлтгэл үе, нүүлгэн шилжүүлэлтийн үе, бүтээн байгуулалтын гэсэн 3 үе шатаар дахин төлөвлөлтийн төсөл хэрэгждэг. Бэлтгэл үед судалгаа, тооцоолол маш чухал. Хүн өөрийн өмчөө хүссэн үнээрээ зарна. Нийтийн эрх ашгийг өмнөө барьж өмнөхөөс нь дордуулж болохгүй. Тухайн айл, өрхүүдийн саадгүй авч байсан эрүүл мэндийн үйлчилгээ, үр хүүхдийнх нь сурч, хөгжих орчин нөхцөлийг дордуулахгүй байх нарийн судалгаа, тооцооллын үндсэн дээр түр оршин суух газрыг тогтооно.
Үүний дараа нүүлгэн шилжүүлэлтийг өвөл хийж болохгүй. Шөнө хийж болохгүй. Оршин суугчид дунд хөгжлийн бэрхшээлтэй, эсвэл хэвтрийн хүн байвал стандартын дагуу зөөвөрлөх бүх бэлтгэлийг хангасан байх шаардлагууд бий. Эцэст нь бүтээн байгуулалтын дараа иргэдийн хяналт тавих боломжоор хангах нь хамгийн чухал. Төсөл хэрэгжих явцад иргэдийн зүгээс санал, гомдол гарвал шийдвэрлүүлдэг механизм ажиллах ёстой.

РЕДАКЦЫН ДҮГНЭЛТ



Б.ЦЭЦЭГСҮРЭН
Vip76.mn сайтын сэтгүүлч

ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ХӨГЖИЛ РҮҮ ТЭМҮҮЛЭХ НЬ ХАМГИЙН ЗӨВ ЗАМ

Хөдөө орон нутгаас хот руу шилжих хөдөлгөөн эрс нэмэгдэж, гэр хороолол хяналтгүй тэлснээр дэд бүтэц хүрэлцэхээ больж, хуучин барилгууд элэгдэж эхэлснээр хот дахин төлөвлөлтийн бодлого хэрэгжүүлэх шаардлагатай болсон.

Энэхүү шинэ тутам үүссэн харилцааг 2 хуулиар зохицуулж буй бөгөөд 2015 оны Хот, суурин газрыг дахин төлөвлөх тухай хуульд тусгасан дахин төлөвлөлтийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, Захиргааны Ерөнхий хуульд заасан “оролцогчийг сонсох” зэрэг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиудын хүрээнд хүний эрхийг хангахын төлөөх зүйл, заалтуудыг огт ашигладаггүй, хэрэгжүүлэхгүй байгаа нь нотлогдлоо.

Мөн хууль барьж хүний эрхийг зөрчиж буйн тод жишээг 2023 оны Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах гэр хорооллыг орон сууцжуулах тухай 9 заалттай хуулиас харж болох бөгөөд иргэдтэй бодитоор зөвлөлдөх, оролцоог хангах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх механизмыг бий болгох, шударга процессын хэм хэмжээг хангах, нүүлгэн шилжүүлэх үйл явцыг тодорхой болгох, албадан нүүлгэхийн **эсрэг хууль, эрх зүйн шинэчлэл** хийх шаардлага үүссэн байна.

Түүнчлэн дахин төлөвлөлтийн шийдвэр төрөөс бус иргэдээс гардаг байх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодлогын олон хувилбарыг боловсруулж, иргэдэд нээлттэй танилцуулдаг байх, зөвшилцөх, хэлэлцээ хийх цаашлаад маргаан шийдвэрлэх, гомдол барагдуулах, эвлэрүүлэн зуучлах механизмыг бий болгох **тогтолцооны шинэчлэл** хийхгүй бол иргэд хуулийн хамгаалалтын гадна үлдсэн хэвээр Байхыг “Хот төлөвлөлт ба Хүний эрх” хэлэлцүүлгийн үр дүн харууллаа.

“ХОТ ТӨЛӨВЛӨЛТ БА ХҮНИЙ ЭРХ” ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ОРОЛЦОГЧ ЭКСПЕРТҮҮДИЙН ТОП-10 ШИЙДЭЛ

01. Захиргааны байгууллагууд хот төлөвлөлтийн төслийн талаарх мэдээ мэдээллийг тухай бүр, олон эх сурвалжаар иргэдэд хүргэдэг болох,

02. Шүүхээр маргаан шийдвэрлэх, хэлэлцээ хийх, эвлэрүүлэн зуучлах тусгай журам тогтоох,

03. Хуульд заасан газрыг албадан чөлөөлөхийн тулд иргэдийн зөвшилцлийн босгыг 70 байгаагаас 95 хувьд хүргэн нэмэгдүүлэх,

04. Хот томоохон төсөл хэрэгжүүлэхдээ байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн үнэлгээг бодитоор хийх, ингэхдээ эмзэг бүлгийн эрх ашигт үзүүлэх нөлөөг тооцдог байх,

05. Иргэний бизнесийн орлого, амьжиргааг бүрэн хамгаалсан нөхөн олговрын нарийвчилсан стандарттай болох,


06. Дахин төлөвлөлт хийх шийдвэрт иргэдийн оролцоог хангахын тулд эхний үе шатад “Санал асуулга” явуулах үйл явцыг журамлах,

07. Гурван талт гэрээнд төрийг төлөөлж оролцож буй “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК-ийн эрх, үүрэг, хариуцлагыг тусгах,

08. Газрыг албадан чөлөөлөх үйл ажиллагааг хянах хараат бус Мэргэжилтний зөвлөлийг хуульчлан байгуулах,

09. Төр хот байгуулалтыг төлөвлөх, дахин хөгжүүлэхэд бодлого, зохицуулалтын олон хувилбарыг боловсруулдаг болох,

10. Яам, Нийслэл, Газрын алба, Улсын бүртгэл болон төсөл хэрэгжүүлэгчдийн мэдээллийн баазыг бүрэн нэгтгэсэн нэг цонхны буюу цахим тогтолцоог бүрдүүлэх,


ALPHA MARSHAL
est.2024
СБД 3-р хороо 5-р хороолол Сөүлийн гудамж
Time classic tower 1давхарт Alpha marsha
77728878

MARSHAL
RESTAURANT











MARSHAL
RESTAURANT & LOUNGE

7533 9191

marshal_restaurant_lounge

МАРШАЛ ТАУН, 143-р байрны хажуул,
Marshal Gate 4р давхар



УИХ-ын гишүүн
Д.ҮҮРИЙНТУЯА

ТӨСВИЙН БОДЛОГОО БИЧИЛ БИЗНЕСИЙГ ХӨГЖҮҮЛЭХЭД ЧИГЛҮҮЛБЭЛ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ АЙЛ БОЛГОНЫ ХААЛГААР ОРНО

Банк бус санхүүгийн байгууллагын хадгаламж зээлийн хоршооны гишүүн байх эрхийг хааснаар хоршооны бусад гишүүд дундын хадгаламжийнхаа хөрөнгөөс бага хүүтэй зээл авч, бизнесээ хөгжүүлэх, өргөжүүлэх боломжийг санхүүгийн хоршооны хуулиар олгоно.



ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЗЭЭЛИЙН ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ХАМГААЛАЛТЫН ДАВХАР ТОГТОЛЦОО 3 ДАВХАР ШАТЛАЛТАЙ БОЛЖ БАТАЛГААЖИНА


Одоо мөрдөгдөж буй Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг шинэчлэх болсны учир юу вэ?

Монгол Улс Хадгаламж зээлийн хоршооны тухай хуультай болохоос өмнө Хоршооны тухай хуулиар энэ чиглэлийн харилцааг зохицуулж ирсэн. Энэ үе тусгайлсан зохицуулалтгүйн улмаас олон хүн хөрөнгө, мөнгөөр хохирсон, үнэт амь эрсэдсэн гашуун сургамжийг бидэнд үлдээсэн юм. Энэ нөхцөл байдлыг зохицуулахаар Хадгаламж зээлийн хоршооны хуулийг 2015 онд баталж, хоршоодыг бүртгэлжүүлэх, тэдгээрт тавих шалгуур үзүүлэлт болон төрийн хяналтад үйл ажиллагаагаа явуулах зохицуулалтуудыг хуульчилж байв. Үүнээс хойш дорвитой өөрчлөлт оролгүй 11 жил болоход Монгол Улс төдийгүй дэлхийн зах зээлд крипто валютаас эхлэн олон төрлийн цахим арилжаа, худалдааны зохицуулалтууд орж ирлээ. Үүнтэй уялдуулж анхдагч санхүүгийн зах зээл болсон хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг дэлхийн жишиг стандартад нийцүүлж, олон улсын байгууллагуудай хамтарч ажиллах, тусламж дэмжлэг авах, үйл ажиллагаагаа өргөтгөх боломж гарцыг нээсэн эрх зүйн зохицуулалт шаардлагатай болсон юм. Иймээс миний бие олон улсын байгууллагатай хамтран 3 жилийн турш хийсэн судалгаанд дүн шинжилгээ, үнэлгээ хийсний үр дүнд хамгийн боломжтой хувилбарыг боловсруулж УИХ-д өргөн мэдүүлсэн.

Хуулийн нэршлийг Санхүүгийн хоршооны хууль болгон өөрчилсний шалтгаан юу вэ?

Хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаа хадгаламж байршуулах, зээл авахад

Монгол Улсад
172
хадгаламж зээлийн хоршоо байдгаас хамгийн том нь
6000
гишүүнтэй.



Үүний нийт хөрөнгийн 90 гаруй хувь нь
11
хүний нэр дээр байдаг.

чиглэдэг. Үүнийг мэргэжлийн даатгалын болон санхүүгийн зах зээлийн үйлчилгээгээр мөнгөн хөрөнгийн урсгал тооцооны хэрэгсэл болгох боломжоор ханган өргөжүүлэх, нөгөөтэйгүүр “Хадгаламж зээлийн хоршоонд мөнгө хадгалуулах нь чононд хонь хадгалуулахтай адил” гэж ерөнхий боловсролын сурах бичгээр дамжин нийгэмд буй болсон хэвшмэл ойлголт, санхүүгийн зах зээл дээрх хамгийн бичил нэгжийнхээ нэр хүндийг шавар шавхайтай хутгаж хаяснаа залруулахын тулд нэршлийг нь өөрчлөхөөс эхэлье гэж үзсэн. Боловсролын яаманд 7-р ангийн Дүрслэх урлагийн сурах бичгийг зах зээлээс татан авч, дахин гаргах боломжгүй гэдгийг мэдэгдсэн.

Хуульд тусгасан гол зохицуулалтуудаас онцолбол?

ХЗХ-нд эргэлдэж буй мөнгөн хөрөнгө баталгаатай, найдвартай болох боломжийг олгож байгаа. Хоршоонд гишүүнээр элссэн хүн бүрийн хадгаламж давхар даатгалаар хамгаалагдах тогтолцоог бүрдүүлнэ. Энэ бол хадгаламж эзэмшигчийн эрхийг хамгаалж байгаа хувилбар юм.

Дээрх тоон мэдээлэл нь газар нутаг, мэргэжлийн холбоод, ямар нэгэн сонирхлын бүлгээр ангилагдаагүйгээс болж улс орон даяар банк шиг зээл олгож байна гэсэн үг. Гэхдээ зээлийн хүү маш өндөр бөгөөд тодорхой хэмжээнд хууль эрх зүйн зохицуулалтаар хязгаарлахаар оролдож байгаа ч үр дүнд хүрч чадахгүй л байна. Иймд хоршооны гишүүн нэг л гишүүний үүрэгтэй байх бөгөөд заавал хадгаламжтай байхыг зүйлчилж байгаа.

Мөн хурлын ирцээ бүрдүүлэх нь гишүүдийн хувьд хүндрэлтэй байдаг гэж ярьдаг. Үүнийг цахимаар хуралдах боломжтой болгон шийдсэн.

2.2 САЯ ТӨГРӨГИЙН ДУНДАЖ ОРЛОГОТОЙ АЙЛ 1 САЯ ТӨГРӨГИЙН ХУДАЛДАН АВАЛТ ХИЙЖ ЧАДДАГ БОЛСОН ЦАГТ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ МОНГОЛЧУУДЫН АМЬДРАЛД АХИЦ АВЧИРНА



Банк бус санхүүгийн байгууллага нь хадгаламж зээлийн хоршооны гишүүн байж болох эрх зүйн орчин нь арилжааны банкнаас авсан зээлээ хадгаламж зээлийн хоршоогоор илүү өндөр хүүтэй эргэлдүүлэх давхар хүүлэлтийн системийг нээж өгсөн байдаг. Иймд уг системийг хаахын тулд Санхүүгийн зохицуулах хороонооос тусгай зөвшөөрөл авах замаар хоршооны гишүүн байхыг хориглохоор хуулийн төсөлд тусгасныг онцолмоор байна.

Өнөөдрийн санхүүгийн тогтолцоо хэрэглээндээ таарсан зээлийг банк, түүнээс арай давсныг нь банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, бүр боломжгүй бол аппликэйшнээс зээл авах боломжийг бий болгосон нь иргэдийг зээлийн дарамтад оруулах үндэс болоод байна. Энэхүү нөхцөл байдлыг хязгаарлах нэг боломжийг уг хуулиар олгож байгаа. Тиймээс богино хугацаанд батлах шаардлагатай.

Хадгаламж хамгаалах тогтолцоог хэрхэн бүрдүүлж байгаа вэ?

Одоо байгаа хууль нэг л хамгаалалтын тогтолцоотой. Тэр нь Эрсдэлийн сан. Гэхдээ биежээгүй, мөнгөжөөгүй бүртгэл төдий л байгаа юм. Зүй нь мөнгө дансанд биет хэлбэрээр байршиж байж эрсдэлээс хамгаалах ёстой шүү дээ. Өөрөөр хэлбэл гишүүддээ олгож байгаа хөрөнгөөс тусдаа хөрөнгө байж эргэлдэх ёстой. Хэрэгтэй үедээ бэлэн байж ашиглагдах ёстой. Гэтэл бодит байдал дээр нэг болчихоод сангийн хөрөнгө зээлээр гараад байгаа юм. Иймд тусдаа сантай болох замаар хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэхийг зорьж байна.

Хуулийн төсөл УИХ-ын түвшинд аль шатандаа явна?

Хаврын чуулганы эхэнд хэлэлцэх эсэх нь дэмжигдсэн ч байнгын хороо анхны хэлэлцүүлгийг өнөөдрийг хүртэл хийгээгүй л байна. Гэтэл өргөн баригдмагцаа батлагдах гээд явж буй хуулиуд байна. Иргэдийн амьдралд хэрэгтэй, эдийн засгийн эргэлтэд чухал нөлөөтэй хуулийг хаврын чуулганд багтаан хэлэлцэхгүй ч ирэх намар нэн яаралтай оруулж ирэх ёстой.

ЗЭЭЛИЙН ЖИЛИЙН ХҮҮ

Арилжааны банк
16.6-17.2%

Банк бус санхүүгийн байгууллага
42-50%

Хадгаламж, зээлийн хоршоо
25-27%

Цахим аппликэйнш
36-96%

Уг хууль батлагдсанаар санхүүгийн салбар хийгээд Монгол Улсын эдийн засагт ямар өөрчлөлт, дэвшил авчирна гэж харж байгаа вэ?

Улсын төсвийн 80-аад хувийг уул уурхайн салбарын орлого бүрдүүлдэг. Салбарын өсөлт буюу нүүрс, зэсний үнэ өндөр үед мэдээж эдийн засаг, ДНБ-ний өсөлт өндөр гарна. Гэвч энэхүү өсөлтийн нөлөө



ард иргэдийн амьдрал дээр огт буудаггүй. Айл, өрхүүдийн хаалгаар ордоггүй.

Макро эдийн засгийн өсөлт микро түвшиндээ очиж чадахгүй байгаа гол шалтгаан нь бид жижиг, дунд бизнес буюу жижиг санхүүгийн зах зээлээ хөгжүүлэхэд анхаарч чадахгүй байгаатай холбоотой. Энэ л жижиг хэмжээнд буй эдийн засгийн эргэлтийг дэмжих үйл явц маш чухал.

Макро, микро эдийн засаг гэхээр их хол сэдэв мэт сонсогддог тул орлогын түвшингээр ялгаатай хүмүүсийн жишээн дээр тайлбарлая. Том компанид 20-30 мянган ам.долларын цалинтай хүмүүсийн хэрэглээ, худалдан авалт, мөнгөний урсгал гадагш л чиглэдэг. Харин 2 сая 200 мянган төгрөгийн дундаж орлоготой гэр бүл хувцас, хүнс, хэрэглээгээ монголд үйлдвэрлээгүй юм гэхэд монголд авчирч, зарж байгаа хүнээсээ л худалдаж авна. Монголдоо ресторан, цайны газраа л орно. Энэ чинь л дотоод эдийн засгаа дэмжиж буй хэлбэр байхгүй юу.

Тиймээс уул уурхайн салбарын орлогын өгөөжийг жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ ялангуяа бичил бизнесийг хөгжүүлэхэд чиглүүлж чадаж гэмээ нь макро эдийн засгийн өсөлт айл өрх болгоны хаалгаар орох юм.

Сарын цалингийнхаа 1 сая төгрөгөөр худалдан авалт хийж чаддаг болсон цагт энэ нөлөөлнө. Гэтэл бид үүнийхээ 120 мянган төгрөгийг инфляцад алдаад байгаа юм. Үүний ядаж 60-ыг нь алддаг байх боломжийг жижиг зах зээл, бизнес эрхлэгчдийн хүрээ томорч байж бий болгох боломжтой.

“ ХҮН БҮРТ АВЬЯАС, УР ЧАДВАР БИЙ. ҮҮНИЙГ НЬ ҮНЭЛЖ, ХӨГЖҮҮЛЭЭД, ЧИГ ҮҮРГИЙГ НЬ ЗӨВ ХУВААРИЛЖ ЧАДВАЛ БАЙГУУЛЛАГА ТАСРАЛТГҮЙ ХӨГЖИНӨ.

Д.ЕРӨӨ
“United management consulting” ХХК-ийн гүйцэтгэх захирал

МОНГОЛ МЕНЕЖЕРҮҮД ГЛОБАЛ ТҮВШИНД МАНЛАЙЛАЛ ҮЗҮҮЛЭХЭД **СЭТГЭЛГЭЭНИЙ ХӨГЖИЛ ДУТАГДАЖ БАЙНА**

Удирдлагын ур чадвар, манлайллаас байгууллагын өсөлт хамаардаг бол менежерийн чадамж нь сэтгэлгээ болон ур чадварын нийлбэр байдаг.

Монгол менежерүүдийн потенциал, ур чадвар дэлхийн аль түвшинд, хэр зөрүүтэй яваа хийгээд давуу талаа хэрхэн тодотгож, сул талаа хэрхэн хөгжүүлж Глобал менежерийн түвшинд хүрч болохыг сүүлийн 5 жилийн хугацаанд Сэтгэл судлалын үндэсний төвтэй хамтран 1033 менежерт “Central Test» аргачлалаар хийсэн «**Монгол менежерийн дүр төрх**» судалгааны тайлангаас харж болно.

> Central Test нь хувь хүний зан чанар, ур чадвар, сэтгэл зүй болон ажлын байрны нийцлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр үнэлж, оношлох зорилготой олон улсад баталгаажсан аргачлал юм.

Уг судалгааг бие хүний 19 онцлог шинж чанар, сэтгэлгээний болон ажиллах хэв маяг, 9 бүлгийн 59 ур чадварыг шинжлэх ухааны үндэслэлтэй, бодит датад тулгуурлан боловсруулсан. Ингэснээр бид цаашдаа хүний нөөц, менежментийн талаар ярихдаа ажиглалт бус статистик тоон мэдээлэлд тулгуурладаг болох давуу талтай.

2025-2030 онд аналитик сэтгэлгээ, манлайлал, нийгмийн нөлөөлөл үзүүлэх, талент менежмент, уян хатан, дасан зохицох, даван туулах, хүн төвтэй, бүтээлч сэтгэлгээтэй байх удирдлагын ур чадварууд хамгийн үнэ цэнтэйд тооцогдож байна.

Бизнес эрхлэх боломж хүн бүрт нээгдэж, хувийн хэвшлүүд олноороо бий болох эхэн үед компанийн үүсгэн байгуулагч нь захирлын үүргээ давхар гүйцэтгэдэг байсан бол өнөөдөр сайн засаглалтай, менежмент, манлайллаар удирдуулсан, олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэх зорилготой Корпорацын түвшинд хөгжсөн олон компаниуд бий болжээ.

Тайланд дурдсанаар монгол менежерүүдийн ур чадварын ерөнхий дундаж оноо 100-аас 55 буюу хөгжих боломжтой түвшинд үнэлэгдсэн. Энэ нь өсөж дэвжих нөөц бололцоо хангалттай байгаа ч потенциалаа бүрэн ашиглаж тогтвортой өндөр гүйцэтгэл үзүүлэхэд хараахан бэлэн биш байгааг харуулж байгаа юм.

Онцолбол, менежментийн 7 хэв маягаас төслийн менежер хэв маяг 88 хувь буюу маш өндөр түвшинд илэрсэн. Энэ нь зорилго, хугацаа, хэрэгжилтэд төвлөрсөн, ажил үүргийг системтэй зохион байгуулдгийг илтгэнэ. Түүнчлэн сэтгэл хөдлөл өндөр, дүрэм журам дагаж, тогтвортой ажиллах хэв маяг мөн л өндөр түвшинд байна.

“ МЕНЕЖМЕНТИЙН БАГИЙН ТӨЛӨВШЛӨӨС КОМПАНИЙН ӨСӨЛТ ШУУД ХАМААРДАГ. МОНГОЛЧУУДАД ТУЛГАМДДАГ ХАМГИЙН ЧУХАЛ АСУУДАЛ ГЭЖ ҮЗЭЖ БОЛНО.



“МОНГОЛ МЕНЕЖЕРҮҮДИЙН 62 ХУВЬ НЬ ӨӨРЧЛӨЛТИЙГ ЭСЭРГҮҮЦЭХ ХАНДЛАГАТАЙ БАЙГАА НЬ ӨНӨӨГИЙН ХУРДАЦТАЙ ХУВЬСАЖ БУЙ ЗАХ ЗЭЭЛД ТОМООХОН СОРИЛТ ДАГУУЛЖ БАЙНА.

МОНГОЛ МЕНЕЖЕРИЙН УР ЧАДВАР

58%	47%	30%	48%	15%	21%
Анализ хийх	Бизнесийн боломжийг тодорхойлох	Шийдвэр гаргах	Хариуцлага хүлээх	Манлайлах	Бусдад нөлөөлөх

Товчхондоо, ажилчдаа хөгжүүлэх, баримтад тулгуурлах, сэтгэл хөдлөлөө зохицуулах, шинийг турших суурь давуу талтай ч, шаардлага тавих, байр сууриа тууштай илэрхийлэх, өөрчлөлтийн үед дасан зохицох, шийдвэрийг хурдан хэрэгжүүлэх зэрэгт учир дутагдалтай байгааг судалгааны үр дүн харуулсан.

Сул хөгжсөн эдгээр чадвар нь байгууллагын өрсөлдөх чадварт шууд нөлөөлөхүйц, анхаарах шаардлагатай үндсэн чиглэлүүд гэсэн үг.

Өрсөлдөх чадвараа сайжруулахын тулд дан ганц дээр дурдсан ур чадварууд хангалттай бус менежер хүн ямар хандлага, сэтгэлгээтэй байгааг үнэлж, хөгжүүлэхээс шалтгаалдаг.

Бид судалгаандаа бусдыг удирдах, өөрийгөө удирдах, өөрчлөлтийг удирдах, гүйцэтгэлийг удирдах гэсэн 4 төрөл, 19 үзүүлэлтээр судлахад сэтгэл хөдлөлөө удирдах чадвар хамгийн өндөр буюу 48% байгаа ч үүний цаана 52% нь удирдаж чаддаггүй үзүүлэлт харагдаж байх жишээтэй.

Английн Захирлуудын Институтаас захирлын чадамжийг сэтгэлгээ+ур чадвар гэж тодорхойлсон байдаг. Мөн амжилттай яваа 2500 захирлын дунд явуулсан “Ceo Mindset” судалгаагаар тэд 6 төрлийн сэтгэлгээтэй байсан бөгөөд эдгээрийг тус бүр 3, 3-н дадлаар бий болгосон гэж үздэг.

Тухайлбал, дунд шатны менежүүдээ чадавхжуулж амжилтад хүргэх сэтгэлгээ, байгууллагаа төлөөлөх сэтгэлгээ маш чухал. Бид сургалтын хөтөлбөртөө энэ агуулгыг ашиглаж байна. Үндсэндээ монгол менежерүүд маань Глобал түвшинд удирдлагын манлайлал үзүүлэхийн тулд сул ур чадваруудаа сайжруулахаас гадна сэтгэлгээгээ хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай болж байна.

М.НАНДИН-ЭРДЭНЭ
АШУҮИС, Био-Анагаахын Сургуулийн багш

НОБЕЛИЙН ШАГНАЛТАН БОЛЖ ЧАДАХГҮЙ БОЛ **НОБЕЛИЙН ШАГНАЛТНЫГ ТӨРҮҮЛЖ ЯАГААД БОЛОХГҮЙ ГЭЖ...**

Миний хувьд 2009 онд ЭМШУИС-ийг Нүүр амны Их эмчээр төгсөөд 2014 он хүртэл эх орондоо ажиллаж байгаад БНСУ-руу Докторт суралцахаар явсан. Миний очсон лаборатори нь Биотехнологи буюу Нанобиомедикал гэх эдийн инженерчлэлийн лаборатори байсан. Ингээд 2014-2020 он хүртэл Доктортоо сурч байгаад үргэлжлүүлэн ахисан түвшний Докторын дараах сургалтаа БНСУ-д үргэлжлүүлэн хийсэн юм. Постдок буюу докторын дараах сургалтын хүрээнд БНСУ-ын эрдэмтэн, судлаачдаа дэмждэг төсөл хөтөлбөрт хамрагдсан юм. Ингэхдээ тухайн улсаас 3 жилийн хугацаанд жилд 70 сая воныг туршилтын ажилдаа зориул хэмээн олгодог бөгөөд нийтдээ 210 сая воныг гаднын улсын Докторын судалгааны ажлыг дэмжих үүднээс тус улсаас олгосон гэсэн үг. Миний хувьд энэ маш том дэмжлэг байсны дээр хувь судлаачийнхаа үүднээс олон ч ажлыг хийж, хэрэгжүүлсэн гэдгийг хэлэх нь зүйтэй. Төгсөж ирээд харахад миний h-index 20 хүрчихсэн байсан. H-index гэдэг нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бүтээлүүд гаргаад, тэрхүү бүтээлүүдийг нь хүмүүс сонирхон уншсан эсэхээр нь оноо цуглуулж, түвшин тогтоодог гэсэн үг. H-index 21-тэй судлаач олон улсад нэлээд өндөр зэрэглэлтэйд тооцогддог юм билээ. Хүний бие рүү оруулангуут эс маань залгичихдаг. Нэг үгээр хэлбэл эсийг дотроос нь эмчлэх гэдэг нь энэ. Биомедикал гэдэг нь жижигхэн хэмжээстэй, гэхдээ биологийн

> **АНУ-ААС АЖИЛЛАХ УРИЛГА ИРСЭН Ч ЭХ ОРОНДОО ИРЭХ СОНГОЛТЫГ ХИЙЖ, 2023 ОНООС АШУҮИС-Д БАГШИЛЖ БАЙНА.**

Тэнд ажиллаж байхдаа амралтаараа эх орондоо очиж судалгаа ямар түвшинд, хэрхэн, яаж явагдаж байна гэдэг дээр чих тавьдаг байсан л даа. Ингээд Биотехнологийн чиглэлд манай улс дэлхийн хөгжлөөс даруй 10-20 жилээр хоцорч буйг анзаарсан. Нэг ёсондоо Монгол Улс Нано, биотехнологийн салбарыг бүр орхигдуулчихсан гэж хэлэхэд буруудахгүй. Ийм учраас л сурсан, мэдсэнээ эх орондоо нутагшуулах зорилгоор ирсэн.

Нано метр гэдэг нь нэг метрийг нэг тэрбум хуваасантай тэнцэнэ. Ийм хэмжээстэй жижигхэн материалыг гаргаж авах бөгөөд ямар ч хэлбэрт оруулж болдгоороо давуу талтай. Улмаар түүнийгээ биетээс гаргаж авсан зүйлийг хэлнэ. Сүүлийн жилүүдэд Нано технологийг дэлхий даяар маш өргөн хэрэглэдэг болчихсон бөгөөд голцуу эмнэлгийн зорилгоор л ашиглаж байгаа. Миний судалгааны ажлууд энэ мэт жижиг хэмжээст бүтээгдэхүүн дээр суурилсан. Тухайлбал, миний хувьд Солонгос улсад очоод эхний 3-4 жил судалгааг эсийн, эдийн түвшинд цаашлаад макро түвшинд хэрхэн хийдгийг сурсан. Жишээ татвал яс орлуулагч буюу скайпфолт маш олон янз гарчихсан. Хавирганаас эсхүл өөр газраас нь яс эмтэлж аваад ясыг нөхдөг байсан бол өнөөдөр ясыг эмтлэх шаардлагагүйгээр биологийн гаралтай яснуудыг олон янзаар гарган авч байна.



“ ДЭЛХИЙН УЛС ОРНУУД ЭРҮҮЛ МЭНД, ШИНЖЛЭХ УХААНЫХАА САЛБАРТ БОДЛОГООР АНХААРЧ, ХӨРӨНГӨ МӨНГӨ, ХҮЧ ХАЯЖ БАЙНА!

“ ЭРДЭМТЭН, СУДЛААЧДЫН СУДАЛГААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХЭД АНХААРЧ АЖИЛЛАХ НЭН ШААРДЛАГАТАЙ БАЙНА!



Улмаар хаана нь хэрхэн, яаж хэрэглэх вэ гэдэг дээр хөгжүүлэлт хийгддэг. Ингэхдээ нэгт, эсийн түвшинд шинж чанарыг үзнэ. Хоёрт, амьтны туршилт хийгдэнэ. Гуравт, амьтнаа томруулдаг. Хулгана байсан бол харх, нохой, гахай, сармагчин гэх мэт болгоно.Үүний дараа клиникал триал - эмнэлзүйн судалгаанд буюу хүн дээр туршиж үздэг. Эмнэлзүйн түвшний судалгаа нь 3 түвшинд хийгдсний дүнд бидний хэрэглэдэг эм, тариа, имплантууд маань эмчилгээнд нэвтэрдэг гэсэн үг. Энэ үе шатууд боллоо гэж үзвэл эцсийн байдлаар уудаг эм, тариа, материал болдог гэсэн үг. Гэхдээ үүний дараа мэдээж дараа дараагийн түвшний судалгаа, хөгжүүлэлт хийгдээд л явна. Харин манай улсын хувьд энэ талын биоматериалын хөгжүүлэлт, судалгаа бүрэн хийгдэх тал дээр нэлээд хоцорсон байгаа нь ажиглагдсан. Манай улс бол зөвхөн хэрэглэгч л байна!

Манай улс эдийн инженерчлэлийн тал дээр нийлээд хоцорсон байгаа ч олон залуус олон улсад суралцан, мэдлэгээ тасралтгүй хөгжүүлж олон улсын түвшний судалгааг хийлцэн гар бие оролцож байна.

Мэдээллийн урсгал чөлөөтэй болсны дээр хиймэл оюун ухаан ч гараад ирлээ. Иймд бид дээрх бүгдийг оновчтой байдлаар ашиглаж чадвал 20 жилийн хоцрогдлыг богиносгох боломжтой хэмээн харж байна. 2014 онд намайг оюутан байхад Нано, биотехнологийн салбарт Австрали, Англи, АНУ, Солонгос, Япон гэсэн орнууд цойлж байсан. Тэгвэл өнөөдөр Хятад улсад энэ салбар хүчээ авч байна. Учир нь төр засгаас нь эрдэмтэн, профессоруудаа нийгмийн халамж, цалин, лаборатори гэх мэтээр нь тултал дэмжсэн. Нэг ёсондоо мэдлэг, боловсролтой эрдэмтэн, судлаачдаа эх орондоо ажиллах нөөц боломжоор нь бүрэн хангасан хэрэг. Үүний дүнд Хятад улс сүүлийн арван жилийн дотор өндөр хөгжсөн орнуудтай хөл нийлүүлээд явж байх жишээний.

Тэнд хийж байсан ажлаасаа жишээ аваад, эх орондоо үргэлжлүүлэх чиглэлд ажиллаж байна. Энэ хүрээндээ нэгт, нано түвшний нано партиклыг аваад элэгний хавдрын эс дээр суурь судалгаа хийхээр ажлаа эхлүүлсэн. Энэхүү төсөл маань 1-2 жилийн хугацаанд үргэлжилнэ. Хоёрт, судалгааны эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарч ажиллах төлөвлөгөө бий. Учир нь олон улсад суралцаж мэдлэг, чадвараа дээшлүүлсэн эрдэмтэн, судлаачдаас монголд ажиллахад “хэцүү” гээд гадагшаа явсан нь цөөнгүй. Тэдгээр хүмүүс маань дор бүрнээ урдах ажлаа чимээгүйхэн хийгээд эх орныхоо нэрийг тодорхой түвшинд гаргаад явж байдаг. Ядаж тэдгээр хүмүүсийг нааш нь дууддаггүй юм гэхэд эх орондоо ирээд ажиллах үед нь хууль, эрх зүйн орчныг сайжруулах нөхцөлийг бүрдүүлэх нь нэн чухал. Намайг хэтэрхий том мөрөөдлөө гэж магадгүй л юм. Гэхдээ Нобелийн шагналтан болж чаддаггүй юм бол, Нобелийн шагналтныг төрүүлж яагаад болохгүй гэж. **Том мөрөөдөж гэмээ нь талд нь хүрнэ гэдэг дээ!**

“БАГАХАНГАЙ-ХӨШИГИЙН ХӨНДИЙ-ЭМЭЭЛТ” ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМ **ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛЖ, ТЭЭВРИЙН ШИНЭ ГАРЦЫГ НЭЭНЭ**

О.БАТЧУЛУУН
“Монголын төмөр зам” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 21, 86, 2026 оны 105 дугаар тогтоолын дагуу “Багахангай – Хөшигийн хөндий - Эмээлт” чиглэлийн төмөр замын төсөл хэрэгжүүлэхийг “Монголын төмөр зам” ТӨХК-д хариуцуулж, бүтээн байгуулалтыг 2025.04.25-нд албан ёсоор эхлүүлсэн.


“Монголын төмөр зам” ТӨХК-ийн зорилго бол үндэсний төмөр замын сүлжээг хөгжүүлэх юм. “Багахангай – Хөшигийн хөндий – Эмээлт” чиглэлийн төмөр зам нь эдийн засгийн гэхээс илүү нийгмийн ач холбогдолтой төсөл гэж хэлж болно.

Өнөөдөр Улаанбаатар хотын дундуур явж буй төмөр замаас үүдэлтэй түгжрэл өдөрт дунджаар 3-4 цагийн алдагдал үүсгэдэг. Шинэ төмөр зам ашиглалтад орсноор хот дундуурх ачаа тээвэрлэлт буурч, замын түгжрэл багасна. Мөн агаарын бохирдлыг бууруулахад эерэг нөлөө үзүүлэх юм. Манай улсын хувьд нийслэлийн төвөөр дамжуулан аюултай, шатамхай ачаа тээвэрлэж байгаа нь эрсдэл дагуулдаг. Жишээлбэл, Толгойт өртөөнд одоогоор 700–900 вагон түлш хадгалагдаж байна.

Энэхүү төмөр зам ашиглалтад орсноор эдгээр ачааг хотын гадна талд шилжүүлэх боломж бүрдэхийн сацуу бөөний худалдаа, ачаа терминалын үйл ажиллагааг Хөшигийн хөндий рүү төвлөрүүлэх нөхцөл бүрдэж буй.



2026 оны есдүгээр сард төсөл бүрэн дуусаж, анхны галт тэргийг явуулна. Нийт 127.14 км үргэлжилнэ.



1-р үе шат
(0-87,85 км)

Газар шорооны ажил	99,6%
Гүүрийн барилга, угсралт	100%
Төмөр бетон дугуй хоолой	100%
Төмөр бетон дөрвөлжин хоолой	100%

2-р үе шат
(87,85 - 127,14 км)

Газар шорооны ажил	46,3%
Гүүрийн барилга, угсралт	31,6%

ДЭД БҮТЦИЙН САНХҮҮЖИЛТЭД ШИНЭ ЖИШИГ ТОГТООЛОО

Төслийн санхүүжилтийг Засгийн газрын тогтоолоор "Монголын төмөр зам" хувьцаат компани хариуцаж байгаа. Санхүүжилтийн зарим хүндрэлээс шалтгаалан ажлын явц саатах нөхцөл үүссэн. Үүнийг шийдвэрлэхийн тулд "Монголын төмөр зам" ТӨХК 300 тэрбумын MTZ бонд гаргаж өнөөдрийн байдлаар амжилттай арилжаалагдаж дууслаа. Энэхүү бонд нь Монгол Улсад анх удаа төрийн өмчит компани өөрийн хөрөнгөөрөө батлан даан гаргасан, жилийн 17 хувийн хүүтэй эх үүсвэрээр "Багахангай-Хөшигийн хөндий - Эмээлт" чиглэлийн салбар төмөр замын санхүүжилтэд зарцуулагдах бөгөөд цаашид олон улсын банк санхүүгийн байгууллагуудаас дэд бүтцийн урт хугацаат хөрөнгө оруулалт татаж энэхүү бондоо буцаан дуудахаар төлөвлөж байна. Энэхүү санхүүжилтийн арга хэрэгсэл нь Төрийн өмчит компаниудын хувьд "Багахангай-Хөшигийн хөндий - Эмээлт" жишиг болсон. Мөн улсын төсөвт дарамт үзүүлэхгүй төсөл хөтөлбөрийг бизнесийн зарчмаар санхүүжүүлэх, олон улсын банк санхүүгийн шаардлага жишигт нийцсэн санхүү болон үйл ажиллагааны үр дүн тайлагнадаг анхны Төрийн өмчит компани болсноороо онцлог.



Монгол Улсад анх удаа

ӨНДӨР ТҮВШНИЙ ИНЖЕНЕРИЙН ШИЙДЭЛ

ТОМООХОН ГҮҮРЭН БАЙГУУЛАМЖ

ГЕОТЕХНИКИЙН НАРИЙН ТӨВӨГТЭЙ НӨХЦӨЛТЭЙ УЯЛДСАН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

амжилттай хэрэгжиж байна



"Монголын төмөр зам" төрийн өмчит хувьцаат компани нь хангайн бүсэд анх удаа төмөр замын томоохон бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд газар нутгийн онцлог, геологийн хүнд нөхцөлтэй уялдсан инженерийн олон шинэлэг шийдлүүдийг ашиглаж байгаа нь өмнөх төслүүдээс ялгарах гол онцлог болж буй.

Тухайлбал, хангайн бүсийн хөрсний тогтворжилт, гүний бүтэц нь лабораторийн шинжилгээнээс өөрөөр өөрчлөгдөх тохиолдол гарч байгаа тул геотехникийн нарийвчилсан тооцооллыг Монгол Улсын зөвлөх инженерүүд болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийж байна. Төслийн зарим хэсэгт гүн ухмал, налуу байгууламж хийх шаардлага гарч, эдгээрийг инженерийн шийдлээр үе шаттай хэрэгжүүлж байна.

Тодруулбал, төслийн онцлох байгууламжуудын нэг нь 22 метр өндөр, 226 метр урт гүүрэн байгууламж бөгөөд энэ нь Монгол Улсад анх удаа хэрэгжиж буй өндөр түвшний инженерийн шийдэл юм. Энэхүү гүүр нь галт тэрэгний ачааллыг жигд хуваарилах, газар хөдлөлт болон динамик ачааллын нөлөөг бууруулах зориулалттай бөгөөд ачаалал шингээх дэвшилтэт технологи ашиглаж байгаагаараа онцлогтой.

Төсөлд нийт **2552** техник, тоног төхөөрөмж, **95** үндэсний аж ахуйн нэгжийн **3578** орчим инженер, техникийн ажилтан оролцож байна.

DI FRANCO

made in italy



TIMELESS DISTINCTION

Сонгодог загвар, дээд зэрэглэлийн арьс, итгэл төгс алхам бурд.

PREMIUM LEATHER
Дээд зэрэглэлийн арьс

FINE CRAFTSMANSHIP
Нарийн гар урлал

DURABLE & COMFORTABLE
Хатуулаг ба тав тух

DETAILS



ELEGANT TASSEL DESIGN
Тансаг товчөн чимэглэл



HAND FINISHED
Гар аргаар өнгөлсөн



STRONG FOUNDATION
Тогтвортой, удаан эдэлгээтэй ул

Гурван Гал Худалдааны төв – 3 давхарт

11:00–19:30

99127170
80115288



Э.УУГАНБАЯР
Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга, Дэд хурандаа

ИРГЭДИЙН АЮУЛ, ЭРСДЭЛГҮЙ АМЬДРАЛЫН ТӨЛӨӨ

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, ИРГЭД, ААН БҮР ХАМТРАН ЗҮТГЭВЭЛ ҮР ДҮНД ХҮРНЭ

Налайх дүүргийн хувьд Гал түймэр, гамшиг ослын чиглэлд бусад дүүргүүдтэй харьцуулбал ихээхэн онцлогтой.

Учир нь төвийн дүүргүүд харьцангуй нэг дор төвлөрсөн байдаг бол Налайх дүүрэг нь Улаанбаатар хотын төвөөс 25-30 км зайд байршдаг бөгөөд аливаа гал түймэр, гамшиг ослын дуудлагад өөрсдөдөө байгаа хүн хүч, техник хэрэгслийнхээ норм стандартын хүрээнд үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Жил ирэх тусам улс орны хөгжил нэмэгдэж, хүн амын суурьшил тэлж байна. Үүнийгээ дагаад Налайх дүүрэг нь "аялал жуулчлалын бүс нутаг" гэдэг утгаараа гал түймэр, гамшиг ослын тохиолдол жил ирэх тусам нэмэгдэх хандлагатай байна.

Уур амьсгалын өөрчлөлт, байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, эдийн засаг, нийгмийн бусад салбарын олон талт харилцаанд тулгуурлан гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх,

НАЛАЙХ ДҮҮРГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ХҮРЧ ҮЙЛЧИЛДЭГ ЦАР ХҮРЭЭ

Налайх дүүргийн нийт 68,700 га талбай бүхий нутаг дэвсгэрт хүрч ажилладаг

Туул, Тэрэлж гол дагуу буюу аялал, жуулчлалын бүс нутагт үүрэг гүйцэтгэдэг

Төв аймгийн Эрдэнэ сум, Сэргэлэн сумын Холтын даваа, Хонхор орчмын гал түймрийн дуудлага хүлээн авч ажилладаг



НАЛАЙХ ДҮҮРЭГ НЬ 1500 ОРЧИМ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА, 40 ГАРУЙ МЯНГАН ХҮН АМ, 18 МЯНГА ОРЧИМ АЙЛ ӨРХТЭЙ ГЭР ХОРООЛОЛ ДАВАМГАЙЛСАН БҮС НУТАГ ЮМ.

шинжлэх ухаанд суурилсан гамшгаас хамгаалах тогтолцоог бүрдүүлэх, дэвшилтэт техник, технологи, инновацыг нэвтрүүлэх, гамшгаас хамгаалах чадавх, бэлэн байдлыг дээшлүүлэх зэрэг асуудал тулгамдаж байна.

Өнөөгийн байдлаар байгалийн болон хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй аюулт үзэгдэл, осол, гал түймрийн улмаас хүний амь нас эрсдэх, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирох тохиолдол буурахгүй байна. Иймд тэдгээрт нөлөөлөх хүчин зүйлийг судлах, болзошгүй гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллах нь чухал ач холбогдолтой юм.

Эрсдэлд суурилсан тогтвортой хөгжлийг хангахын тулд машин, техник хэрэгслүүдийг тухай бүрт нь шинэчилж, алба хаагчдаа тогтмол сургаж, чадавхжуулахын сацуу алба хаагчдад тулгамдаад буй нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажлын байрны таатай орчныг бүрдүүлэх чиглэлд Онцгой байдлын ерөнхий газраас шат дараалсан ажил, арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэс нь 2026 онд Шадар сайдын өгсөн үүрэг даалгавар, мөрийн хөтөлбөр, хэрэгжүүлэх ажлын чиглэл, Онцгой байдлын ерөнхий газар, удирдах бүрэлдэхүүний цугларалтаас өгсөн үүрэг, хөтөлбөр төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Түүнчлэн нийслэлийн Онцгой байдлын газрын дарга, дүүргийн Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.

Аливаа гал түймэр гамшиг ослоос урьдчилан сэргийлэхэд нөлөөллийн ажлууд нэн чухал байдаг. Энэ хүрээндээ манай хэлтсийн алба хаагчид төрийн болон төрийн бус байгууллага, иргэн аж ахуйн нэгжтэй хамтран ногоон бүс, үер усны эрсдэл өндөртэй байршилд эргүүл, хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлж, илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулан ажиллаж байна.



“НАЛАЙХ ДҮҮРГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ЭРЭН ХАЙХ, АВРАХ БҮЛГИЙГ ЭРЭН ХАЙХ, АВРАХ САЛБАР БОЛГОН ӨРГӨТГӨСНӨӨР ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ ТОДОРХОЙ ХУВИАР БУУРУУЛЖ, ГАМШГИЙН ГОЛОМТОД ШУУРХАЙ ОЧИЖ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ ЦАГ АЛДАЛГҮЙ АВАХ НӨХЦӨЛ БҮРДЭНЭ!

Налайх дүүргийн алслагдсан 1, 5, 6-дугаар хороод болох Горхи Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт жилд дунджаар 500,000 орчим гадаадын болон дотоодын аялагч ирж амардаг гэх тоон мэдээлэл бий. Үүн дээр үндэслэн Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн эрэн хайх, аврах бүлгийг өргөтгөж эрэн хайх, аврах салбар болгох хэрэгцээ шаардлага байгаа юм. Учир нь алслагдсан хороодын нутаг дэвсгэрт гарсан гамшиг, осол, аюулт үзэгдлийн дуудлагаар очиж үүрэг гүйцэтгэхэд “хугацаа алдах” шуурхай хариу арга хэмжээ авахад хүндрэл учруулдаг. Иймд дээрх нөхцөл байдлыг үндэслэн “Онцгой байдлын байгууллагын эрэн хайх, аврах нэгжид тавих шаардлага” MNS 6740:2018-д нийцүүлэн эрэн хайх, аврах бүлгийг эрэн хайх, аврах салбар болгон өргөтгөх шаардлага байгаа юм.

Д.БУМДАРЬ
МУИС, Улс төр судлалын тэнхимийн
профессор, доктор

МАНАЙ УЛС ПАРЛАМЕНТАТ ЁСНЫ ТӨЛӨВШЛӨӨР **ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ТЭГ ДУНД НЬ БАЙНА**

Парламент гэж хууль тогтоох гол эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага гэдгийг бид мэднэ. Тиймээс парламентын хөгжлийн талаар ярихын тулд засаглалын хэлбэр, хууль тогтоох эрх бүхий байгууллага хоёрын зааг, хамаарлыг ойлгох нь чухал.

Улс орнуудад парламентын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа харилцан адилгүй түвшинд хөгжиж ирсэн байдаг. Орчин үед парламентын хөгжлийг "парламент ёс"-ны төлөвшлөөр тайлбарладаг. Парламент ёсны мөн чанар нь "хууль тогтоох, нийгмийг хамаарсан шийдвэр гаргах эрх нь иргэдийн төлөөлөл буюу түүний зүй ёсны зохион байгуулалтад хадгалагдах" гэдгээр тодорхойлогддог. Өөрөөр хэлбэл, улсыг хамарсан шийдвэр буюу хууль тогтоох эрхийг зөвхөн ард иргэдийн төлөөлөл болох парламентын гишүүд эдэлдэг гэсэн үг. Төлөөллийн зүй ёсны зохион байгуулалт гэдэг нь төлөөллийг хэрхэн сонгох, парламентыг хэрхэн байгуулах, үйл ажиллагаа нь ямар дэгээр явагдах зэрэг олон үе шат бүхий, дэс дараатай үйл ажиллагааг илэрхийлдэг. Парламентын хөгжил гэдгийг манай нөхцөлд УИХ-ын сонгуулийн тогтолцоо, эрх зүйн орчноос эхлээд Их Хурлын тухай хууль, хурлын дэг, Тамгын газрын зохион байгуулалт гээд олон үзүүлэлтээр хэмждэг юм.

Эдгээр үзүүлэлтийн төлөвшлөөр манай улс дэлхийн улс орнуудтай харьцуулбал тэг дунд нь байна.

Парламентын хөгжлийн чиг хандлагыг үнэлж тодорхойлдог байгууллагын нэг нь Олон улсын парламентын холбоо (IPU) юм. Олон улсын парламентын холбоо нь улс орнуудын парламентын шинэчлэл, хууль тогтоох чадавх, хууль тогтоох үйл ажиллагаа болон мэдээллийн ил тод байдал, иргэдийн оролцоо, хяналтын талаарх мэдээллийг нэгтгэх, харьцуулах, судалж шинжлэх боломжийг бүрдүүлсэн байдаг.

Олон улсын түвшинд парламентын мөн чанарыг хэмжиж илэрхийлдэг хэд хэдэн индекс байдаг. Тухайлбал, Дэлхийн засаглалын үзүүлэлт (World Governance Indicators - WGI)-ээр гүйцэтгэх засаглалын үр дүнтэй байдлыг илүүтэй хэмждэг. Энэ нь гүйцэтгэх засаглалын үр дүнтэй байдал нь хууль тогтоох байгууллагын чадавхаас хамаардаг гэж үздэгтэй холбоотой.

Мөн Бертелсманы өөрчлөлтийн индекс (Bertelsmann Transformation Index - BTI)-ээр эрх мэдлийн хуваарилалт, парламентын хяналт зэрэг үзүүлэлтийг хэмждэг.

Гэхдээ, судлаачид олон улсын засаглалтай холбоотой эдгээр индексийг тодорхой улс орон, үндэстэн, бүс нутгийн онцлог хүчин зүйлсийг тооцож чадсан эсэх дээр онолын шүүмжлэл өрнүүлсээр байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Улс төрийн шинжлэх ухаанд "төлөөллийн засаглалыг зохион бүтээсэн" явдал нь орчин үеийн улс төрийн гол ололт хэмээн үздэг. Тиймээс парламентын засаглалыг тал бүрээр засан залруулж, төгөлдөржүүлж байх учиртай юм.

> **"2025 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙГ БАТЛАХ ҮЙЛ ЯВЦ НИЙГМИЙН АНХААРЛЫН ТӨВД ОРСОН НЬ НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД, ОЛОН УРГАЛЧ БАЙДАЛ, ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮДИЙН ТООНЫ ХУВЬД ТӨЛӨӨЛӨХ ЧАДВАР САЙЖИРСНЫ ИЛРЭЛ ЮМ.**

Манай улсын хувьд парламентын гишүүдийн тоог нэмж, сонгуулийн тогтолцоог холимог болгосон нь зөв шинэчлэл. Ээлжит сонгуулийн дараа "сонгогчдын санал гээгдэж байна, хүсээгүй улстөрчид сонгогдлоо, нөгөө л хэдэн нам, нөгөө л хэдэн улстөрчид..." гэж шүүмжлэх нь бий.

Энэ мэт шүүмжлэл бол зүй ёсны зүйл. Гэхдээ хамгийн чухал нь парламентын төлөөллийн чадавх, парламентын үйл ажиллагааны чадавхыг хангах ёстой. Яагаад



Манай улсын хувьд 2012, 2024 оны сонгуулийн үр дүнд бүрэлдсэн парламентын Херфиндалын индекс 0.3-0.41 хооронд гарч байгаа. Харин өмнөх долоон удаагийн сонгуулийн дүнд бүрэлдсэн парламентын индекс 0.45-0.89 хооронд байсан. Эндээс өнөөгийн сонгуулийн холимог систем нь олон намын тогтолцоог илүүтэй харгалзсан гэдэг нь харагддаг.

гэвэл нийгмийн эрэлт хэрэгцээг илүүтэй илэрхийлсэн парламентын төлөөлөл нь тэр эрэлт хэрэгцээнд нийцсэн хууль тогтоомжийг гаргаж, түүнийг хэрэгжүүлэхийн төлөө ажиллана. Тэгэхээр энэ логикоор авч үзвэл, 76 гишүүнтэй байх үеийн парламентын үйл ажиллагаа, 126 гишүүнтэй парламентын үйл ажиллагааны үр нөлөө ямар нэг хэмжээгээр харагдана.

Зөв шинэчлэл гэсэн дээрх дүгнэлтийг улс төрийн шинжлэх ухаанд хэрэглэгддэг "Herfindahl Index" гэдэг үзүүлэлтээр тайлбарлаж болно. Энэ индексээр улс төрийн намуудын парламент дахь суудлын эзлэх жин, парламентын чадавх, намын тогтолцооны идэвхтэй байдлыг хэмждэг юм. Үнэлгээний тоон утга нь 0-1 хооронд байдаг. Тоон утга 0-д тэмүүлэх тусам парламентыг олон ургалч гэж үздэг. Харин тоон утга нь 1 рүү тэмүүлж байвал ганц юм уу, цөөн намын давамгайлал үүссэн байна гэж үздэг.

Манай өнөөгийн парламентын төлөөлөх чадвар гишүүдийн тооны хувьд өмнөхөөсөө өргөжсөн, парламентын мэтгэлцээн илүү өрнөж, асуудлыг олон талаас авч үзэж байгаа, нээлттэй-ил тод байх тал дээр сайжирсан гэж судлаачийн хувьд би үзэж байгаа. 2025 оны улсын төсвийг батлах үеэр энэ давуу тал харагдсан. Шинэ бүтэц зохион байгуулалтад орсон анхны парламент учраас нэг өдөрт төгс төгөлдөр болчихгүй нь илэрхий. Төгөлдөржих, мэргэших үйл явц аажим явагдана.

"НАМУУДЫН ЖАГСААЛТАД НЭР ДЭВШҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ ИЛ ТОД, ЖУРАМ НЬ ТОДОРХОЙ, ДОТООД АРДЧИЛАЛТАЙ БАЙХЫГ ШААРДСАН ХУУЛЬ ТОГТООМЖ БИЙ. УЛС ТӨРИЙН НАМУУД НЭР ДЭВШҮҮЛЭХ ЖУРМАА МӨДХӨН ЦАХИМ САЙТАД БАЙРШУУЛАХ БИЗ ЭЭ.



Б.БАТТОГТОХ
Татварын хуульч

ТАТВАРЫН ХУУЛИЙГ ДАН ГАНЦ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТӨӨР БУС БАГЦААР НЬ **ДАХИН СИСТЕМЧЛЭХ ШААРДЛАГАТАЙ**

“МИНИЙ ХУВЬД ТАТВАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСНААР ДОРВИТОЙ ШИНЭЧЛЭЛ ХИЙГДЭНЭ ГЭЖ ҮЗЭХГҮЙ БАЙГАА.

Сүүлийн хоёр жилийн дотор хоёр удаа засгийн газар унаж, гурвантаа солигдлоо. Гэтэл 2024-2028 оны хооронд бүрэлдсэн парламент нь одоог хүртэл иргэд болон баялаг бүтээгч нартаа тус дэм болчих хуулийг батлуулж чадаагүй л байна. Энэ хаврын чуулганаар «Татварын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл» -ийг баталлаа. Хэдийгээр Засгийн газраас татвар төлөгчдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилготой хэмээн тайлбарлаж байгаа ч салбарын эксперт миний хувьд зарим зүйлс дээр дараах байр суурьтай байна.

Хуулийн төсөлд «уян хатан хандах», «орлогын тодорхой хувийг суутгах» гэх мэт ерөнхий найруулгууд нь хэт тунхгийн шинжтэй. Гэтэл иймэрхүү тунхгийн шинж чанартай зохицуулалт их орох тусам хөрсөн дээр буухдаа эргэлзээтэй нөхцөл байдал буюу талуудад маргаан үүсдэг. Уг нь аливаа хуулиар тодорхой зохицуулалтыг гаргаж өгөх нь хэрэгжүүлэгч тал болон аж ахуй нэгж, хувь хүнд амар хялбараар хуулийг дагаж мөрдөх нөхцөл болдог. Ингэснээр гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага болох татварын алба эсвэл улсын байцаагч нар өөрийн өнгө үзэмжээр асуудалд хандах боломжгүй, зөвхөн хуулиа мөрдөж ажилллах нөхцөл бүрэлддэг. Гэтэл Засгийн газраас өргөн барьсан энэхүү нэмэлт өөрчлөлтөд тийм зүйлс үнэхээр дутмаг байгаа нь эргээд маргаан үүсэх гол шалтгаан болох юм.

> **ХАРИН ОЛСОН МЭДЭЭЛЛЭЭ ЭРХ МЭДЛИЙН ХҮРЭЭНД ДАВУУ БАЙДАЛ БОЛГОН АШИГЛАХЫГ ХУУЛИАР НАРИЙВЧЛАН ЗОХИЦУУЛАХ НЬ ЧУХАЛ.**

Түүнчлэн татварын байгууллага нь иргэд, аж ахуйн нэгждээ хэрхэн хатуурхаж, хүнд суртал гаргадаг байсныг 2022 онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийсэн судалгаагаа харуулсан. Тус судалгаанд татвар төлөгчдийн 25% нь татвар төлөх хугацааг «уян хатан биш» , 18% нь «сургалт, зөвлөгөө өгдөггүй» гэж дүгнэжээ.

Нэг талаас татварын албанаас зөвлөгөө авах явцад өгсөн мэдээллийг өөрсдийнх нь эсрэг ашиглахвий гэдэг айдас, болгоомжлол татвар төлөгч нарт байдаг. Энэ асуудлыг л хуулинд маш нарийвчлан зохицуулахгүй л бол татвар төлөгчийн эрх ашиг, сонирхлыг зөрчих тохиолдол гарч болзошгүй. Гэтэл нэмэлт өөрчлөлтөд уг баталгааг хангасан зохицуулалт бас л байхгүй. Мэдээж татварын алба нь зөвлөх болон хяналт шалгалтын чиг үүргийг хавсран хэрэгжүүлэх нь ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй. Угаас Татварын ерөнхий хуульд татварын албаны чиг үүргийг:

1. **Татварын хууль тогтоомжийг сурталчлах тайлбарлан таниулах.**
2. **Хэрэгжилтэд нь хяналт тавих.**
3. **Төсвийн орлогыг бүрдүүлэх гэж заасан байдаг. Тиймээс энэ чиг үүргээ баримтлах нь хуульд нийцнэ. Харин олсон мэдээллээ эрх мэдлийн хүрээнд давуу байдал болгон ашиглахыг хуулиар нарийвчлан зохицуулах нь чухал.**

Өөр нэг чухал зүйл нь өмнө нь боловсруулсан төсөлд “Татварын албаны дэргэдэх маргаан таслах зөвлөл”-ийн үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр зохицуулалтыг тусгаж оруулж ирсэн ч сүүлд өргөн баригдсан төсөлд энэ зохицуулалт бүхэлдээ хасагдсан. Гэхдээ хасагдсан зохицуулалт дотор маргаан таслах зөвлөлийг Сангийн яамны дэргэд ажиллуулах зохицуулалт байгаагүй юм.

Ер нь татварын маргаан таслах зөвлөлийн хувьд бусад ижил төстэй гомдлыг урьдчилан шийдвэрлэх бүтцээс харьцангуй үйл ажиллагаа нь жигдэрсэн гэж хэлж болно. Гэхдээ цаашид маргаан таслах зөвлөлийн үйл ажилагааг боловсронгуй болгох, хараат бусаар ажиллах нөхцөл боломжийг дээшлүүлэх чиглэлд анхаарах зүйлс байгаа. Тухайлбал, маргаан таслах зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газрын тогтоолоор баталдаг. Харин миний хувьд журмаар бус хуулиар зохицуулах шаардлагатай гэж үздэг. Энэ талаар манай Монголын Хуулчдын Холбооны Захиргааны эрх зүйн хорооноос хэлэлцүүлэг зохион байгуулж оновчтой санал, зөвлөмжийг хууль тогтоогчид хүргүүлж байсан. Гэхдээ энэ хуулийн төсөлд тэр зөвлөмжөөс оруулсан зүйл алга байна.

Эцэст нь тэмдэглэхэд миний хувьд татварын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулснаар дорвитой шинэчлэл хийгдэнэ гэж үзэхгүй байгаа. Өөрөөр хэлбэл татварын хууль тогтоомжийг дахин системчлэх, хууль хоорондын уялдаа хангах байдлаар тодорхой цаг хугацаанд тандан судалгаа, дүн шинжилгээ хийж, бүх талын оролцоо, эрх ашгийн тэнцэврийг хангасны үндсэн дээр татварын хууль тогтоомжийн багц хуулийн төслийг боловсруулах шаардлагатай.

Түр зуурын аргацаасан зүйлс нь эргээд урт хугацаандаа тогтворгүй байдлыг үүсгэж байдаг. Мэдээж энэ бүхнийг хийхийн тулд хүний нөөц, цаг хугацаа, төсөв хөрөнгө шаардагдана. Гэхдээ л татварын хууль тогтоомжийг багцаар нь өөрчлөх л хамгийн зөв шийдэл.



УИХ-ын гишүүн, хууль санаачлагч П.Батчимэг

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.
Батлагдсан огноо: 2026.06.12

18 НАС ХҮРСЭН ИРГЭД СКҮҮТЕР, МОПЕДООР ЗОРЧИХЫГ ЗӨВШӨӨРӨХӨӨР ХУУЛЬЧИЛЛАА

Хүн амын хэт төвлөрөл, хотын автозамын түгжрэлээс улбаалан Улаанбаатар хотод нийтийн хэрэглээний цахилгаан дугуй, скүүтер түрээсийн шинэ төрлийн үйлчилгээ бий болоод буй. Иргэдийн хэрэглээний огцом өсөлт, хууль, эрх зүйн хүрээний зохицуулалтгүй байдал нь энэ төрлийн тээврийн хэрэгслээс үүдэлтэй осол гэмтлийн тоо 6 дахин өсөж, амь насанд хүрэх эрсдэл дагуулж буй тул УИХ-ын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, 2026 оны зургаадугаар сарын 12-ны өдөр УИХ-ын нэгдсэн чуулганаар батлууллаа.



Хуулийн төсөлд мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд унадаг дугуйтай адил дүрмээр зорчихоор зохицуулжээ. Харин суррон буюу цахилгаан дугуйг мотоциклтэй адилтган үзэж, холбогдох дүрмийг дагуу зорчих аж.





Хуулийн төслийг 2025 оны долдугаар сарын 03-ны өдөр өргөн мэдүүлэв.

Хуулийн ОНЦЛОХ ЗААЛТУУД:

- 18 нас хүрсэн хүн жолоодож замын хөдөлгөөнд оролцоно
- Унадаг дугуйн зам, эсвэл замын зорчих хэсгийн баруун хөвөөгөөр жолоодно
- Явган хүний гарцаар тээврийн хэрэгслээ түрж гарна
- Жолооч нь сургалтад хамрагдаж, мэдээллийн санд бүртгүүлсэн байна
- Скүүтер, суррон, мопедыг автотээврийн хэрэгслийн бүртгэлд бүртгүүлнэ
- Нийтийн түрээсийн эрхлэгч нь хариуцлагын даатгалд хамрагдсан байна

АНХААРАХ ЗААЛТУУД

- 18 нас хүрээгүй хүүхэд замын хөдөлгөөнд оролцсон бол эцэг эх асран хамгаалагчийг 200 мянган төгрөгөөр торгоно.
- Тээврийн хэрэгслээ жолоодож явган хүний гарцаар зам хөндлөн гарсан бол 50 мянган төгрөгөөр торгоно
- Согтуурсан мансуурсан үедээ жолоодсон бол 100 мянган төгрөгөөр торгоно
- Бусдын эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 100 мянган төгрөгөөр торгоно.

Энэ төрлийн осол, гэмтэл

2022 онд
50

2023 онд
305

2024 онд
532

2025 онд
2792



УИХ-ын гишүүн,
Ажлын хэсгийн ахлагч
Г.Уянгахишиг:

Бид хуулиа баталж болох ч энэ бүхний цаана Нийслэлээс хийх ёстой дэд бүтцийн асуудал орхигдоод байгааг дурдах ёстой. Замын хөдөлгөөний дүрмээр нарийвчлан зохицуулах нь эрх зүйн хувьд зөв. Тэднийг замын хөдөлгөөнд оролцоход дүрмийн мэдлэг, сургалт хэрэгтэй.



УИХ-ын гишүүн, хууль санаачлагч
Г.Лувсанжамц:

Хуулийн төслөөр шийдэхийг зорьж буй гол асуудал нь хүүхдүүд бэртэж гэмтэх, хаа сайгүй скүүтер, мопедоо орхиж яваад байгаа явдал юм. Жолооны А, Б үнэмлэхтэй бол мопед ашиглаж болох зохицуулалтыг E-Mongolia системд тулгуурлан хэрэгжүүлэх нь хамгийн хялбар, оновчтой шийдэл байх болно.



УИХ-ын гишүүн, хууль санаачлагч Д.Рэгдэл

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
Батлагдсан огноо 2026.05.01

ШУ-НЫ САЛБАР ИХ ӨГӨГДЛИЙН САНТАЙ БОЛСНООР ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТ САЙЖИРНА


Үндсэн хууль, урт хугацааны томоохон бодлогууддаа төсвийн бодлогоос эхлээд Засгийн газрын бүхий л бодлого шийдвэр шинжлэх ухаанд тулгуурлан гарах ёстой хэмээн тусгасан ч манай улсын шинжлэх ухаан эдийн засагжаагүй, эдийн засаг шинжлэх ухаанжаагүй хэвээр байна. Дэлхийн улсууд ДНБ-ийхээ 2 хувийг шинжлэх ухаан технологийн салбартаа төсөвлөдөг бол манай улс 0.1 хувийн санхүүжилт өгчихөөд далайцтай судалгааны үр дүн, инновац, патент хүлээх нь өрөөсгөл юм. Гэсэн хэдий ч төсвийн хуваарилалтыг шударга, өрсөлдөөний зарчимд нийцүүлэх, монгол эрдэмтэн судлаачдын ур чадвараа ахиулах бололцоог нээсэн, судалгаа, мэдээллийн төвлөрлийг бий болгох зорилгоор Шинжлэх ухаан технологийн хуульд 2 багц өөрчлөлт оруулж УИХ-аар батлууллаа.

1. СУДАЛГААНЫ НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН САНТАЙ БОЛНО.

Улсын хэмжээнд төсвийн хөрөнгөөр, төрийн өмч болон орон нутгийн өмчийн оролцоотойгоор хийгдэж буй судалгаа шинжилгээний ажлуудын бүх тайланг хадгалдаг мэдээллийн нэгдсэн сантай болсноор уг судалгааг авах, ашиглах сонирхолтой этгээдүүдэд өгөх дэд бүтэц бий болж, Их өгөгдлийн сан болон хөгжих суурь тавигдлаа. Мэдээллийн бүрэн бүтэн байдал нэг дор байна гэдэг нь түүнийг ашиглалт сайжирна гэсэн үг. Инновац, хиймэл оюун нь их өгөгдөлд суурилдаг. Хэдий чинээ өгөгдлийг зөв зохион байгуулна төдий чинээ эдийн засгийн эргэлтэд оруулах оновчтой шийдлүүд гарах юм.

2. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУД ТЕНДЕРТ ОРОЛЦОХ БОЛОМЖ НЭЭГДЛЭЭ.

Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагууд Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад оролцохдоо тендерийн болон гүйцэтгэлийн баталгаа гаргах шаардлагаас чөлөөлөгдөх юм. Ингэснээр төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагуудад улсын төсвөөс судалгаа хөгжүүлэлтийн ажилд зориулдаг 50 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаас нэмэлт санхүүжилт татах, төсвийн эх үүсвэрээ өргөжүүлэх боломж бүрдэхээс гадна хамгийн том ололт нь монгол эрдэмтэн судлаач, инженерүүдийн ажил гүйцэтгэх потенциал, ур чадвар нэмэгдэж буй явдал юм.



Монгол Улсад Шинжлэх Ухааны Академийн төв, хүрээлэнгүүд, Яамдын харьяа улсын эрдэм шинжилгээний байгууллагууд болон их, дээд сургуулиудын дэргэдэх судалгааны хүрээлэн, төвүүд нийлсэн **60** орчим төрийн өмчит ЭШБ бий.

Монгол эрдэмтдийн 1200 гаруй бүтээл олон улсын нэр хүндтэй сэтгүүлд хэвлэгдэж, 20,000 гаруй удаа ишлэгдсэн байна. Шинжлэх Ухааны Академи авлигаас ангид бүс болж чадсан. Одоо боловсон хүчнээ дэмжчихэд өрсөлдөх чадвараа ахиулах бүрэн боломжтой.



УИХ-ын гишүүн,
Ажлын хэсгийн гишүүн
А.Ариунзаяа:

Эрдэм шинжилгээний ажил дан ганц сургуулийн, эсвэл ШУА-ийн асуудал огт биш. Боловсрол шинжлэх ухааныг шүтье, дээдэлье, дэмжье гэж үзэж буй бол хуулийн зөрчлүүдийг нэн тэргүүнд арилгах шаардлагатай.



УИХ-ын гишүүн
Ж.Галбадрах:

Төрийн бодлогоор их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагаа дэмжин ажиллахад энэ хууль чухал нөлөө үзүүлнэ. Хөгжих боломж нь нээгдэж байна. Хамгийн дэвшилттэй өөрчлөлт нь тендерт оролцох нөхцөл бүрдэж буй явдал юм.

Нийгмийн ажлын тухай анхдагч хууль
Өргөн мэдүүлсэн огноо: 2025.12.17

“ХАЛАМЖААС-ХӨДӨЛМӨРТ” БОДЛОГЫН ХӨДӨЛГӨГЧ ХҮЧ НИЙГМИЙН АЖИЛТАН МЭРГЭЖИЛ “ДАРХЛАГДЛАА”

Хүүхэд, гэр бүлийг хамгаалах тогтолцоог бэхжүүлэхэд хамгийн чухал үүрэг гүйцэтгэгч бол нийгмийн ажилтан. Анхан шатны нэгжид халамжийн цогц үйлчилгээг үзүүлж буй эдгээр хүмүүс мэргэжлийн үнэлэмж, нийгмийн баталгаа, хууль эрх зүйн хамгаалалтгүй байгаа нь Халамжаас-Хөдөлмөрт бодлогын хөдөлгөгч хүч сул байгааг илтгэнэ. Учир нь салбараасаа шалтгаалан төрийн албан тушаалын ангилал өөр байдгаас цалин хөлс, үйлчилгээний төрөл, хэлбэр, мэргэжлийн хувьд ахих, дэвших боломж нь эрс ялгаатай.

Нийгмийн халамжид буй эмзэг бүлгийн иргэнийг чадавхжуулах, хүнд нөхцөлөөс гарахад нь мэргэжлийн дэмжлэг үзүүлэхэд төвлөрөн ажиллах бололцоог сууриар нь бүрдүүлж өгөхийн тулд тусгайлсан хууль шаардлагатай болсноор УИХ-ын О.Саранчулуун нарын 24 гишүүн Нийгмийн ажлын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүллээ.



УИХ-ын гишүүн, хууль санаачлагч О.Саранчулуун

Нийгмийн ажлын үйлчилгээ нь халамжийн зардлыг 10-20 хувиар бууруулах боломжтой.

Эх сурвалж: Дэлхийн банк

2025 оны 1 дүгээр сараас сум, хорооны нийгмийн ажилтан, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог Засгийн газраас тогтоон **770** албан хаагч ТҮМ 4 зэрэглэлээр ажиллаж, **1.3** сая төгрөгөөр цалинжиж буй бол хөдөлмөрийн хэлтсийн ажилтнуудын зэрэглэл **ТЗ 8, 9** буюу салбарынхаа дунджаас **60** хувь бага хэвээр байна.

2026 оны эхний улирлын байдлаар Монгол Улсад боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, нийгмийн халамж, нийгмийн хөгжил, хүүхэд гэр бүлийн хөгжил хамгаалал, хууль зүйн салбарт нийт **3000** гаруй нийгмийн ажилтан ажиллаж байгаагаас **60** гаруй хувь нь өөр мэргэжлийн хүмүүс, **80** хувь нь төрийн албан хаагчид байна.

Олон улсын туршлагаар нэг нийгмийн ажилтанд ногдох хүн амын тоо **1000-1500** бол манай улсад **3000-5000** буюу **2-3** дахин өндөр.



УИХ-ын гишүүн О.Саранчулуун нарын 24 гишүүнээс 2025 оны 12-р сарын 17-ны өдөр Нийгмийн ажлын тухай анхдагч хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэв.

Нийгмийн ажлын тухай анхдагч хууль нь салбар бүрийн нийгмийн ажлын үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн нэгдсэн бодлого, стандартад оруулах үндсэн зорилготой бөгөөд дараах өөрчлөлтүүдийг авчирна.

Мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулна:

Нийгмийн ажилтнуудыг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, ёс зүйн болон мэргэжлийн нэгдсэн стандартаар ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

Үйлчилгээг төрөлжүүлнэ:

Нийгмийн ажилтныг салбар тус бүрээр төрөлжүүлэн нарийн тодорхойлж, хэрэгцээнд суурилсан тусламж үйлчилгээг хүргэхээр заасан.

Салбар хоорондын уялдааг хангана:

Өмнө нь 13 өөр хуулийн заалтаар тархай бутархай зохицуулагддаг байсан нийгмийн ажлын үйлчилгээг нэгтгэж, нэгдсэн мэдээллийн сантай болсноор салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулна.

Эрх хамгаалах ба урьдчилан сэргийлэх:

Өөрийгөө төлөөлөх чадваргүй иргэд, хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэм чанар, нэр төрийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг онцгойлон тусгасан байна.



Гэр бүл, хөдөлмөр нийгэм хамгааллын сайд

Т.Аубакир:

НҮБ-ын Хүүхдийн сангийн судалгаагаар нийгмийн ажлын үйлчилгээ сайн хөгжсөн улс орнуудад хүүхэд хамгааллын эрсдэл 20-40 хувиар буурдаг. Монгол Улсад анх удаа Нийгмийн ажлын тухай бие даасан хуулийн төслийг боловсруулан өргөн мэдүүлсэн нь нийгмийн хамгааллын салбарт шинэчлэлийг хэрэгжүүлэх суурь болно.



УИХ-ын гишүүн, хууль санаачлагч

А.Ариунзаяа:

Халамжид хамрагдаж буй хүмүүсийн давуу талыг нь хөгжүүлж чадвал хөдөлмөр эрхлэх нөөц бололцоотой нь цөөнгүй. "Нийгмийн ажил" мэргэжлийн гол үнэ цэн нь энэ давуу талуудыг нь илрүүлж, нөхцөл байдлын үнэлгээ хийснээр ирээдүйд амьдралдаа эзэн болох алхам руу нь хөтөлж, сайн сайхан амьдрах үндсийг нь суулгаж өгөхөд оршдог.



Б.БАЯРБААТАР
УИХ-ын гишүүн, Ажлын хэсгийн ахлагч

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль
Батлагдсан огноо:2026.05.08

НЭГ АМЬГҮЙ ДОНОР 8 ХҮНИЙ АМЬ НАС АВРАХ БОЛОМЖТОЙ

Өнөөдөр дэлхийн жишиг амьд донороо хамгаалж амьгүй донорыг олноор илрүүлэх алхам руу явж байна. Тийм учраас дэлхийн 93 улс оронд эрхтэн, эд эс шилжүүлэн суулгах эмчилгээг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд 90 орон тус эмчилгээний талаарх бие даасан хууль тогтоомжийг баталжээ.Үүний нэг нь манай улс болж, “ЭРХТЭН, ЭД, ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ТУХАЙ” анхдагч хуулийг баталсан юм.

Монгол улс 2006 онд анхны бөөр шилжүүлэн суулгах мэс заслыг амжилттай хийсэн. 2023 оны байдлаар **331** иргэнд бөөр, **262** иргэнд элэг, **29** иргэнд ясны чөмгийн үүдэл эс, **24** иргэнд нүдний эвэрлэг, **735** иргэнд арьс, **150** гаруй иргэнд шөрмөс, **373** иргэнд үр шилжүүлэн суулгасан байна.



Эрхтэн, эд эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийг (2025.03.31) өргөн барив



Хууль батлагдсанаар:

- Иргэдийн эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг эх орондоо хийлгэх боломж нэмэгдэнэ
- Хүйн цус, эд, эсийн сан бий болж, зарим хүнд өвчнийг эмчлэх шинэ боломж нээгдэнэ
- Амьгүй донорын эрх зүйн зохицуулалт тодорхой болж, хүний эрх хамгаалагдана
- Эрхтэн, хүний наймаанаас сэргийлэх хатуу хяналт, хууль эрх зүйн орчин бүрдэнэ
- Шилжүүлэн суулгах эмчилгээний үйл явц нэг мөр, ойлгомжтой эрх зүйн орчинд орно
- Эмч, мэргэжилтнүүдийн шийдвэр гаргалт эрсдэл багатай, хариуцлага тодорхой болно
- Донор, реципиенттай холбоотой ёс зүйн асуудлыг хуулиар хамгаалсан тогтолцоо бүрдэнэ
- Салбарын хүний нөөц, мэргэшлийг тогтвортой хөгжүүлэх суурь нөхцөл бий болно
- OPT IN / OPT OUT холимог тогтолцоо нэвтэрнэ
- Амьгүй донорын ар гэрт оршуулгын тэтгэмж олгох боломж бүрдэнэ



УИХ-ын гишүүн, Ажлын хэсгийн ахлагч

Б.Баярбаатар:

Өнөөдөр Монгол Улсад 1044 иргэн донорын хүлээлгийн жагсаалтад байна. Энэ тоо ганцхан тохиолдолд буюу зөвхөн нас баралтаар буурдаг. Нэг амьгүй донор 8 хүний амь нас аврах боломжтой.Хуульд хүний эрхийн мэдрэмжтэй байх хүний эрхийг хөндөхгүй байх хамгаалалтуудыг эрх зүйн нөхцөлд маш сайн тусгаж өгсөн. Хүний эрхийн комиссоос 22 санал авсан, үүнийг хуулийн төсөлдөө 100% тусгаж өгсөн.



УИХ-ын гишүүн

Ж.Чинбүрэн:

Хууль батлагдсанаар эмч хүн бусдын амь нас аврах ажлаа хийсний төлөө гэмт хэрэгтэн болох асуудлыг хааж өглөө. Монгол хүн эрүүл болохын тулд гадаад улс руу орон байраа зарж явдаг үе ард хоцорч, хайртай хүнээ аврахын тулд эрүүл хүн эрхтнээ өгдөг биш амьгүй донороос авах боломжийг бүрдүүллээ. Үр шилжүүлэн суулгахтай холбоотой тодорхойгүй зохицуулалтуудыг нарийвчлан зохицуулж өгсөн.



Хүний гавъяат эмч

П.Батчулуун:

Манай улс амьгүй донороос эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг сүүлийн 2018 оноос эрчимтэй хөгжүүлж яваа. Хуулиар амьгүй донорын гэр бүлд тодорхой хэмжээний оршуулгын зардлыг шийдэж өгснөөр, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ нэмэгдэнэ гэж үзэж байгаа. БНСУ, БНТУ гээд манай улстай хамгийн ойр дотно ажилладаг энэ улс оронд амьгүй донорынхоо үйл ажиллагааг идэвхжүүлэх, ард олондоо тусламж дэмжлэг үзүүлэхийн тулд гэр бүлд нь оршуулгын зардал өгдөг юм байна.



УИХ-ын гишүүн

Н.Батсүмбэрэл:

Амьгүй донорын гэр бүлд тухайн донор эрүүл мэндийн даатгал төлж байсан эсэхээс үл хамааран хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний оршуулгын тэтгэмж Эрүүл мэндийг дэмжих сангаас олгох болно. Мөн иргэн бүр эрхтэн, эд, эсээ сайн дурааараа, үнэ төлбөргүй үлдээх сонголтоороо дамжуулан төрөөс ажуулгүй, шударга зохицуулалтаар хамгаалуулна.

Тухайн иргэн амьд сэрүүндээ өөрөө донор болох хүсэлтээ илэрхийлсэн тохиолдолд гэр бүлийнх нь гишүүдээс зөвшөөрөл авах шаардлагагүй. Одоогоор 6,500 иргэн донор болох хүсэлтээ илэрхийлж, үнэмлэхээ авсан байна. Харин амьгүй донороос эд эс, эрхтэн шилжүүлэхдээ гэр бүлийнх нь гурван гишүүнээс бичгээр зөвшөөрөл авах аж.



С.ЭРДЭНЭБОЛД
УИХ-ын гишүүн, Тогтоолын төсөл санаачилагч

“Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч байгаа системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын төсөл
Батлагдсан: 2026.04.29

МОНГОЛ УЛС ГЭМТ ХЭРЭГТЭЙ “КОММУНИСТ”-ААР ТЭМЦЭЖ ИРСНЭЭ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ “ТОГТООЛ” БАТАЛЛАА!

Эрүү шүүлттэй холбоотой асуудал бол хувь хүний гэхээс илүү системийн асуудал болчихсон нь нууц биш! Тэнд байгаа албан хаагчдыг чадавхжуулж, даргыг нь сольсон ч асуудал шийдэгддэггүй. Хорьж, мөрдөж, айлган сүрдүүлж, мэдээллийн дутмаг байдалд нь түшиглэн хэрэг тохдог, хэрэг хүлээлгэдэг “коммунист, фашист” аргаар Монгол Улс гэмт хэрэгтэйгээ тэмцэж байгаа нь тогтолцооны гажуудал гэдгийг нэр бүхий УИХ-ын гишүүд хэлж ирсэн. Тэгвэл Монгол Улсын Их хурал сүүлийн 36 жилийн хугацаанд анх удаа үүнийг хүлээн зөвшөөрч тогтоолын төслийг баталлаа. Гэхдээ уулын мод урттай, богинотой гэдэгчлэн хууль сахиулах байгууллагын зарим албан тушаалтан, алба хаагч бусдад эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий ханддаг ч нөгөө талд нь шударга албан хаагч олон байдгийг санах нь зүйтэй.



Эрүү шүүлтийн улмаас хохирсон иргэдтэй биечлэн уулзаж, хууль зүйн шинжилгээ хийв.

Нэг ёсондоо манай улс анх удаа “системийн шинжтэй хүний эрхийн зөрчил гэдэг үг, үсэг”-ийг тогтоолын төсөлд тусгав. Тодруулбал, 2024 оны 11 дүгээр сард Улсын Их хурал “Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” сэдвийн дор хяналтын сонсгол зохион байгуулсан. Үүнтэй холбогдуулан Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүй, эд хөрөнгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, нөхөн төлбөр олгох талаар судалж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хохирол барагдуулах үйл ажиллагааны тухай хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Уг ажлын хэсгийг УИХ-ын гишүүн С.Эрдэнэболд ахалж чуулганы нэгдсэн хуралдаанаар “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч байгаа системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн баталлаа.

Эрүү шүүлт гэдэг хөнгөн хэлэлцэх зүйл огт биш! С.Эрдэнэболд гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг эрүү шүүлттэй холбоотой асуудлаар хохирсон иргэдтэй биечлэн уулзаж, хэрэг тус бүрд шинжээч томилж тэдний дүгнэлтийг сонсож ажилласан нь эрүү шүүлтийн эсрэг үйл ажиллагаан дахь галыг өөртөө авч, зоригтой алхам хийснийг нь харуулна.



Ажлын хэсэгт

- 38 иргэнээс
- 21 хавтаст хэрэг, 2386 хуудас материал ирүүлсэнд хууль зүйн шинжилгээ хийж, бодлогын түвшинд шийдвэр гаргаж, арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзжээ!

Учир нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэг удаагийн бус дахин давтан үйлдэгддэг, тогтолцооны шинжтэй хүний эрхийн ноцтой зөрчлүүд илэрч, хөдөлшгүй баримтаар нотлогдсон тул УИХ бодлогын шийдвэр гаргаж, үе шаттай арга хэмжээ авах шаардлагатай юм.

Эрүү шүүлтээс сэргийлж, хүний эрхийг хамгаалах тогтоолд туссан зохицуулалт

- Иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийн баталгааг хангах;
- Цагдан хорих арга хэмжээний хэрэглээг хязгаарлах чиглэлээр нэн яаралтай арга хэмжээ авах;,
- Нотлох баримтын хууль ёсны стандарт, шалгуурыг чангатгах, прокурорын болон шүүхийн хяналтын хэрэгжилтэд чиглэсэн арга хэмжээ авах;
- Хохирогчийн эрх сэргээх, нөхөн төлбөрийн тусгай зохицуулалт бий болгох;.



УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн гишүүн
О.Номинчимэг:

Бидний авч хэлэлцсэн кэйсүүдийн 90% нь 2012-2016 онд гарсан хэргүүд. Тэр үед шударга бусын хонгил үгсрагдаж, системийн доголдол гарсан нь маш тодорхой болсон. Хүний амьдрал богино. Нэр төрөө сэргээж, үхэхдээ үр хүүхдүүддээ нэр цэвэр байхсан гэдэг тэдгээр хүмүүсийн хүслийг төр шуурхай шийдэх ёстой! Буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцож, нөхөн төлбөрийг нь гаргах ёстой.



УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн гишүүн
Х.Тэмүүжин:

Төр иргэнийг гэмт хэрэг хийхэд нь шалгаж чаддаг хэрнээ төрийн албан хаагчдын гэмт хэргийг шийдэж чаддаггүйн жишээ нь эрүү шүүлт! Энэ тогтоолын төслөөр Ерөнхий сайдад үүрэг даалгавар өгнө. Эрүү шүүлттэй холбоотой хар жагсаалт гаргадаг болох хэрэгтэй. Энэ гэмт хэргийн хохирогчид төрийн нэрийн өмнөөс хохирлыг нь барагдуулсан бол буруутай этгээдээр буцааж төлүүлж, гэмт хэргийг бие даан шалгадаг тусдаа байгууллагатай болох хэрэгтэй.


Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр
Батлагдсан огноо: 2026.04.02

АВСТРИ УЛСАД АМЬДАРЧ БУЙ ИРГЭД НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ ХОЁР УЛСАД ДАВХАР ТӨЛӨХӨӨС ЧӨЛӨӨЛӨГДЛӨӨ

Энэ хаврын чуулганаар Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээрийг баталлаа. Ингэснээр манай улс найм дахь улстайгаа нийгмийн хамгааллын хэлэлцээрийг байгуулж байна.



Нийгмийн хамгааллын хэлэлцээрийг байгуулсан улс



Энэ улс орнуудад нийт 92 мянга гаруй монгол иргэн ажиллаж, амьдарч байна.

Энэхүү хэлэлцээр хэрэгжсэнээр

Иргэд нийгмийн даатгалын шимтгэлийг хоёр улсад давхар төлөхөөс чөлөөлөгдөх, хоёр улсад ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн давхцаагүй хугацааг нэгтгэн тооцуулж,

Өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх үүсгэх,

Тухайн улсын хууль тогтоомжийн дагуу даатгалын шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэтгэврийг тогтоолгон авах боломж бүрдсэнээр тухайн хүний ирээдүйн нийгмийн баталгаа нь сайжрах юм.



УИХ-ын гишүүн
Х.Жангабыл:

Монгол Улс өнөөдөр найман улстай нийгэм хамгааллын хэлэлцээр байгуулаад ажиллаж байна. Энэ бол их сайшаалтай хэрэг. Цаашдаа ОХУ, БНСУ-тай хэлэлцээр байгуулах шаардлагатай байна. Тухайлбал, ОХУ-тай нийгэм хамгааллын хэлэлцээрийг 1981 онд байгуулсан. Цаг үеийн хувьд энэ хэлэлцээрээр цааш явахад шаардлага хангахгүй байгаа. БНСУ-д нэг сумын дайтай 50 мянган иргэн амьдарч байна. 2006 онд байгуулсан хэлэлцээрийг шинэчлэх шаардлага байна.



НДЕГ-ын дарга
Б.Батжаргал:

Хэлэлцээрийн үр дүнд гадаадад буй монголчуудын 35-38 орчим хувь нь нийгмийн даатгалын тогтолцоонд хамрагдсантай адил үйлчилгээ авах боломжтой болж байна. Гадаадад байгаа монголчууд нийгмийн даатгалд цахимаар даатгуулах боломж нь хуулиар нээлттэй болсон.Сүүлийн тоогоор 4-5 мянга орчим даатгуулагч гадаад улсаас Монгол Улсдаа даатгуулаад явж байна. Бусад улс орнуудтай хэлэлцээрт орох тусам гадаадад буй монголчуудын даатгалд хамрагдах хувь 50-60% болж өснө.

КАЗАХСТАН УЛСАД АЖИЛЛАЖ, АМЬДАРЧ БАЙСАН ИРГЭД ӨӨРИЙН УЛСДАА ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ БОЛОМЖ БҮРДЛЭЭ



Монгол Улсын Засгийн газраас манай улсын иргэд олноор оршин суудаг улстай нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг байгуулж, хоёр улсын иргэдийн нийгмийн харилцаанд харилцан тэгш эрхтэй байх, тухайн улсын иргэний нэгэн адилаар тэтгэвэр, тэтгэмж авах хууль эрх зүйн үндсийг бүрдүүлж ирсэн.

Энэ хүрээнд 2025 оны намрын чуулганаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр” 2026.04.01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн юм.

Хэлэлцээр хэрэгжсэнээр хоёр улсын иргэд Монгол Улс болон Бүгд Найрамдах Казахстан Улсад ажилласан, шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн өндөр насны тэтгэвэр тогтоолгох боломж бүрдэж байгаа юм.

Тодруулбал:

Монгол Улсын иргэн 1998 оноос өмнө Монгол Улс болон БНКУ-д ажилласан жилээ нэгтгэн тооцуулж, Монгол Улсаас өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах

Монгол Улсын иргэн 1998 оноос хойш БНКУ-д шимтгэл төлсөн бол шимтгэл төлсөн хугацаанд ногдох хуримтлалын тэтгэврийг БНКУ-аас тэтгэвэр авах

Казахстан Улсын иргэн 1998 оноос өмнө Монгол Улс болон БНКУ-д ажилласан жилээ нэгтгэн тооцуулж, Казахстан Улсаасаа өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах боломж бүрдэнэ.

Монгол Улсын нийгмийн даатгалд **18 жил** шимтгэл төлсөн, Бүгд Найрамдах Казахстан Улсад 1990-1998 онд нийт **8 жил** ажиллаж, даатгуулжээ. Иргэн А Монгол Улсад **18 жил** даатгалын шимтгэл төлсөн болон Казахстан Улсад 1998 оноос өмнө **8 жил** нийгмийн даатгалд хамрагдсан хугацаагаа нэгтгэн нийт **26 жил** шимтгэл төлснөөр тооцуулж, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.

60 настай
Монгол Улсын иргэн А

18 жил



8 жил



Казахстан Улсад

8000
гаруй монгол иргэн амьдарч буйн

3000
гаруй нь хөдөлмөрийн насныхан байгаа юм.



Ж.БАЯСГАЛАН
УИХ-ын гишүүн, Ажлын хэсгийн ахлагч

НЭГ ХҮНИЙ ХАНДИВЛАСАН ЦУС ГУРВАН ХҮНИЙ АМИЙГ АВРАХ БОЛОМЖТОЙ

Монгол Улсад 210 мянга гаруй донор хүний амь насыг аврах эрхэм үйлсэд нэгдэж байна.Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээллээр Цусны алба бүхий 171 улсаас 110 улс нь Цус сэлбэлтийн аюулгүй байдал, чанарыг зохицуулах тусгай хуультай байна.

Манай улсын хувьд хүн амын суваргын хэтийн төлөвөөр идэвхтэй донор (24-45 нас)-ын хүн амын тоонд эзлэх хувь буурахаар байгаа бөгөөд цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн тасралтгүй байдлыг хангах нь чухал асуудал болсон. Харин энэ хаврын чуулганаар Цусны донорын тухай хуулийн төслийг баталснаар олон эрэг үр дүн гарна гэж тооцоолж байна.

• Цус сэлбэлт судлалын салбарын эрх зүйн орчин улам боловсронгуй болж үүний хэрээр цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамж улам сайжирч, цус сэлбэлт судлалын салбар хөгжин дэвших шинэ боломжууд нээгдэнэ.


• Иргэд эх орондоо дэлхийн жишигт нийцсэн чанартай тусламж, үйлчилгээг хүртээмжтэй хүртэх боломж нэмэгдэнэ.

• Цус сэлбэлт судлалын үйл ажиллагааг зохицуулах удирдлагын тогтолцоо, үйл ажиллагаа шинэ шатанд гарна.

• Цусны донорын сургалт, сурталчилгаа, түүний дотор орон нутаг дахь үйл ажиллагаанд ахиц дэвшил гарснаар эрүүл аж төрөх ёсны талаарх ойлголт сурагч, оюутнаар дамжин өргөжнө.

• Цусны донор, сэлбүүлэгч, эмнэлгийн мэргэжилтэнд тавигдах шаардлага, тэдний эрх, үүрэг тодорхой болохын дээр тэдний нийгмийн халамж, алдаршуулалт, урамшуулал сайжирч, цусны донорын тоо нэмэгдэнэ.

• Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамж бүрэн шийдэгдэх нөхцөл бүрдэх аж.



Цусны донорын тухай хуулийн төслийг (2025.03.31) өргөн мэдүүллээ



УИХ-ын гишүүн
Ажлын хэсгийн ахлагч
Ж.Баясгалан:

Хүндэт донорт олгох цусны донор цол тэмдгийг өмнө нь ТББ олгодог байсан бол үүнийг ЗГ-ын шагнал болгон өөрчилсөн. Ингэснээр цусны донорыг хүндэтгэх тэдний хүмүүнлэгийн үйл ажиллагааг алдаршуулж байна. Цусны аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагааг хуулийн төсөлд тусгаж өгсөн бөгөөд донорын үйлсийг сурталчлах, алдаршуулах, байнгын донорыг тоог нэмэгдүүлэх, хүндэт доноруудад хүндэтгэл үзүүлэх цогц үйл ажиллагаа байдаг юм.



УИХ-ын гишүүн
Хуулийн төслийг санаачлагч
А.Ариунзаяа:

Цусаа өгсний дараа сийвэн 24 цагийн дотор, улаан эс 4-6 долоо хоногийн дотор бүрэн нөхөгддөг. Энэ үед цусны шинэ эсүүд эрчимтэй төлжиж эхэлдэг. Тогтмол цусаа өгөх нь бие дэх төмрийн илүүдлийг тэнцвэржүүлж, зүрх судасны өвчлөл, цус харвалт болон хорт хавдар тусах эрсдэлийг үлэмж хэмжээгээр бууруулдаг юм. Ялангуяа ковидын дараах энэ цаг үед маш олон залуучуудын цус өтгөрсөн. Үүнээс урьдчилан сэргийлэхэд цусаа өгч болох нь. Энэ нь нэг талдаа буян болохоос гадна таны эрүүл мэндэд ач тустай. Энэ хуулиар сайн дурын донорын хөдөлгөөнийг бодитоор дэмжих, доноруудаа алдаршуулах, цусны нөөцийн тогтвортой байдлыг хангах зэрэг олон боломж бүрдэнэ.

Монгол Улс 1939 онд анх цус сэлбэлтийн тусламж үйлчилгээ үзүүлж ирсэн,1963 оноос бие даасан нэгж анх байгуулагдсан, 2021 оны байдлаар 19,337 цусны донор бүртгэгдсэн. 7,837 донор тогтмол цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ бэлэглэж байна. 36 нэр төрлийн 103,265 нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 61,675 нэгж цус, цусан бүтээгдэхүүнийг эмнэлэгт олгоод байна.





Сангийн сайд З.Мэндсайхан, УИХ-ын гишүүн, хууль санаачлагч Н.Алтаншагай

Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хууль
Батлагдсан огноо: 2026.05.22

ИМПОРТЫГ ОРЛОХ 2 МЕГА ТӨСӨЛ ХУГАЦААНДАА БҮРЭН ХЭРЭГЖИХ БОЛОМЖ БҮРДЛЭЭ

2026 оны эхний 5 сарын байдлаар 2026 оны төсвийн алдагдлыг 1 их наяд төгрөг байхаар баталсан ч хэдийн 1.4 их наяд хүрч, орлого 800 тэрбум төгрөгөөр тасалдахын зэрэгцээ хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 15 хувьтай байгаа нь төсөвт тодотгол хийх хэмжээний эрсдэл учраад буйг эдийн засагчид сануулсаар байна. Иргэд үүнийг махны үнэ 50 хувь давсан өсөлтөөс “жинтэй” мэдэрч буй.

Гэсэн хэдий ч импортыг орлож, үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх чадамжтай, эдийн засгийн эргэлтийг сайжруулах, стратегийн ач холбогдол бүхий төслүүдээ зогсоож үл болох агуулга хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан нь бий.

Нөгөөтэйгүүр манай улсад төсөл хэрэгжүүлэхээр зээлсэн 13.8 их наяд төгрөгийн үлдэгдэл бий. Үүний 89 хувь нь 2026-2029 онд хэрэгжиж дуусах гэрээ, хэлэлцээртэй байгаа тул ирэх 3 жилд зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага ч үүсээд байв. Иймд дотоодын бензин, түлшний хэрэглээний 55 хувийг хангах Газрын тосны үйлдвэр болон баруун таван аймгийг эрчим хүчээр хангах Эрдэнэбүрэнгийн УЦС-ын төсөл бүрэн хэрэгжихэд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ 5.3 их наяд төгрөг бөгөөд үүнийг гадаад зээлийн эх үүсвэрээр шийдэхээр Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийг 2026 оны тавдугаар сарын 22-ны өдөр УИХ-аар батлууллаа.



Засгийн газар
1991 оноос хойш нийт
308 төсөл
арга хэмжээнд
33.4 их наяд
төгрөгийн төслийн
зээлийн хэлэлцээр
байгуулснаас өнөөдрийн
байдлаар
19.6 их наяд
төгрөгийн хөрөнгийг
ашиглаж
13.8 их наяд
төгрөгийн ашиглаагүй
үлдэгдэлтэй байна.



Газрын тосны үйлдвэр
Дорноговь аймагт баригдаж буй тус үйлдвэр нь жилд 1.5 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэж 1.0 тэрбум ам.долларын орлого олох бөгөөд импортын хараат байдлыг бууруулахаас гадна шатахууны үнийг бие даан, уян хатан зохицуулах боломж бүрдэнэ. 2028 оны I улиралд ашиглалтад орно.



Эрдэнэбүрэнгийн УЦС

Ховд, Баян-Өлгий, Увс аймгийн дөрвөн сумыг хамарсан 28000 га талбайд баригдах станц нь их ачааллын үед Төвийн эрчим хүчний системийг дэмжин ажиллах бөгөөд ОХУ-аас цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангасны төлбөрт жил бүр төлдөг 17.5 тэрбум төгрөгөөс хэмнэнэ. 2030 онд бүрэн ашиглалтад орно.



УИХ-ын гишүүн,
Ажлын хэсгийн ахлагч
Н.Алтаншагай:

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх анхдагч хуулийн төсөл санаачилсан ч УИХ дээр унасан. Гэсэн ч 2 том төслийг явуулахаар Засгийн газраас дахин оруулж ирснээр батлагдлаа. Авсан зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлж, мега төслүүдийн өгөөжийг ард иргэд бодитоор хүртэх үүд нээгдэж байна. "Сэлбэ дэд төв"-ийн төсөл хасагдсан ч цаашид Нийслэл дээр бүтээн байгуулалт зогсолтгүй үргэлжилнэ.



УИХ-ын гишүүн
М.Бадамсүрэн:

Мөнгийг нь шийдээд үйлдвэрээ барьчих юм байна. Харин түүхий тосоо дотоодын эх үүсвэрээр хангах асуудал орхигдоод байна. Бидэнд газрын тосоо олборлох төрийн өмчит олборлолт, хайгуулын компани алга. Үйлдвэрт шаардагдах түүхий тосыг дотоодын эх үүсвэрээс бүрэн хангах бодлогыг хэрэгжүүлэх Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг яаралтай хангаж ажиллая.



Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр ЕАЭЗХ-ны Худалдааны түр хэлэлцээр хүчин төгөлдөр болохтой холбогдуулж хамтарсан мэдэгдэлд гарын үсэг зурах үеэр

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээр.
Батлагдсан огноо: 2025.12.12

ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛЖ, ЭДИЙН ЗАСГИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ ЕВРАЗИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улс 2025 онд нийт 15.7 тэрбум ам.долларын экспорт хийж, гадаад худалдааны тэнцэл 4.4 тэрбум долларын ашигтай гарсан хэдий ч, эдийн засгийн гол тулгуур болсон зэс, нүүрс 2 нийт экспортын 74 хувийг бүрдүүлж, 70 хувийг нь БНХАУ дангаараа худалдан авсан хэвээр байна.

Иймд манай улс нэг эдийн засгаас хараат байдлыг бууруулах, экспортын зах зээлийг тэлж, төрөлжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх, худалдааг хөнгөвчлөх, хувийн хэвшил, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор ОХУ, Армени, Беларусь, Казахстан, Киргиз гэсэн таван улсаас бүрддэг Евразийн эдийн засгийн холбоотой худалдааны түр хэлэлцээрийг 3 жилийн хугацаатайгаар байгуулж чадлаа.

Евразийн эдийн засгийн холбоо нь нэгдсэн татварын тогтолцоотой, бусад гадаад улс орнуудтай хийх худалдаанд нэгдсэн нэг бодлогыг хэрэгжүүлдэг зарчимтай. Тухайлбал, импортоор орж ирэх бүтээгдэхүүнүүдэд 15-50 хувийн татвар ногдуулахаас гадна эрүүл ахуй, хорио цээр, техникийн өндөр шалгуур, шаардлагыг тавьдаг. Энэ нь Монгол Улсаас экспорт хийх боломжийг хязгаарлаад байв.

Харин хэлэлцээр байгуулснаар мах, арьс шир, ноос ноолуур зэрэг 367 нэр, төрлийн барааны экспортод тавих хязгаарлалт, мөн логистик, стандартын хаалтууд 10-15 хувь буурна. Нөгөөтэйгүүр, хүнсний салбарт элсэн чихэр, хуурай сүү, алим, хөөлгөгч зэрэг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн татваргүй орж ирснээр зах зээлийн үнэ багасах өндөр хүлээлттэй байна.

Хэлэлцээр байгуулахаас өмнө 15-50 хувийн татвартай байсан бүтээгдэхүүнүүд Евразийн зах зээлд татваргүйгээр гарах боломж бүрдэж байна.

29 мах, махан бүтээгдэхүүн

60 арьс ширний

204 ноос ноолуурын

65 хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн



Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал "Монгол Улс болон ЕАЭЗХ хоорондын худалдааны түр хэлэлцээр"-т гарын үсэг зурах үеэр, Минск хот, 2025.06.27

2025.06.27	2025.12.12	2026.02.09	2026.05.22	2026.07.22
Минск хотноо Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал "Монгол Улс болон ЕАЭЗХ хоорондын худалдааны түр хэлэлцээр"-т гарын үсэг зурав.	УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар тус хэлэлцээрийг соёрхон батлав.	ЕАЭЗХ-оос Монголын аж ахуйн нэгжүүд, бизнес эрхлэгчдэд зориулан зохион байгуулсан Худалдааны түр хэлэлцээрийн талаарх Бизнес хэлэлцүүлэг зохион байгуулав.	Худалдааны түр хэлэлцээр хүчин төгөлдөр болохтой холбогдуулж хамтарсан мэдэгдэлд гарын үсэг зурав.	Хэлэлцээр албан ёсоор хэрэгжиж эхэлнэ.



Монгол Улсын Ерөнхий сайд

Н.Учрал:

Монгол Улсаас Евразийн зах зээл рүү нийлүүлэх экспорт 24.2 хувиар нэмэгдэх тооцоолол гарсан. Тарифын болон тарифын бус зохицуулалтаас гадна бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хил гаалийн хүндрэлүүдийг бууруулах, хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Үр дүнд нь ААН-үүдийн үйл ажиллагааны зардал буурч, хөрөнгө оруулагчдын итгэл нэмэгдэхээс гадна иргэдэд хүрэх бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ буурч, хүртээмж сайжирна.



УИХ-ын гишүүн

М.Бадамсүрэн:

Эрсдэлтэй үеийн эдийн засгийн уналтыг Евразитай хийх худалдаагаар нөхөх боломжтой. 2024 оны байдлаар ЕАЭЗХ-ны гишүүн орнуудтай хийсэн худалдааны эргэлт 3.0 тэрбум ам.доллар байснаас нийт 2.8 тэрбум долларын алдагдалтай гарсан байна. Энэ алдагдал 367 төрлийн бүтээгдэхүүний экспортоор багасах, өмнөх оноос 39 хувиар унаад байгаа нүүрсний үнийн бууралт, уул уурхайн бүтээгдэхүүний ханшийн савлагааны эрсдэлтэй үед нээгдэж буй шинэ боломж юм.



Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль
Батлагдсан огноо: 2026.05.29

МОНГОЛЫН ТӨР АЛДААГАА ЗАСАЖ, МЯНГА МЯНГАН ЭЭЖҮҮДЭД МЭХИЙН ЁСОЛЛОО

Эх хүн аминаасаа амь ургуулж үрээ төрүүлдэг. Арван сар хэвлийдээ үрээ тээж төрүүлдэг эх хүний алдар ямар нэгэн цаг хугацаа, ямар нэгэн өөр хэмжүүрээр хэмжигдэх ёсгүй!

Хүний амьдралд зовлон жаргал, баяр гуниг ээлжилдэг. Хэвлийдээ тээж төрүүлсэн үр нь эндэх, ой ч хүрэлгүй орчлонгоос буцаж насан туршдаа шаналж, цөхөрч харуусаж яваа ээжүүд цөөнгүй бий. Эх хүн үрээ 1 нас хүрсэн, хүрээгүйгээр нь ялгаж хайрладаггүй шиг, төр ээжүүдээ ялгаварлаж яавч болохгүй. Иймд Монголын төр өнгөрсөн үеийн алдаагаа засаж, 1 нас хүрээгүй үрээ алдаж, одонгоо авч чадаагүй мянга мянган ээжүүддээ мэхийн ёсоллоо.

Тодруулбал, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нарын гишүүд хуулийн төслийг 2025.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн бөгөөд 2026.05.29-ний чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн батлагдлаа.

Одоо мөрдөж байгаа Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн зохицуулалтаар урамшуулал авах болзолд “бага хүүхэд нь 1 нас хүрсэн байх”, “нас барсан хүүхэд нь 1 ба түүнээс дээш настай байсан байх” зэрэг нөхцөл тавигдаж байгаа. Энэ нь хүний эрхийн зөрчил үүсгэж, хүүхдийг насаар нь ялгаварлан гадуурхах нөхцөл бүрдүүлсэн тул засах шаардлагатай гэж хууль санаачлагчид үзсэн юм.

Хууль батлагдсанаар 38 мянга гаруй эх шинээр одон авна



Монгол Улсад жил бүр дунджаар **75,000–80,000** хүүхэд шинээр мэндэлдэг



Нийт төрөлтийн **3-4** орчим хувьд хүүхэд **1** нас хүрэхээс өмнө нас барж, мөн тооны ээжүүд одон болон одонгийн урамшуулалд хамрагдаж чаддаггүй



Энэ нь ойролцоогоор жилд **2,500-3,000** эх хуулийн хязгаарлалтаас үүдэн тэгш эрхээ эдлэх боломжоо алдаж буй хэрэг



Хууль хэрэгжсэнээр Алдарт эхийн нэгдүгээр одон **10,154** ээж



Алдарт эхийн 2 дугаар одон **27,100** ээж авна гэсэн урьдчилсан тооцоо бий



УИХ-ын гишүүн, хууль санаачлагч
Д.Үүрийнтуяа:

Миний бие УИХ-ын эмэгтэй гишүүн, 5 хүүхэдтэй ээжийн хувьд хүүхэд, гэр бүл, эмэгтэйчүүдийн хөгжил, нийгмийн баталгааг дэмжих бодлогыг тууштай дэмжин ажиллаж ирсэн бөгөөд энэ хүрээнд "Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль"-ийг УИХ-ын гишүүдийн хамтаар санаачлан боловсруулж, УИХ-аар батлуулсан. Уг хууль нь 2027 оноос хэрэгжиж эхлэх бөгөөд өмнө нь 1 нас хүргэлгүй хүүхдээ алдсан шалтгаанаар одонгоо авч чадаагүй эхчүүд одонгоо авах боломжийг бүрдүүлсэн юм. Энэхүү хууль нь олон хүүхэдтэй эхчүүдийн нийгэмд гүйцэтгэж буй үүргийг өсгөж чадаагүй гэх үндэслэлээр ялгаварлахгүй байх, хүүхдийн эрхийн зөрчлийг арилгах, гэр бүлийн үнэ цэнийг дэмжих, хүүхэд өсгөн хүмүүжүүлэх хөдөлмөрийг бодлогын түвшинд үнэлэх, хүн бүр хуулийн өмнө тэгш эрхтэй байх зарчмыг хангах чухал ач холбогдолтой шийдвэр болсон гэж үзэж байна. Энэ хууль 2027 оны 1 сарын 1-ээс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

Хуульд орсон өөрчлөлт:

- Нэг нас хүрээгүй хүүхдээ алдсан эхчүүдийг урамшуулал, дэмжлэгт хамруулна
- Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхчүүдийг ялгаварлахгүй, урамшуулал олгох шалгуурыг хөнгөлнө.
- Төрөлтийг дэмжиж, өсөлтийг нэмэгдүүлнэ



Б.УЯНГА
УИХ-ын гишүүн, Ажлын хэсгийн ахлагч

ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ТӨРИЙН ХҮНД СУРТАЛ ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ТӨРИЙН ОРОЛЦОО 30 ОРЧИМ ХУВИАР БУУРНА

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль нь байгаль орчны чиглэлд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэнд чухал ач холбогдолтой хууль юм. Монгол Улсад өнөөдөр 110 гаруй үнэлгээ хийдэг тусгай зөвшөөрөлтэй компаниуд байдаг бөгөөд тэдгээр нь том, жижиг гэлтгүй бүх төсөл, хөтөлбөрүүдэд үнэлгээ хийдэг байсан юм. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багатай төслүүдээс эхлээд уул уурхай, хөдөө аж ахуй, эрчим хүчний салбарын томоохон төслүүдэд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээнүүдийг 150-200 орчим хоногийн хугацаанд хийдэг байсан нь аж ахуйн нэгжүүдэд хүнд суртал болдог байсан.

Энэ хууль нь байгаль орчны салбарын томоохон хуулиудын нэг. Хуулийн хүрээнд байгаль орчинд үзүүлж байгаагаа сөрөг нөлөөллөөр нь төсөл, хөтөлбөрүүдээ гурван зэрэглэлд ангилсан.

УИХ-ын гишүүн,
Ажлын хэсгийн ахлагч
Б.Уянга:

Засаглалыг сайжруулж, хүнд суртлыг арилгах чиглэлээр төрийн байгууллагуудын эрх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлсэн. Сум, дүүрэг, баг хорооны засаг даргын санал өгөх, хурлаа хуралдуулах хугацааг тодорхойлсон.Цахим шилжилт, мэдээллийн ил тод байдлыг хуульд тусгалаа. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний мэдэх эрхийг тодорхой болголоо.Байгаль орчны стратегийн үнэлгээг "Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлт"-тэй уялдуулан тухайн асуудал эрхэлсэн яаманд үүрэгжүүлсэн. Аливаа төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд мэдээлэл өгч, саналыг тусгах механизмыг тодорхой болголоо.

Гуравдугаар зэрэглэлд

Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь бага атлаа нарийвчилсан үнэлгээг хийлгэх гэж 2-3 жил саатдаг байсан төслүүд хамаарч байгаа юм. Эдгээр төслүүдэд автомашины зогсоолууд, төвийн шугамд холбогдсон үйлчилгээний төв, авто угаалга, үсчин, гоо сайхан, рентген аппаратууд ашигладаг эмнэлэг, эмийн сан, их, дунд, их, дээд, дунд сургууль, алт мөнгөний дархан, гар урлалын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдүүд хамаардаг. Хуулийн хүрээнд эдгээр үйл ажиллагааг эрхлэхэд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд иргэн, хуулийн этгээд мэдэгдэл өгснөөр үйл ажиллагаагаа эхлэх эрхийг нь олгож байна.

Хоёрдугаар зэрэглэлд

Аймаг, нийслэлийн засаг даргын хэмжээнд нь байгаль орчны ерөнхий үнэлгээ нь хэлэлцэгдээд ажил нь эхлэх төслүүдийг хамааруулах зохицуулалтыг тусгасан. Гэхдээ Байгаль орчны газраараа дамжуулаад салбарын яам нь ерөнхий хяналтаа тавих, эрх хэмжээ нь хэвээрээ үргэлжилж байгаа.

Нэгдүгээр зэрэглэлд

Хамаарах төслүүдийн хувьд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хүрээнд ерөнхий, нарийвчилсан үнэлгээгээ хийлгээд салбарын яам нь эцэслэн шийдвэрлэдэг зохицуулалт хэвээр үлдсэн.



УИХ-ын гишүүн,
Хууль санаачлагч
С.Одонтуяа:

Хууль тогтоомжийн давхардал, хийдэл зөрчлөөс чөлөөлөх чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр гарсан нөхцөл байдлыг хянан үзээд зарим шаардлага тодорхойгүй, бичиг баримтын бүрдлийн ангилал ойлгомжгүй, давхацсан шинжтэй, үүрэг хариуцлагын зохицуулалт тусгагдаагүйн улмаас хууль хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэлийг арилгах үүднээс зарим хэсэг, заалтыг шинээр нэмж зарим хэсэг заалтыг өөрчлөн найруулаа.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль нь нийт 124 заалттай бөгөөд нийт хуулийн эх бичвэрт 19 хэсэг, 6 заалтыг нэмж тусган, 12 хэсэг 3 заалтыг өөрчлөн найруулж нийт хуулийн 48 заалт буюу 38.4%-д нэмэлт, өөрчлөлт оруулсан.

БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭГ ХЯНАЖ БАТЛАХ ДУНДАЖ ХУГАЦАА

ХУУЧИН ХУУЛИАР
150-200
ХОНОГ

ШИНЭ ХУУЛИАР
43
ХОНОГ
БОЛЖ

65%
БУУРУУЛЛАА



“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын төсөл
Батлагдсан огноо: 2026.06.04

ТӨСӨВТ ӨРТӨГ НЬ УДАА ДАРАА НЭМЭГДСЭН ТӨСЛҮҮДИЙГ ЦААШИД САНХҮҮЖҮҮЛЭХГҮЙ!

2026 оны төсвийн төсөлд нийт 579 төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр тусгасны 2.0 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 136 төсөл, арга хэмжээний анх батлагдсан төсөвт өртөг нь 805.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн!

Улмаар Монгол Улсын 2024, 2025 оны улсын төсөв, 2026 оны төсөвт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр тусгасан нийт төсөл, арга хэмжээний давхардлыг ангилан үзэхэд 2010 оноос хойш төсвөөс санхүүжүүлсэн 522 төсөл, арга хэмжээний анх батлагдсан төсөвт өртөг 2026 оны байдлаар 1.9 их наяд төгрөгөөр нэмэгдсэн дүнтэй байгаа юм!

Энэ нь улсын төсөвт ихээхэн хэмжээний дарамт үзүүлж, төсвийн хөрөнгө оруулалтын бодлогыг алдагдуулахын зэрэгцээ цаашид төсвийн хөрөнгө оруулалтаар нийгэм, эдийн засгийн олон үр дүнтэй төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх боломжийг хязгаарлаж, өмнөх төслүүдийн нэмэгдсэн дүнг санхүүжүүлэхэд зарцуулж буй байдлыг залруулах шаардлага үүссэн тул төслийг боловсруулав.

Энэхүү тогтоолын төсөл нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсөвт өртгийн үндэслэлгүй өсөлтийг бууруулах, зогссон болон үр ашиггүй төслүүдийг эрэмбэлэх, төлөвлөлт болон шийдвэр гаргалтыг ил тод, өгөгдөлд суурилсан болгох, төсвийн сахилга бат, хариуцлагыг бэхжүүлэх зорилготой юм.



Тогтоолын төсөл батлагдсанаар:

- Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй бүх хөрөнгө оруулалтын төслийг УИХ, Засгийн газар нэг хавтгай дээр буулгаж харах боломж бүрдэнэ;
- Бүх төслүүдийг эрэмбэлж, нэн шаардлагатай төслийг санхүүжүүлнэ;
- Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын нэгдсэн систем бий болно;



УИХ-ын гишүүн,
Тогтоолын төсөл санаачлагч

Б.Пунсалмаа:

Монгол Улсын Засгийн газар "чөлөөлөх" уриа дэвшүүлсэн. Энэ хүрээндээ төрийн хүнд суртлаас хувийн хэвшлийг чөлөөлье гэж ярьж байгаа. Үүний тулд улсын төсөв, хөрөнгө оруулалт нь цөөн бас чанартай байх ёстой. Иймээс 2027 оны улсын төсвийг хэмнэлттэй, шинэлэг зарчмаар баталж, ужиг хуучин төслүүдээсээ зориггой салж, улмаар онц шаардлагатай төсөл арга хэмжээ рүү төсвийг чиглүүлэхийн тулд уг тогтоолын төслийг яаралтайгаар оруулж ирсэн.



УИХ-ын гишүүн

Б.Мөнхсоёл:

2010 оноос одоог хүртэл хэрэгжиж дуусаагүй барилгын асуудлыг шийдэх шаардлагатай. Зөвхөн Улаанбаатарт биш орон нутагт ч дуусаагүй барилга, эзэнгүйдсэн хөрөнгө үнэхээр тулгамдсан асуудал болоод байна! Анх оруулж ирсэн төсөвт өртөг нь явцын дундаа "хөрөнгө мөнгө хүрсэнгүй, инфляц орлоо, барилгын материалын үнэ өслөө" гэх зэрэг олон шалтгаанаар өртөг нь нэмэгддэг. Энэ асуудлыг цэгцлэхэд уг тогтоолын төсөл маш өндөр нөлөөтэй. Ер нь төсвийн сахилга батыг бий болгохын тулд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бий болсон. Мөн Үндэсний Аудитын газар ч гэж байгаа. Иймд Улсын Их хурал дээр гаргаж буй тайлангуудыг сайтар уншаад хариуцлагатайгаар зөвлөмжүүдийг хэрэгжүүлдэг байх ёстой. Тэгэхээр энэ тогтоолын төслийн ач холбогдлыг төсвийн сахилга бат алдагдаж, хариуцлагын механизм байхгүйгээс үүдсэн ужгирчихсан олон том асуудлыг цэгцэлнэ гэж харж байна.



БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭЭ ТАТВАРЫН ДАРАМТААС ЧӨЛӨӨЛНӨ

Олон улсын эдийн засгийн хурцадмал байдлаас үүдэлтэйгээр эдийн засгийг идэвхжүүлэх, хувийн хэвшил, бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдээ дэмжих зорилгоор Татварын багц хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар Засгийн газраас /2026.05.07/-ны өдөр өргөн мэдүүлж энэ хаврын чуулганаар батлагдсан. Хууль 2027.01.01-ний өдрөөс хэрэгжиж эхлэх юм. Чөдөр тушааг чөлөөлөх “ЧӨЛӨӨЛЬЕ” санаачилга хэрэгжсээр байна.

ХХОАТ дээр
3.6
их наяд төгрөг

ААНОАТ дээр
246
тэрбум төгрөг

НӨАТ дээр
181
тэрбум төгрөг.



УИХ-ын гишүүн,
Ажлын хэсгийн ахлагч
Х.Ганхуяг:

Татварын хуулийг шинэчлэх ажлын хэсгийн ахлагчийн хувьд иргэн, ААН-ийн татварын дарамт, ачаалал, хувь хэмжээг бууруулахад анхаарч ажиллалаа. Иргэд, ААН-д ирэх татварын дарамтыг 4.1 их наяд төгрөгөөр бууруулах тооцоолол хийсэн.

792.000
төгрөг хүртэл цалингийн хувь хүний орлогын албан татвар тэглэгдлээ.
2027.01.01-ээс
хэрэгжинэ.

792.000-аас
2 сая төгрөг хүртэл цалингийн хувь хүний орлогын албан татвар 1% боллоо.
2028.01.01-ээс
хэрэгжинэ.

НӨАТ төлөгчийн босгыг
50 сая
төгрөгөөс
400 сая
төгрөг болгон нэмэгдүүлэв



Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
Батлагдсан: 2026.06.18

ҮЛ ХӨДЛӨХ БОРЛУУЛСНЫ 2% ТАТВАР ХҮЧИНГҮЙ БОЛЛОО

Татварын багц хуулийн төслийн хүрээнд хувь хүний орлогын албан татварт хоёр шатлал нэмэх юм. Ингэснээр иргэдийн гар дээр очих цалин нь нэмэгдэнэ гэсэн үг. ХХОАТ-ын шаталсан татварын тогтолцоо хэрэгжсэнээр иргэдийн орлогын хэсэг бүрд өөр өөр шатлалын татвар тооцогдоно.

ХХОАТ-ын хуулийн шинэчлэл

Хэрэгжих хугацаа 2027.01.01

- Сарын 792 мянган төгрөг хүртэлх орлогод 0% татвар
- Тусгай хамгаалалттай бүс нутгаас бусад байршил дахь орон сууцаа худалдвал 2 хувийн татвараас чөлөөлөгдөнө.

Шаталсан татварын тогтолцоо

Хэрэгжих хугацаа 2028.01.01

- 792 мянгаас 2 сая төгрөг хүртэлх орлогод 1% татвар шаталсан татварын тогтолцоо:
- 2 саяас - 10 сая хүртэлх орлогод 10% татвар
- 10 саяас - 15 сая хүртэлх орлогод 15% татвар
- 15 саяас - дээш орлогод 20% татвар



Сангийн сайд
З.Мэндсайхан:

ХХОАТ-ын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр сарын 792 мянган төгрөг хүртэлх орлоготой иргэд татваргүй, 792 мянгаас 2 сая төгрөгийн орлоготой иргэд ердөө 1 хувийн татвар төлнө. Цалингийн орлоготой 1,031,743 иргэний 57 хувь нь 1 хүртэл хувийн татвартай болно.

ТАТВАРЫН ӨРТЭЙ БОЛ ДАНС ХААЖ, ХӨРӨНГИЙГ 100 ХУВЬ ХУРААДГИЙГ БОЛИУЛНА

Хуулийн шинэчлэл 1

Өнөөдрийн мөрдөж буй зохицуулалтаар татварын өр үүссэн тохиолдолд аж ахуйн нэгжийн данснаас хөрөнгийг 100 хувь суутган авч, дансыг нь хаан үйл ажиллагааг нь доголдуулж байгаа. Тэгвэл уг хуулийн шинэчлэлд татварын өр барагдуулах зохицуулалтыг илүү уян хатан болголоо. Ингэснээр татварын өр барагдуулах үйл ажиллагаа үргэлжлэхийн сацуу аж ахуйн нэгжүүд үндсэн үйл ажиллагаагаа бүрэн зогсоохгүйгээр хэвийн үргэлжлүүлнэ.

Байгууллагын данснаас **70** хувийг татварын өрийн орлого татан төвлөрүүлэхэд авч, **30** хувийг тухайн аж ахуйн нэгжийн дансанд үлдээнэ;

Хуулийн шинэчлэл 2

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиар 0-6 тэрбум төгрөгийн орлоготой аж ахуйн нэгжүүд 15 хувийн татвар төлж буй бол дундын шатлалыг нэмснээр 6-10 тэрбум төгрөгийн орлоготой аж ахуйн нэгжүүд 15 хувиар татвар төлөх юм. Үүний үр дүнд 180 мянга гаруй аж ахуйн нэгж татварын дарамтаас чөлөөлөгдөнө.

6-10 тэрбум төгрөг хүртэлх ашигт **15%**-ийн татвар ногдуулж, татварын ачааллыг бууруулна;
Борлуулалтын орлого нь **2.5** тэрбум төгрөг хүртэлх бүх аж ахуйн нэгж **1%** хувийн татвар төлнө;

Хуулийн шинэчлэл 3

Татвар төлөгчид алдаа, зөрчлөө өөрөө залруулах боломжийг олгох үүднээс татварын тайлан залруулах хугацааг сунгана.

Татварын тайлан залруулах хугацаа **1** жил байгааг **2** жил болгон сунгаж, алдангийн дээд хэмжээг **50** хувиар тогтооно;



НӨАТ-ЫН БОСГЫГ 400 САЯ БОЛГОСНООР 23 МЯНГАН ААН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРАА ХАДГАЛЖ ҮЛДЭНЭ

Орлого нь 50 саяас давахаар албан журмаар НӨАТ суутган төлөгч болж, өндөр татвар төлөх ачааллаас үүдэн бизнесээ хаах эсвэл орлогоо нуух эрсдэл үүсдэг.

Иймд нэмэгдсэн өртгийн албан татварын (НӨАТ) шинэчлэлээр одоогоос 11 жилийн өмнө тогтоосон 50 сая төгрөгийн босгыг үнийн өсөлттэй холбоотойгоор 400 сая болгон нэмэгдүүллээ. Ингэснээр 23 мянга аж ахуйн нэгж НӨАТ-ын тайлагналын хүнд суртлаас чөлөөлөгдөж, бизнесээ өргөжүүлэхэд анхаарах боломжтой болж байна.

Мөн орлого нь бүрэн орж ирээгүй байхад НӨАТ төлөх шаардлагатай болдог нь ААН-үүдэд тулгардаг том бэрхшээлүүдийн нэг юм. Иймд импортын барааны мэдүүлэгч хүсэлт гаргасан тохиолдолд татвар төлөх хугацааг 2 хүртэлх сараар хойшлуулахаар зохицууллаа.



Монгол Улсын Ерөнхий сайд
Н.Учрал:

Орлого нь 50 саяд хүрчихээр хамаарал бүхий иргэд, гэр бүлийнхэндээ хуваарилж жижиглээд байгаа юм. Энэ босгыг 400 сая болгон нэмэгдүүлснээр жижиглэх асуудал байхгүй болж хуулийн дагуу НӨАТ-аа төлөөд явна. Далд эдийн засгийг дэмжинэ гэсэн шүүмжлэлд И-Баримтаар бүгдийг нь бүртгэж 100 хувь буцаан олгох боломж бий гэж хэлмээр байна.



УИХ-ын гишүүн
М.Бадамсүрэн:

Орлого нь 50 саяд хүрчихээр хамаарал бүхий иргэд, гэр бүлийнхэндээ хуваарилж жижиглээд байгаа юм. Энэ босгыг 400 сая болгон нэмэгдүүлснээр жижиглэх асуудал байхгүй болж хуулийн дагуу НӨАТ-аа төлөөд явна. Далд эдийн засгийг дэмжинэ гэсэн шүүмжлэлд И-Баримтаар бүгдийг нь бүртгэж 100 хувь буцаан олгох боломж бий гэж хэлмээр байна.

CENTRAL TOWER

A PRESTIGIOUS ADDRESS IN THE CITY HEART

Их хотын зүрхэнд байрлах бизнесийн хамгийн таатай байршил

ТӨВИЙН ҮНЭ ЦЭНТЭЙ БАЙРШИЛ
Улаанбаатар хотын төв хэсэгт, Монгол Улсын Засгийн Газрын ордон, тер. захиргааны байгууллагууд, элчин сайдын яамдууд, үзвэр үйлчилгээ болон томоохон худалдааны төвүүдтэй зэргэлдээ байрлалтай.

НЭГ ДОР ТӨВЛӨРСӨН ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ
1-3 давхарт байрлах Central Mall нь олон улсын болон дотоодын худалдаа, үйлчилгээний байгууллагуудыг нэг дор цогцлоон бүрдүүлсэн.

ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН 8 БАЛЛД ТЭСВЭРТЭЙ ХИЙЦЛЭЛ
Барилгын инженерийн төрөл шиидэл бүхий удирдлагын нэгдсэн систем, барилгын найдвартай чанарыг өндөр түвшинд хангасан.

PM2.5 АГААР ШҮҮГЧ СИСТЕМ
Нарийн ширхэгт тоосонцрыг үр дүнтэй шүүн, цэвэр агаараар салгах агааржуулалт, салхижуулалтын нэгдсэн системийг барилгын бүх хэсэгт бүрэн нэвтрүүлсэн.

24/7 БАРИЛГЫН МЕНЕЖМЕНТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
Түрээслэгч бүрийн тав тух, аюулгүй байдлыг хангах 24 цагийн харуул хамгаалалт, инженер техник болон хөрөнгийн менежментийн үйлчилгээ.

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ
Галын аюулгүй байдлыг дээд түвшинд хангасан автомат бороохүүлэлтийн систем, утаа, дулаан болон хий мэдрэгч, аварын шатны утаагүйжүүлэх цэвэр агаарын систем, дотоод зарлан мэдээллэх системээр тоноглогдсон, дотоодын болон олон улсын стандартыг бүрэн хангасан.

БҮРЭН АВТОМАТЖУУЛСАН ХӨРГӨЛТ, ХАЛААЛТЫН СИСТЕМ
Жилийн дөрвөн улиралд тогтвортой, тав тухтай дотоод орчныг бүрдүүлсэн.

НӨӨЦ ЦАХИЛГААН ҮҮСГҮҮР
Цахилгаан тасарсан үед барилгын үндсэн системүүдийг тасралтгүй хэвийн ажиллуулах найдвартай нөөц шийдэл.

Limited OFFICE SPACES NOW AVAILABLE

Хотын А зэрэглэлийн бүсэд байрлах Central Tower нь таны бизнесийн амжилтыг баталгаат, дээд зэрэглэлийн, орчин үеийн оффисын орон зайг Улаанбаатар хотын төв цэгт санал болгож байна.



Оффисын түрээсийн албатай холбогдох
9597-7770, 8810-3271, 8013-1445

Central Tower
centraltower.mn